



**МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛ**

ШҮҮХИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

(Харьцуулсан судалгаа)



Улаанбаатар хот

2023



ШЕЗ-ийн Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу гүйцэтгэсэн “Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал”
харьцуулсан судалгаа

Зөвлөхөөр ажилласан: Хууль зүйн доктор, профессор Б. Өлзийсайхан

АГУУЛГА

АГУУЛГА.....	ii
Товчилсон үгсийн жагсаалт	iv
Хүснэгт, график, зургийн жагсаалт.....	v
Хүснэгтийн жагсаалт v	
Графикийн жагсаалт v	
Зургийн жагсаалт v	
УДИРТГАЛ.....	6
Судалгааны зорилго 7	
Судалгааны арга 7	
Судалгааны хүрээ 7	
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	8
Бүлгийн танилцуулга.....	8
1.1. Шүүхийн санхүүжилтийн талаарх хууль тогтоомжийн зохицуулалт 8	
1.2. Анхан болон давж заалдах шатны шүүхийн төсвийн өнөөгийн байдал 17	
1.3. Шүүхийн төсвийн хүрэлцээтэй байдал ба тулгамдаж буй асуудал 25	
Бүлгийн дүгнэлт	35
ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮХИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ	36
Бүлгийн танилцуулга.....	36
2.1. Гадаадын зарим улсад шүүхийн санхүүжилтийг төсөвлөж байгаа өнөөгийн загвар 39	
Финланд Улс.....	39
Эстони Улс	41
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс.....	42
Оросын Холбооны Улс	44
Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	45
2.2. Дэлхийн бусад улс орнуудын онцлох туршлага болон олон улсын байгууллагуудын зөвлөмж 50	
Бүлгийн дүгнэлт	54
СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ	57
СУДАЛГААНЫ САНАЛ	61
Салбарын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар: 61	
Гүйцэтгэл болон үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжихэд дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар: 61	
СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	63
Монгол хэл дээрх эх сурвалж: 63	
Гадаад хэл дээрх эрх сурвалж: 65	
Англи хэл дээрх эх сурвалж:	65
Орос хэл дээрх эх сурвалж:.....	66



Товчилсон үгсийн жагсаалт

ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИБУИНВУ, Их Британи	Их британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс
УИХ	Улсын Их Хурал
ШЭЗБтХ	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БЗД	Баянзүрх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
АШШ	Анхан шатны шүүх
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АИХ	Ардын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага

Хүснэгт, график, зургийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь, 1994-2002 он	10
Хүснэгт 2. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь, 2003-2012 он	11
Хүснэгт 3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв, 2013-2021 он.....	13
Хүснэгт 4. Шүүхийн бие даасан байдал.....	15
Хүснэгт 5. Хандив, тусламжийн талаар мэдээлэл /мянган төгрөг/	17
Хүснэгт 6. Орон нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг /мянган төгрөг/	19
Хүснэгт 7. Шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлого /мянган төгрөг/	20
Хүснэгт 8. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж буй шүүх	30
Хүснэгт 9. Прокурорын байгууллагуудтай нэг байранд үйл ажиллагаагаа явуулж буй шүүх..	31

Графикийн жагсаалт

График 1. ШЕЗ-өөс оруулсан шүүхийн төсвийн төслийг үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлсэн зохицуулалт шаардлагатай эсэх.....	15
График 2. Шүүхийн төсөв, шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо ба улсын тэмдэгтийн хураамжийн мэдээлэл, 2014-2021 он.....	18
График 3. ШЕЗ-ийн 2022 оны төсөв	21
График 4. ШЕЗ-ийн 2022 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал	22
График 5. ШЕЗ-ийн 2023 оны төсөв	23
График 6. ШЕЗ-ийн 2023 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал	23

Зургийн жагсаалт

Зураг 1. Шүүх хуралдааны танхим	32
Зураг 2. Шүүх хуралдааны танхимын багтаамж, хүн хоорондын зай талбай	32
Зураг 3. Хөгжлийн банканд хамааралтай нэр бүхий 84 шүүгдэгчид холбогдох шүүх хурал ...	33

УДИРТГАЛ

Монгол Улс 1992 оны Үндсэн хуульд анх удаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн суурь үзэл баримтлалыг бэхжүүлснээр дэлхий нийтийн жам ёсны хандлагаар ардчилал, зах зээлийн шинэ нөхцөлд зохицон хөгжих нийгмийн амьдралын бүхий л хүчин зүйлсийг өөрчлөн шинэчлэх үндсийг бүрдүүлж, шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан статустайгаар аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлэх баталгааг Үндсэн хуулийн “Төрийн байгуулал” гэсэн Гуравдугаар бүлгийн 4 дэх хэсэг, түүнчлэн шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангах захиргааны байгууллага болон шүүхийн санхүүжилтийн талаарх суурь зарчмыг Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалтаар шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлэх хийгээд шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах үүрэгтэй байх зэрэг шинэ механизм, зарчим тогтоож¹ өгсөн байна. Энэхүү суурь зарчмыг салбарын болон холбогдох хууль тогтоомжид хуулбарлан, зарим зохицуулалтыг судалгааны санал, зөвлөмжийн үр дүнд үндэслэн нарийвчлан тусган, хэрэгжүүлж ирсэн байна. Шүүхийн эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн ерөнхий зохицуулалт өнөө хир нь тунхаглалын шинжтэй байгаа ч шүүхийн захиргааны байгууллага болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг дотоод, гадаадын байгууллагууд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын голлох баталгааны хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нь шүүхийн төсвийн хүрэлцээгүй байдал бөгөөд үүнээс үүдэлтэй хүндрэл бэрхшээлийн талаар цөөнгүй судлан үзэж, санал зөвлөмж өгч ирснийг дурдах учиртай.

Монгол Улс Шүүхийн тухай хуулиа 1993, 2002, 2012 онд тус тус шинэчлэн баталж, хэрэгжүүлж ирсэн бөгөөд тухайн хууль тус бүрийн хүчин төгөлдөр үйлчилсэн цаг хугацаанд шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд дорвитой алхам хийх санал санаачилга гарч, салбарын хуульд зарим зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан ч хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөлөлд буй шүүхийн санхүүжилтийг бусад эрх мэдлийн санхүүжилтийн дараагийн эрэмбэд байршуулдаг, санхүүжилт хүрэлцээгүй байдал хэвээр үргэлжилсээр иржээ.

Шүүхийн санхүүжилт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахуйц хүрэлцээтэй байдлаар бодитой, ил тод төсөвлөгдөж, батлагдах процесс ч мөн адил ил тод аль нэг эрх мэдлийн өмнөх хэвшсэн ойлголт дур зоргын нөлөөгүй батлагдах учиртай. Энэхүү нөхцөл байдлыг судлан үзэж, шүүхийн санхүүжилтийн загварыг шинэчлэх аль болох бүрэн хэрэгжихүйц хувилбарыг эрх мэдлийн онцлогийг харгалзан сонгон судлах, өөрийн орны зарим үйлчилгээний салбарт туршин хэрэгжүүлж буй санхүүжилтийн загвартай харьцуулан жиших хүрээнд гадаадын зарим улс тухайлбал, Финланд, Эстони, Их Британи Улс, ОХУ, БНХАУ-ын шүүхийн санхүүжилт, тэдгээрийн манай улсын шүүхийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтаас онцлог зохицуулалтыг судлан, харьцуулан үзэж зарим туршлагыг дагнан судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохыг зорьсон болно.

Шүүхийн эдийн засгийн баталгааг төр хангах энэхүү зарчмын хэрэгжилтийг хангахын тулд Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн тухай 2021 оны хуульд заасан чиг

¹ Чимид, Б. (2017) Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 265 дахь тал.

үүргийн дагуу шүүхийн төсвийн хүртээмжтэй, үр нөлөөтэй байдлыг бэхжүүлснээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын 5.1 дэх зорилтын 2021-2030 оныг хамрах I үе шат дахь “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шүүхийн төсвийн зүйл заалтын буюу уламжлалт (аажмаар өсөх төсөвлөлт²) төсөвлөлтийн загварын давуу болон сул талыг хууль зүйн зохицуулалтын хүрээнд дүгнэх, түүнчлэн гадаадын зарим улсын шүүхийн төсөвлөлтийн туршлагыг харьцуулан судалж, хэрэгжүүлэх боломжтой төсөвлөлтийн загварыг санал болгох зэрэг үндэслэлээр энэхүү судалгааг захиалагч талын ажлын даалгаврын хүрээнд 2 бүлэг, 5 дэд зүйл, бүлэг тус бүрийн дүгнэлт болон нэгдсэн дүгнэлт гэсэн бүтэцтэйгээр гүйцэтгэсэн болно.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн (анхан, давж заалдах шатны) санхүүжилтийг гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжүүлэх боломжийг судлан, гадаадын зарим улсын шүүхийн санхүүжилтийн загвар хоорондын шилжилт болон өнөөгийн байдалд харьцуулалт хийж шүүхийн санхүүжилтийг боловсронгуй болгоход чиглэсэн санал, дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны арга

“Шүүхийн санхүүжилтийн зарим асуудал” судалгааны ажлыг гүйцэтгэхэд баримт бичиг шинжлэх, харьцуулан судлах болон тоон болон чанарын аргыг тус тус ашигласан болно.

Судалгааны хүрээ

Судалгаанд Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн (анхан болон давж заалдах шатны) санхүүжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тул 1994-2023 оны улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь, шүүхийн төсвийн төсөл болон батлагдсан төсвийн харьцуулалт, гадаадын зарим улсын шүүхийн төсөвлөлтөд туршигдан хэрэгжиж буй төсвийн загварыг судлан, гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэхэд судлан шийдвэрлэх зарим асуудлыг тодорхойлно. Ингэхдээ дэлхийн бусад улс орнуудын бий болгосон туршлага болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг харьцуулан судална.

² Дэлхийн улс орнуудад шүүхийн төсөвлөлтийн хамгийн нийтлэг 1) Тэгд суурилсан төсөвлөлт, 2) Аажмаар өсөх төсөвлөлт, 3) Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт хэрэгжиж байна. Судалгааны ажлын хоёрдугаар бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Бүлгийн танилцуулга

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэж заасан суурь зарчмыг баталгаажуулан Шүүхийн тухай 1993, 2002 оны хууль, 2012 оны Шүүхийн багц хууль, Шүүхийн тухай 2021 оны хуулиар санхүүжилтийн процессыг бэхжүүлж, төрийн төсөв, санхүүгийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна.

Шүүхийн төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ирсэн тогтолцоог халж, улсын нэгдсэн төсвөөс санхүүжүүлэх болсон нь шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн Үндсэн хуулийн суурь зарчмыг Шүүхийн тухай хуулиудын нарийвчлан, тодотгон хуульчлах шаардлага үүссэн.

Шүүхийн тухай 1993, 2002 оны хуульд шүүхийн санхүүжилтийн талаарх Үндсэн хуулийн суурь зарчмыг бүхэлд нь хуулбарлан хуульчилж шүүхийн төсвийн төслийг боловсруулах чиг үүргийг ШЕЗ хэрэгжүүлэн, Засгийн газар тухайн эрх мэдлийн төсвийг хянаж, улсын төсөвт нэгтгэн, УИХ төсвийг баталж ирсэн дээрх хугацаанд шүүхийн өр төлбөр, шүүхийн төсвийн улсын төсөвт эзлэх хувь хэмжээг төсвийн жилээр судлан үзсэн.

Шүүх тухай 2012 оны багц хуулийн хэрэгжилтийн хугацаанд шүүхийн санхүүжилтийн талаарх зохицуулалтыг нарийвчлах оролдлого хийж, тодотгосон дэвшилтэт зүйл, хэсэг, заалтыг хуульчилсан хэдий ч хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хөндлөнгийн нөлөөлөл, шахалт үргэлжлэн шүүхийн эдийн засгийн баталгааг бэхжүүлэх шинэлэг зохицуулалтыг хүчингүй болгосон.

Шүүхийн тухай 2021 оны хууль нь 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд буюу өмнө нь багц хуулиар зохицуулж байсан харилцааг нэгтгэн үзэл баримтлалын хувьд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахуйц харилцааг нэгтгэн зохицуулж, шүүхийн санхүүжилтийн талаарх багц хуулийн бүрэн хэрэгжиж үр дүнд хүрээгүй хүчингүй болгуулсан зохицуулалтыг дахин тодотгон хуульчилж, 3 дахь төсвийн жилдээ хэрэгжүүлж байна. Шүүхийн санхүүжилт сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд бие даасан эрх мэдлийн хүрээнд хүрэлцэхүйц байгаагүй бөгөөд өнөөдөр ч тулгамдаж буй асуудал хэвээр байна.

1.1. Шүүхийн санхүүжилтийн талаарх хууль тогтоомжийн зохицуулалт

Шүүхийн тухай 1993 оны хуулийн 60 дугаар зүйлийн 1-т Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. Мөн зүйлийн 2-т Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байвал зохино³ гэсэн зохицуулалтыг шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны хуулийн 2 дугаар зүйлд ... Шүүхийн тухай 1993 оны хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “2-т Шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгана. Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн

³ Доржготов, А. (2016) Монгол Улсын шүүх (Эрх зүйн баримт бичиг). Уб., 236 дахь тал

ба дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэх бөгөөд тэдгээрийг Улсын Их Хурал тус, тусад нь батална. Шүүхийн төсөв нь шүүх эрх мэдлийг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байвал зохино” гэж өөрчлөн найруулснаар Шүүхийн төсвийг Шүүхийн ерөнхий зөвлөл болон анхан болон давж заалдах шатны шүүхийн, Улсын дээд шүүхийн гэж хоёр тусад нь боловсруулан батлах зохицуулалт өнөө хир нь үйлчилж байгааг нь Үндсэн хуулиар Улсын дээд шүүхийг шүүхийн тогтолцооны салшгүй хэсэг гэдгийг тодорхой заасан атал төсвийг нь зориуд салгаж буй нь шүүхийн нэгдмэл байдлыг сулруулах, эдийн засгийн нөлөөлөл тогтоож байгаа үйлдэл⁴ гэж тайлбарласан байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1-т Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. Мөн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-т Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно гэсэн суурь зарчмын хэрэгжилтийг шүүхийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэхгүй байгаагийн илрэл гэж тэмдэглэж байна.

Үндсэн хуулийн “Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасны дагуу 1992 оноос шүүхийн тогтолцоог бүхэлд нь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зарчим, журам тогтож, анхан болон давж заалдах шатны шүүхийн төсөв орон нутгийн төсвөөс хамаарахгүй болсон байна.

Шүүхийн тухай 1993 оны хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “шүүхийн төсвийн төслийг зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулах, батлагдсан төсвийг хуваарилах бүрэн эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгож, улмаар энэхүү заалтад Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны хуулийн 2 дугаар зүйлд ... Шүүхийн тухай 1993 оны хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “3-т шүүхийн төсвийн төслийг хөндлөнгийн магадлан шинжлэх байгууллагаар дүгнэлт гаргуулж, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах, батлагдсан төсвийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих” гэж өөрчлөн найруулсан боловч уг заалт нь Төсвийн тухай хуультай зөрчилтэй улмаас шүүхийн төсвийн төслийг батлах үйл явц Сангийн яамнаас шууд хараат хэвээр байжээ. Ийнхүү төсвийн хараат байдал нь шүүхийн төсвийн хүрэлцээтэй байх зарчмын хэрэгжилтийг хангах боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн бөгөөд шүүхийн өр төлбөрийн хэмжээ 1994-2002 онд 635,3 сая төгрөг⁵-т хүрсэн талаар судалгаанд дурдсан байна. Түүнчлэн Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувийг зарим судалгааны тайлан, холбогдох баримт бичгээс шүүн нэгтгэж судлан үзсэнийг дараах хүснэгтээр харуулж буй нь улсын төсвийг батлахад хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн үлс төрийн хийгээд эдийн засгийн бүрэн эрх нөлөөлж буйг, нөгөө талаар шүүхийн төсвийн бууруулахгүй байх арга замыг эрэлхийлэн зарим улсад улсын төсвийн тодорхой хувь байхаар хуульчлан тогтоож, жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдэж байх боломжийг судлан үзэж байсантай холбоотой.

⁴ Лүндэндорж, Н. Монгол Улсын Үндсэн хууль (Шинжлэх ухааны тайлбар). 2022. Уб., 764 дэх тал.

⁵ Амарсанаа, Ж, Чимид, Б нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 77-78 дахь тал.

Хүснэгт 1. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь, 1994-2002 он⁶

Төсвийн жил	Улсын төсөв /мянган төгрөг/	Шүүхийн төсөв /мянган төгрөг/	Улсын төсөвт эзлэх хувь
1994	78,468,137.7	238,638.4	0.30
1995	132,153,100.0	555,040.5	0.42
1996	162,377,500.0	587,124.0	0.36
1997	151,867,974.3	718,287.1	0.47
1998	293,963,978.6	1,047,741.1	0.36
1999	338,846,397.0	1,071,135.6	0.32
2000	391,588,620.1	1,547,518.0	0.40
2001	440,157,875.0	1,760,631.5	0.40
2002	435,691,020.2	1,994,593.8	0.46

Дээрх хугацаа нь Монгол Улсын хувьд нийгэм, эдийн засгийн шилжилтийн үеийг хамарч байсан бөгөөд Шүүхийн тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд 1993-2002 онд улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь 9 жилийн дунджаар 0,39 хувь байжээ.

УИХ-ын 1993 оны “Шүүхийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол, УИХ-ын 1996 оны “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 26 дугаар тогтоол, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоол, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоол, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2001 оны 44 дүгээр тогтоолыг тус тус батлан хууль хэрэгжүүлэх болон шүүх эрх мэдлийн байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн материаллаг болон процессын хууль тогтоомжийг 2002 онд өөрчлөн баталсан бөгөөд Шүүхийн тухай 2002 оны хуульд Шүүхийн санхүүжилтийг 19 дүгээр зүйлийн 19.1-д Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. 19.2-т Шүүхийн төсөв нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна. 19.3-т “Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн болон дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэнэ” хэмээн захиргааны шинжтэй заалтаар тодруулсан зэрэг нь шүүхийн хараат бус байдлыг хөндөлгүйгээр шүүхийн төсвийг хэрхэн батлах, зарцуулалтыг хэрхэн хянах зэрэг бусад

⁶ Төрийн мэдээлэл-1993 он., №8/19/

ШЕЗ-ийн 1996 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн “Монгол Улсын шүүхийн 1995 оны төсвийн гүйцэтгэл, 1996 оны төвлөрсөн төсвийг хуваарилах тухай.” Тогтоолын дугаар 13.

ШЕЗ-ийн 1996 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Шүүхийн байгууллагын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх тухай.” Тогтоолын дугаар 50.

ШЕЗ-ийн 1997 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Шүүхийн 1997 оны төсөв хуваарилах тухай.” Тогтоолын дугаар 1.

Амарсанаа, Ж, Чимид, Б нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 78 дахь тал.

эрх мэдэлтэй харилцах асуудлыг тус хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3-т шүүхийн төсвийг хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд үлдээж, шүүхийн төсвийн төслийг өргөн барих бүрэн эрхийг хасаж уг чиг үүргийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай 2002 оны хуулиар зохицуулжээ. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн төсвийн; 11.1.8-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн; мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг нэгтгэн ... Засгийн газарт мэдүүлнэ. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т Засгийн газар төсвийн төслийг ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ гэж нэг эрх мэдлийн үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг нөгөө эрх мэдэл өөрийн чиг үүрэгт хамааруулах хянан хэлэлцэх нь хэр оновчтой байсныг Хүснэгт 2.-оор нэгтгэн харууллаа.

Хүснэгт 2. Монгол Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь, 2003-2012 он⁷

Төсвийн жил	Улсын төсөв	Шүүхийн төсөв	Улсын төсөвт эзлэх хувь
	/мянган төгрөг/	/мянган төгрөг/	
2003	558,198,728	2,201,713	0.39
2004	699,102,676	2,701,279	0.39
2005	775,069,573	3,360,534	0.43
2006	1,161,197,115	4,141,438	0.36
2007	1,725,971,669	7,293,628	0.42
2008	1,815,584,400	13,283,100	0.73
2009	1,854,741,100	9,819,300	0.53
2010	2,423,103,400	12,113,500	0.50
2011	3,609,784,500	14,309,100	0.40
2012	4,865,904,200	20,876,000	0.43

Дээрх хүснэгтээс харахад Шүүхийн бие даасан 2 дахь хуулийн хэрэгжилтийн үед шүүхийн төсөв нь 10 жилийн дунджаар улсын төсвийн 0,46 хувийг эзэлсэн байна. Үүнээс 2008 оны улсын төсөвт хамгийн өндөр буюу 0,73 хувийг, харин 2006 онд⁸ хамгийн бага буюу 0,36 хувийг эзэлсэн байна. Монгол дахь засаглалын төлөв байдлыг үнэлэх 2006 онд хийгдсэн судалгаанд шүүхийн төсвийг улсын төсөвт 0.45 хувь орчимд тооцон суулгаж байгаа нь шүүх, шүүгчийн орон байр, цалин, томилолт, холбоо харилцаа, шүүн таслах ажиллагаанд хүрэлцдэггүй зэрэг нь шүүхийг улс төрөөс зарим талаар хараат болгож байна гэж дурджээ.

Улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувь хэмжээ нь 2002-2012 оны 10 жилийн дунджийг 1994-2002 оны дундаж хувь үзүүлэлттэй харьцуулан үзэхэд 0,07 хувиар өссөн дүн харагдаж

⁷ Амарсанаа, Ж, Чимид, Б нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 78-79 дэх тал.

⁸ ШЕЗ (2018). Шүүхийн захиргааны хөгжил. Уб., 222 дахь тал.

байгааг ч шүүхийн хүний нөөц, ажиллах орчин нөхцөлд бодитой бие даасан байдлыг бүрдүүлэх алхам хийгдэж чадаагүй хэвээр үргэлжилж байжээ гэж дүгнэж байна.

Шүүхийн төсөв бодит дүнгээрээ төдийгүй төрийн бусад байгууллагатай харьцуулахад бага байгаа бөгөөд улсын төсвийн 0.5 хувьд ч хүрэхгүй, энэ хувь нь жилээс жилд өсөж, буурдаг. Иймээс санал асуулгад оролцогчдын гуравны нэг орчим буюу 29 хувь нь “Шүүхийн нийт төсөв нь шүүхээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд байдаг” гэдэгтэй санал нийлжээ. Шүүхийн төсвийг улсын төсвийн тодорхой хувиар тогтоож, тогтвортой болгосноор шүүхийн төсвийг буруугаар ашиглан тэдгээрт хяналтаа тогтоох явдлаас хамгаалагдах тул шүүхийн төсвийг улсын төсвийг тодорхой хувь, тухайлбал, 3, 2, бүр 1 хувь, эсхүл өөр хувиар тогтмол барих тухай санал хэд хэдэн удаа гарсан ч хууль тогтоох байгууллага нь хүлээж аваагүй байна. Үүнээс үүдэн шүүхийн төсөв нь өчүүхэн бага, шүүх өөрөө жилийн хугацаанд төлбөр хураамжаас олдог орлогоос нь ч бага төдийгүй бусад төрийн эрх мэдлийн байгууллагын зүгээс өөртөө ашигтайгаар өөрчлөх боломжтой байгаа юм.⁹ гэж дүгнэсэн нь одоо ч Засгийн газрын болон УИХ-аас байгуулж буй зарим байгууллагын төсөвтэй харьцуулан үзэж, тэдгээр байгууллагын төсвийн улсын төсөвт эзлэх хувийг төсвийн хяналтын хүрээнд хөндлөнгийн судалгааны ажлаар дүгнэж үзэх нь зүйтэй юм.

Үндсэн хуульд заасан шүүхийн эдийн засгийн баталгааг хангах суурь зарчмын хэрэгжилт хангалтгүй байгааг Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь судалгаанд хөндөж судалсан бөгөөд шүүх хараат бус орших эдийн засгийн баталгааг хангахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай зарим зөвлөмжид 1) улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувийг шууд зааж, жил бүр итгэлцүүрээр өсөж байхыг хуульчилсан зарим орны туршлагыг авч хэрэгжүүлэх, 2) ШЕЗ-ийн төсвийн төслөө хамгаалан зөвшилцөх эрх хэмжээг өргөтгөх, шүүгчдийн байгууллагын оролцоог хангах арга замыг төсвийн болон шүүхийн хуулиар нарийвчлан зохицуулах, 3) Шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангахад УИХ, Засгийн газрын хүлээх үүрэг, хариуцлагыг шүүхийн болон төсвийн хуулиар нарийвчлан зохицуулах¹⁰ гэж зөвлөж байжээ.

УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний Стратеги зорилт 1.4-т Шүүхийн төсвийн хараат бус байдлыг бэхжүүлнэ: Авах арга хэмжээ-2, Стратеги зорилт 1.5-д Шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлнэ: Авах арга хэмжээ-2, Стратеги зорилт 1.6-д Шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн хувьд хараат бус байх явдлыг хангана: Авах арга хэмжээ-3 гэж тусгаж, тухайн стратеги төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулсан нь 2006 оны тайланд тус стратеги төлөвлөгөөний зорилт бүрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 101 арга хэмжээ зааснаас 26 арга хэмжээ буюу 25 хувь нь эцсийн үр дүнд хүрээгүй тасалдсан, эдгээр арга хэмжээ нь гол төлөв шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын эдийн засгийн баталгааг хангаж хэрэгжүүлэх болон дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээг хамарсан¹¹ гэжээ. Түүнчлэн уг стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Шүүхийн төсвийн хараат бус байдлыг бэхжүүлэх”, “шүүгчийн эдийн

⁹ Брент Т. Уайт. Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан Нээлттэй нийгэм форум. Уб., 2008. 14 дэх тал.

¹⁰ Лүндэндорж Н., нар. Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь (Бодлогын тойм судалгаа). Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 35-36 дахь тал.

¹¹ Амарсанаа, Ж, Чимид, Б нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 31 дэх тал.

засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх” стратеги зорилт сайн биелэхгүй байгааг төрийн хяналт, тэнцлийн зарчим хэрэгжих бодит нөхцөл байдал бүрэлдээгүйтэй холбон дүгнэж байжээ.

УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай”, “УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай”-д тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтыг бүрэн хангах, шинэтгэлийг гүнзгийрүүлэх ажлын хүрээнд Шүүхийн багц хуулийг 2012 онд батлан 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн уг хууль нь Үндсэн хуульд тухайн харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна гэсэн зарчмыг 20 жилийн дараа бүрэн хэрэгжүүлж, шүүхийн мэргэжлийн болон захиргааны үйл ажиллагааг бүрэн зааглаж өгснөөрөө шүүхийн эрх зүйн орчинд шинэ хуудас нээж өгсөн. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т заасан шүүхийн санхүүжилтийн хараат бус байдлаар талаарх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Шүүхийн тухай 2012 оны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана”. Мөн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт “ШЕЗ бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн УИХ-д шууд өргөн мэдүүлнэ”, 28.5-д “Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” ШЭЗБТХ-ийн 23.5-д “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” зохицуулалтыг шинээр тусгасан байна. Эдгээр зохицуулалтаас үзэхэд шүүхийн үйл ажиллагаа хэвийн явуулах хэмжээний төсөвтэй байх асуудлыг бодлогын хэмжээнд боловсруулах эрх мэдлийг ШЕЗ-д шилжүүлж¹², шүүхэд чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн хангалттай эх үүсвэр олгох нь төрийн үүрэг¹³ болохыг тодотгож өгсөн. Түүнчлэн ШЕЗ, шүүхийн үндсэн үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй, хүртээмжтэй эрхлэхэд дэмжин туслах чиг үүргээ хэрэгжүүлэх, тэдгээрт шаардагдах төсвийг батлуулах эрх хэмжээг хуулиар олгосон. Шүүхийн төсвийг цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын зардал, шүүн таслах ажиллагаатай холбогдон гарах зардал, бусад зардалд зарцуулдаг. Шүүхийн багц хууль батлагдсанаас хойших шүүхийн төсвийн санал, батлагдсан төсвийг Хүснэгт 3.-аар харьцуулж үзлээ.

Хүснэгт 3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв, 2013-2021 он

Төсвийн жил	Төсвийн санал		Батлагдсан төсөв		Батлагдаагүй үлдсэн хувь	
	Урсгал зардал /тэрбум төгрөг/	Хөрөнгө оруулалтын зардал /тэрбум төгрөг/	Урсгал зардал /тэрбум төгрөг/	Хөрөнгө оруулалтын зардал /тэрбум төгрөг/	Урсгал зардал /хувиар/	Хөрөнгө оруулалтын зардал /хувиар/
2013	-	-	35.75	7.03	-	-
2014	135.5	102.6	59.6	0	56.01	100

¹² Бямбаа, Л. (2016) Шүүхийн эдийн засгийн баталгааг хангах зарим асуудал. //Шүүхийн шинэтгэл. Уб., 219-222 дахь тал.

¹³ Дэлхий нийтийн авлигын тайлан 2007 (Шүүхийн тогтолцоо дахь авлига).Транспэрэнси интернэшнл – Монгол. Уб., 2008. 86 дахь тал.

2015	63.3	24.8	52.1	0	17.69	100
2016	67.9	42.7	48.3	0	28.87	100
2017	66.3	30.5	50.8	0	23.38	100
2018	86.6	40	48.6	0	43.88	100
2019	95.9	40	51.1	0	46.72	100
2020	99.1	30.98	56.3	0	43.19	100
2021	105.29	28.98	61.16	4	41.91	86.20

ШЕЗ-өөс шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, Шүүхийн тухай багц хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлан төлөвлөн Сангийн яаманд хүргүүлж, УИХ-д өргөн мэдүүлж, өргөн мэдүүлсэн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу хянан, үрсгал зардлын төсвийг дунджаар 35,11 хувиар бууруулж, хөрөнгө оруулалтын зардлыг 2014 оноос 2020 он хүртэл 100 хувь хассан. Шүүхийн багц хуулийн хэрэгжилтийн хүрээнд хөрөнгө оруулалтын зардлыг 2013 онд 7,03 тэрбум төгрөгөөр, 2021 онд 4 тэрбум төгрөгөөр баталж байжээ.

Төсвийн саналыг энэ маягаар бууруулж баталж байгаа нь тухайн жилийн эдийн засгийн хүндрэл, жил бүрийн орлого төвлөрүүлэлт тасалдсанаас үүсэх талтай ч бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг төр хангах үүргээ хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл хяналт, тэнцлийн зарчмыг алдагдуулан хөндлөнгийн нөлөөлөл үүсгэн, хэлбэрийн төдий хэрэгжүүлж иржээ гэж дүгнэж болох юм. Тухайлбал, Засгийн газраас 2016 оны 8 дугаар сарын 23-ны өдөр УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүхийн урсгал төсвийн зардлыг батлагдсан хэмжээнээс 3,9 тэрбум, шүүгчийн цалингийн санг 3,2 тэрбум төгрөгөөр бууруулахаар тусгаж, ШЭЗБТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, УИХ-ын 2015 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болгох төсөл боловсруулсан талаар ШЕЗ-ийн даргын холбогдох албан тушаалтанд илгээсэн албан бичигт¹⁴ дурдсан байна. Энэ нь шүүхийн үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн зарчмын хэрэгжилтэд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн улс төрийн хийгээд эдийн засгийн нөлөөлөл тогтоож ирсний нэг илрэл гэж харж болно.

Шүүхийн төсвийн хэмжээ Хүснэгт 3-т үзүүлснээр аажмаар нэмэгдэж байгаа нь нааштай хандлага боловч түүнийг улсын нэгдсэн төсвийн ядахдаа нэг хувьд хүргэх бодит шаардлага хэвээр байна¹⁵ гэжээ. Шүүхийн эдийн засгийн баталгааг хангах гэдэг нь шүүхийн шүүн таслах ажиллагааны зардал, шүүгчийн цалин, хангамж шүүхийн дэд бүтэц зэрэг нэг нэгээсээ харилцан хамааралтай цогц асуудлыг шийдвэрлэж, шүүгчийн хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг байна. Гэтэл Шүүхийн тухай 2012 оны хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно”, ШЭЗБТХ-ийн 23.5-д “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй”¹⁶ гэсэн


¹⁴ ШЕЗ-ийн даргын 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 01/915-921 тоот албан бичиг.

¹⁵ Энхбаатар, Ч., нар. (2016) Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Уб., 117 дах тал.

¹⁶ Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон

зохицуулалтыг тус тус хүчингүй болгон шүүхийн эдийн засгийн баталгааг төр хангана гэсэн суурь зарчмыг хэрэгжүүлэхээс ухарсан алхам болсон талаар зарим судалгаанд дурджээ.

График 1. ШЕЗ-өөс оруулсан шүүхийн төсвийн төслийг үндэслэлгүйгээр бууруулахаас сэргийлсэн зохицуулалт шаардлагатай эсэх¹⁷



Судалгаанд хамрагдсан шүүгчдийн 88.7 хувь нь; шүүхийн захиргааны ажилтнуудын 62.2 хувь нь ШЕЗ-ийн оруулсан төсвийг үндэслэлгүйгээр бууруулахаас урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзсэн бол уг судалгаанд хамрагдсан шүүхийн захиргааны ажилтнуудын 28.1 хувь нь тухайн асуудлаар ямар нэгэн хариу хэлж мэдэхгүй байна гэжээ. Мөн Үндсэн хуульд “шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийн хэмжээнээс бууруулахыг хориглоно”, “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэсэн агуулга бүхий заалтыг Үндсэн хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна¹⁸ гэсэн судалгааны дүгнэлт ч гарч байжээ. Хэдийгээр шүүхийн тухай багц хууль батлагдсанаар шүүхийн эдийн засгийн баталгаа тодорхой хувиар сайжирсан тоон мэдээ гарсан боловч Шүүхийн тухай хууль, ШЭБЗТХ-д заасан шүүхийн төсөв, шүүгчийн цалинг бууруулахгүй байх агуулгаар тусгасан заалтыг хүчингүй болгосон нь өнөөдөр ч шүүхийн хараат бус байдлыг хангахад бэрхшээл учирсан хэвээр байхыг илэрхийлжээ. Тухайлбал, Хүснэгт 4-т шүүхийн бие даасан байдалд нөлөөлж буй хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн Үндсэн хуульд заасан эрх хэмжээг эрх мэдэл хуваарилах онолын хяналт тэнцлийн зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг илэрхийлж байгаа нь дараа дараачийн шүүхийн тухай хуульд ч шүүхийн санхүүжилтийн талаар, шүүхийн төсөв батлах үйл явцын талаар эерэг зохицуулалт орж ирэхгүй байх талтайг харуулж байна.

Хүснэгт 4. Шүүхийн бие даасан байдал

Нөлөөлж болзошгүй субъект	Үндсэн хуулийн зүйл, заалт	Тайлбар
	<p>Хорин тавдугаар зүйл.</p> <p>1. УИХ төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:</p> <p>1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;</p>	<p>1. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд эрх зүйн байдлыг дордуулсан хууль батлах замаар шүүхийн хууль зүйн болон эдийн засгийн баталгааг хангахгүй дордуулах;</p>

¹⁷ Өлзийсайхан, Б. (2018) Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны гүйцэтгэх үүрэг: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сэдэвт Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан бүтээл. 159 дэх тал.

¹⁸ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан. 2020. 31 дэх тал. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү (2023-09-10): <https://forum.parliament.mn/files/93572>

Хууль тогтоох эрх мэдэл	<p>7/төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.</p> <p>Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.</p> <p>Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;</p>	<p>2. Шүүхийн төсөв ..., улсын төсөв түүний гүйцэтгэлийн тайланг батлахдаа шүүхийн төсвийн хэмжээг үндэслэлгүй бууруулж батлах замаар шүүхийг эдийн засгийн дарамтад оруулж шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдаж болзошгүй.</p>
Гүйцэтгэх эрх мэдэл	<p>Гучин наймдугаар зүйл.</p> <p>2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>2/ ... улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;</p>	<p>Бүрэн эрхийнхээ дагуу болон бусад хуульд тусгасан зохицуулалт буюу бүрэн эрхийн дагуу шүүхийн төсвийн төслийг УИХ-д өргөн барих явцдаа ХЗБХ-ны дүгнэлтийг үл харгалзан шүүхийн төсвийг танах, шүүхийн төсвийг бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлэх төсөв гэж үзэхгүйгээр эдийн засгийн нөлөөлөл үүсгэж болзошгүй.</p>

Үндсэн хуульд шүүхийн эдийн засгийн баталгааг хангах тухай ерөнхий заалт тусгасан боловч практикт хэрэгжихгүй, шүүх эдийн засгийн хувьд төрийн бусад эрх мэдлээс хараат байсаар байна.¹⁹ Шүүхийн эдийн засгийн баталгаа хангагдах эрх зүйн зохицуулалт сайжирсан боловч хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийн төсвийг бууруулах хандлага хэвээр байна. Хуулийн дэвшилттэй заалтыг сэргээн хуульчлах, ...“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх” хөтөлбөрт тусгасан шүүхийн төсвийн хэмжээг улсын нэгдсэн төсвийн 1,5 хувьд хүргэх зорилтыг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай²⁰ гэж дурджээ. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн хэд хэдэн судалгаанд шүүхийн төсөв нь улсын төсвийн тодорхой хувийг эзэлдэг байх, тухайн хувийг хуульчлах талаар зөвлөмж, санал гаргаж байсан нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах зарчмыг бүрэн хэрэгжүүлэх бололцоо бүрдэнэ хэмээн нэг талаас дүгнэсэн бол нөгөө талаас өөрчлөгдөж буй тэргүүлэх чиглэл, эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн шийдвэрээс хамаарч төсвийн хуваарилалт жилээс жилд өөрчлөгдөж болно гэсэн агуулгыг харгалзан үзээгүй байна. Түүнчлэн шүүхийн багц хуулийн хэрэгжилтийн хүрээнд шүүхийн бодит хэрэгцээг хангахуйц шүүхийн зориулалтын барилга, хөрөнгө оруулалтын төсвийг УИХ-аар батлуулах, шүүхийн техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг шинэчлэх

¹⁹ Алтансүх, Ж. (2017). Монгол Улсын Үндсэн хууль ба шүүхийн эдийн засгийн баталгаа. //Хууль дээдлэх ёс. №2 (62). 158-159 дэх тал.

²⁰ Хууль зүйн судалгааны төв (2016). Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь. (Судалгааны үндсэн тайлан). УБ., 102-103 дахь тал.

санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна бусад эх үүсвэрээс бүрдүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага буй тухай бүр тайлагнаж байсан хэдий ч өнөө хэрнэ шүүхийн эдийн засгийн баталгааг хангах бодитой алхам хийгдээгүй хэвээр байна. Шүүхийн төсвийг танаж, аль нэг яам газрынх шиг хасаад, шүүгчийн болон шүүхийн ажилтны ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан төсвийн хэрэгцээ шаардлагаа бүрэн илэрхийлж, нээлттэй ил тод хэлэлцүүлэх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бусаар төсвөө батлуулах эхний алхам юм.

1.2. Анхан болон давж заалдах шатны шүүхийн төсвийн өнөөгийн байдал

УИХ-аас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журам, шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг бэхжүүлж, өмнө нь Шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулж ирсэн харилцааг нэгтгэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгах шаардлага бий болгосны дагуу Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 онд баталсан. Мөн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т заасан суурь зарчмыг хуулийн шинэчилсэн найруулгаар тодотгон хэд хэдэн зүйл, хэсгээр зохицуулсан байна. Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т Шүүх нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрөөс бусад хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглоно. гэж улсын төсвийн бус өөр эх үүсвэрээс санхүүжих ёсгүй гэдгийг бататгасан²¹ байна. Шүүхийн бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэхдээ ШЕЗ нь Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, НҮБ-ын Хүний эрхийн төсөл, Дэлхийн банкны Шүүх эрх мэдэл төсөл, Ханнс-Зайделийн сан, Японы Жайка байгууллагын дэмжлэгтэйгээр нийт шүүхийг компьютер бусад техник, тоног төхөөрөмж, шаардлагатай гарын авлагаар хангах, шүүхийн байрыг засварлах, зарим орон нутгийн шүүхийг байраар хангах зэрэг шүүгч, шүүхийн ажилтны албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах чиглэлийн ажлыг хийсэн байна²². Эдгээр олон улсын эрх зүйн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч, дэмжигч байгууллагуудын санхүүжилтээр тодорхой хөрөнгө оруулалтууд хийгдсэн бөгөөд цаашид ч үргэлжлүүлэх шаардлага буйг тэмдэглэхийн зэрэгцээ хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх санхүүжилт нь шүүгч, шүүхийн ажилтныг чадавхжуулахад чиглэгдэх шаардлагатай юм. ШЕЗ-ийн 2020-2023 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд авсан гадаад тусламжийн мэдээлэл нь шүүхийн хөрөнгө оруулалтын зардлыг тогтмол танаж, огт батлаагүй ирсэн сүүлийн 10 гаруй жилд шүүхийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй, шуурхай хүргэхэд үүсэж буй бэрхшээлийг илтгэхийн зэрэгцээ, эдгээр хандив тусламжаар шүүхийн хөрөнгө оруулалтын зарим зардлын тодорхой хувийг нөхөж ирсэн хэвшмэл ойлголт буйг Хүснэгт 5.-аар харуулж байна.

Хүснэгт 5. Хандив, тусламжийн талаар мэдээлэл /мянган төгрөг/²³

²¹ Лүндэндорж, Н. (2022) Монгол Улсын Үндсэн хууль (Шинжлэх ухааны тайлбар). Уб., 761 дэх тал.

²² Оюумаа, В. (2011). Монгол Улсын эрх зүйн шинэтгэл: Олон Улсын байгууллага, гадаад орнууд, олон улсын байгууллагын төслийг дэмжлэг. Эрдмийн ертөнц (Academiae). Уб., 136-139 дэх тал.

²³ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл.

Утга	Он /төгрөгөөр/				Тайлбар
	2020	2021	2022	2023	
Гадаад	6,716.7	1,943,553.4	324,071.6	299,950.4	GIZ олон улсын байгууллагаас серверийн болон шүүх хуралдааны танхимд тоног төхөөрөмж, 2021 онд 299.1, 2022 онд 324.0, 2023 оны 299.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.


Шүүхийн гадаад хандив, тусламжийн сүүлийн 4 жилийн мэдээнээс харахад шүүхийн техник, технологийн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэгджээ. Энэ нь шүүхэд хөрөнгө оруулалтын төсвөөр хийгдэх ажлын багахан хэсэг юм.

Шүүхэд ирүүлсэн дотоод хандив, тусламжийн талаарх мэдээлэлд дүгнэлт өгөхөөс өмнө шүүх улсын төсвийн орлого бүрдүүлэгчийн үүрэггүй болохыг тэмдэглэж байна. Татварын ерөнхий хуульд "хураамж гэж төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг" ойлгохоор заасан бөгөөд тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.9-д заасан улсын тэмдэгтийн хураамжийг нь татварын төрөлд хамаарах бөгөөд Төсвийн тухай 2011 оны хуулийн 23 дугаар зүйлийн 23.7, 23.8-д заасан Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогод энэ хуулийн 23.4.9-д заасан улсын тэмдэгтийн хураамжаас бусад улсын тэмдэгтийн хураамж хамаарна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль²⁴ -ийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх, 7 дугаар зүйлийн 7.1.1-д эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоохоор заасан бол, 7.1.2-т эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шүүхэд гаргах гомдолд 70 200 төгрөгөөр, 7.1.3-т хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутамд 100 төгрөг. Мөн хуулийн 7¹.1-д Эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа зохицуулахаар шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргахад 30,000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана гэж хуульчилсан. Эдгээр хуулийн хэрэгжилтийн дагуу орон нутгийн төсвийн орлогод шүүх хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлж, хуульд заасан мөнгөн дүн, хувь хэмжээгээр хураамж авч тухай бүр төсөвт төвлөрүүлжээ.

График 2. Шүүхийн төсөв, шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо ба улсын тэмдэгтийн хураамжийн мэдээлэл, 2014-2021 он²⁵

²⁴ Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийг 1993 онд баталж, 2010 онд шинэчлэн найруулсан.

²⁵ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл



Шүүхээр шийдвэрлэж буй хэрэг маргаан жил ирэх тусам өссөн үзүүлэлттэй. Шүүх 2014 онд 64.4 мянган хэрэг шийдвэрлэж байсан бол энэ тоо 2020 онд 100.1 мянга, 2021 онд²⁶ 88.2, 2022 онд 98.2 мянга болж өссөн дүнтэй байна.²⁷ Мөн шүүх улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу 2014-2021 оны мэдээгээр 161.4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод оруулсан байна. Шүүхээр шийдвэрлүүлж буй хэрэг маргааны тоо өсөж буй үзэгдлийг дагаад улсын тэмдэгтийн хураамжийн дүн өсөн нэмэгдэж байгаа нь шүүхийн жилийн төсвийн 1/3-тэй тэнцэхүйц хэмжээнд хүрч буйгаас дүгнэж болно. Энэхүү орон нутгийн төсвийн орлогын хүримтлалын зарцуулалтыг өөрчлөх, шүүхийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх боломжийг эрэлхийлж ШЕЗ-ийн ажлын албанаас 2017 онд судалгаа хийсэн бөгөөд Засгийн газрын зарим байгууллагын жишгээр төсөвт төвлөрүүлсэн орлогын тодорхой хувийг буцаан авч, зарим зардлаа шийдвэрлэж байсан түршлагыг ч харгалзан үзсэн нь бий. Угтаа бол энэхүү орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн үйлчилгээний хураамжийг Засгийн газар чиг үүргийн хүрээндээ төвлөрүүлэн Шүүхийн санхүүжилтийн хүртээмжтэй байдлыг бэхжүүлэхэд зарцуулах үүрэгтэй юм.

Монгол Улсад анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн 41 тамгын газрын 43 байранд үйл ажиллагаа явуулж²⁸ байна. Орон нутагт байрлах шүүхийн тамгын газарт Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.15-д аймгийн Засаг дарга нь “тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллагад шаардлагатай дэмжлэг үзүүлэх” бүрэн эрхийн хүрээнд Хүснэгт 6.-д харуулснаар орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд хуулийн энэ заалтыг дэлгэрүүлэх, дэмжлэгийн хүрээ хязгаарыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй улсын тэмдэгтийн хураамжийн орлоготой уялдуулан зохистой хэмжээнд тодорхой болгох шаардлага ч үүсэж байна. Үүнд Засгийн газар манлайллын үүрэгтэй оролцож холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, санаачилга гаргах нь эрх мэдэл хоорондын хяналт, тэнцлийн зарчмыг бодитоор хэрэгжүүлэхэд түлхэц болно.

Хүснэгт 6. Орон нутгийн захиргааны байгууллагын дэмжлэг /мянган төгрөг/²⁹

Утга	Он /төгрөгөөр/	Тайлбар
------	----------------	---------

²⁶ 2021 онд Корона вируст халдварын улмаас шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тоо буурсан байна.

²⁷ Шүүх эрх мэдлийн хөгжлийн хөтөлбөрийн төсөлд хийсэн нөлөөллийн үнэлгээ. Хөндлөнгийн судалгаа 2023. Уб., 24 дэх тал

²⁸ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл

²⁹ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл

	2020	2021	2022	2023	
Дотоод	170,700.0	205,716.2	139,784.0	123,570.1	Орон нутгийн захиргааны байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн өрөө тохижуулах болон зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад санхүүжүүлсэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг 2022 онд баталсан. Тус хуулийн 3 дугаар зүйлд Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага орлого төвлөрүүлнэ гэж заасны дагуу Шүүхийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4-т заасан Ерөнхий зөвлөлийн дэргэдэх иргэний болон захиргааны хэргийн тусгай архив³⁰ 2023 онд 270.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр буюу өмнөх оноос 2.25 дахин нэмэгдүүлэн хуульчилсан байна. Өмнөх жилүүдэд шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогыг Хүснэгт 7.-ийн тайлбар хэсэгт заасан дүнгээр баталж ирсэн бөгөөд тухайн дүнгээс илүү гарсан дүнг давсан орлогод тооцож байжээ. Шүүхийн тусгай архивын орлогыг 2 жил тутамд нэмэгдүүлэн тооцож байгаад зарчмын хувьд ШЕЗ санал нийлэх учиргүй бөгөөд үүнийг тодотгон тэмдэглэвэл: 1) шүүх нь төсөв бүрдүүлэгчийн үүрэггүй бие даасан эрх мэдлийн байгууллага, 2) тухайн орлого нь тогтвортой өсөн нэмэгдэх орлогод тооцогдохгүй, манай улсын нийгэм, эдийн засгийн байдалтай уялдаж хэлбэлзэж байдаг тул улсын төсвийн хуульд орлого төвлөрүүлэгч байгууллагаар баталж буйг эргэж харах нь зүйтэй.

Хүснэгт 7. Шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлого /мянган төгрөг/³¹

Утга	Он /төгрөгөөр/				Тайлбар
	2019	2020	2021	2022	
Давсан орлого	227.4	275.6	163.1	262.4	2017-2019 онд 60.0 сая төгрөг, 2020-2022 онд 120.0 сая төгрөгөөр батлагддаг бөгөөд шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогоос давсан орлогын дүнг харуулав.

Шүүхийн төсөвт дэмжлэг болж буй дотоод, гадаад хандив, тусламж болон шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогын хууль зүйн үндэслэлд дүн шинжилгээ хийвэл Үндсэн хуульд шүүх үйл ажиллагаагаа хэвийн явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэж тодотгосон, шаардлагатай санхүүгийн нөөцийг Засгийн газар бүрдүүлж, УИХ баталж өгөх үүрэгтэйг баталгаажуулж өгсөн.

Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-т Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана. Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.³² Мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ болон нэмэгдэл олгох журам, шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно. 46.4-т Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй. 46.7-д Шүүгчийн ажлын ачаалал тооцох

³⁰ Шүүхийн архивын ажиллах журам. ШЕЗ-ийн 2016 оны 03 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 56 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан.

³¹ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл

³² Төрийн хэмнэлтийн тухай хууль. 2022

шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг Ерөнхий зөвлөл батална³³. гэж тухайн баталгааг хангах, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлсэн. Шүүхийн тухай 2012 оны хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.”, ШЭЗБТХ-ийн 23.5-д “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг буруулж болохгүй” гэсэн 2015 онд хүчингүй болгосон зохицуулалтыг дахин тодотгон хуульчилсан байна. Шүүхийн тухай 2021 оны хуулийн 46 дугаар зүйлийн 46.8-д Шүүхийн төсвийг боловсруулж батлахад дараах журмыг баримтална: 46.8.1-д Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх; 46.8.2-т Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх; 46.8.3-т Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 46.8.4-т Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх гэж нэлээд нарийвчилсан зохицуулалтыг оруулан баталсан байна.

Шүүхийн эдийн засгийг баталгааг харьцангуй тодотгон зохицуулсан Шүүхийн тухай хуулийн дээрх зохицуулалт ШЕЗ-ийн төсөвт хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж дараагийн дэд зүйлд хөндөх агуулгыг тодорхойлохыг зорилоо.

ШЕЗ-ийн 2022, 2023 оны төсөвт хийсэн дүн шинжилгээ:

ШЕЗ-ийн 2022 оны төсөв нийт 79,196,664.3 мянган төгрөг батлагдсанаас 75,196,664.3 мянган төгрөг буюу нийт төсвийн 94,95 хувийг урсгал зардал, 4,000,000.0 мянган төгрөг буюу нийт төсвийн 5,05 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

График 3. ШЕЗ-ийн 2022 оны төсөв³⁴

³³ ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 207 дугаар тогтоолоор “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ыг баталсан.


³⁴ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөл 2022 оны батлагдсан төсөв
нийт 79,196,664.3 мянган төгрөг



2022 оны батлагдсан төсвийн нийт урсгал зардал 75,196,664.3 мянган төгрөгийн 71,864,770.9 мянган төгрөг буюу 95,57 хувь нь бараа, үйлчилгээний зардалд, 3,331,893.4 мянган төгрөг буюу 4,43 хувь нь бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн тэтгэмж урамшуулал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж эзэлж байна. Үүнээс урсгал зардлын бараа, үйлчилгээний зардалд 71,864,770.9 мянган төгрөг төсөвлөгдөн зарцуулагдсан ба уг зардлыг зардал тус бүрээр ангилан График 4.-т харуулав.

График 4. ШЕЗ-ийн 2022 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал




ШЕЗ-ийн 2022 оны батлагдсан төсвийн нийт хөрөнгө оруулалтын зардал 4,000,000.0 мянган төгрөгөөс 2,000,000.0 мянган төгрөг буюу 50 хувь нь их засварын зардалд, үлдсэн 2,000,000.0 төгрөг буюу 50 хувь нь тоног төхөөрөмжийн зардалд тус тус төсөвлөгдөн зарцуулагдсан байна. Мөн батлагдсан төсөв болох 79,196,664.3 мянган төгрөгийн 99,85 хувь 79,076,664.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 0,15 хувь 120,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого буюу шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогоос санхүүжүүлэн

зарцуулсан байна. Тухайн жилийн төсвийн 86.28 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл эзэлсэн бөгөөд үлдсэн 13.72 хувийн төсвөөр шүүхийн бие даасан байдлыг ханган үйл ажиллагаа явуулах, түүнчлэн төрөөс санхүү, мөнгөний талаар баримтлах зарим бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шүүх эрх мэдлийн байгууллагыг тэгшитгэн хамааруулж байгааг эргэн харах шаардлагатай юм. 2022 оны шүүхийн төсөвт хөрөнгө оруулалтын зардал баталж өгсөн нь Шүүхийн тухай 2021 оны хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн байна.

ШЕЗ-ийн 2023 оны нийт төсөв 90,597,060.1 мянган төгрөгөөр батлагдсанаас 3,851,757.6 мянган төгрөг нэмж, 2023 оны нийт төсвийг 94,448,817.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Уг тодотголоор нэмж батлагдсан 3,851,757.6 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 3,423,783.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардалд 426,373.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 412,604.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд тус 7,500.0 мянган төгрөг тус тус нэмж тодотгон баталжээ.

ШЕЗ-ийн 2023 оны тодотгосон нийт төсөв нь 94,448,817.7 мянган төгрөгөөр батлагдсан ба уг батлагдсан төсөвт хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй байна. 2023 оны батлагдсан төсвийн нийт урсгал зардал 94,448,817.7 мянган төгрөгийн 88,530,366.3 мянган төгрөг буюу 93,7 хувь нь бараа, үйлчилгээний зардалд, 5,918,451.4 мянган төгрөг буюу 6,3 хувь нь бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн тэтгэмж урамшуулал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж эзэлж байна.


График 5. ШЕЗ-ийн 2023 оны төсөв³⁵



Үүнээс урсгал зардлын Бараа, үйлчилгээний зардалд 88,530,366.3 мянган төгрөг төсөвлөгдөн зарцуулагдсан ба уг зардлыг зардал тус бүрээр ангилан харуулбал:

График 6. ШЕЗ-ийн 2023 оны төсвийн бараа, үйлчилгээний зардал

³⁵ ШЕЗ-өөс ирүүлсэн албаны мэдээлэл



ШЕЗ-ийн 2023 оны батлагдсан төсөв болох 94,448,817.7 мянган төгрөгийн 99,7 хувь 94,178,817.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 0,3 хувь 270,000.0 мянган төгрөгийг шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна. Тухайн жилийн төсвийн 83.79 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл эзэлж байгаа бөгөөд үлдсэн 16.21 хувийн төсвөөр шүүхийн бие даасан байдлыг ханган, иргэн төвтэй шүүхийн тогтолцоог төлөвшүүлэх зорилт тавих ажиллахад хүндрэлтэй, түүнчлэн хөрөнгө оруулалтын зардлыг бага хувиар боловч батлаагүй үлдээсэн нь 2022 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсантай холбоотой гэж зарим тал тайлбарласан нь бий. Энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дүнд шинэ хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжих боломж үүсэж болох ч өмнө нь эхлүүлсэн зураг төсөл нь гарсан ажлыг тодорхой хугацаагаар зогсоож буй нь бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлэхэд эс үйлдэхүйгээр саад учруулжээ гэж дүгнэж болохоор байна.

Мөн ШЕЗ-ийн төсөв 2022 оны улсын төсвийн 0.68 хувийг, 2023 оны улсын төсвийн 0,54 хувийг тус тус эзэлжээ. ШЕЗ-ийн 2022 оны төсвийн төслийн саналыг 135,439,535.5 мянган төгрөгөөр нэмж хүргүүлснийг 56,242,871.2 мянган төгрөгөөр буюу 41,5 хувь (урсгал зардлаас 17,716,814.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 38,526,056.8 мянган төгрөг)-иар бууруулан баталжээ. Харин 2023 оны төсвийн төслийн саналыг 296,357,554.7 мянган төгрөгөөр өмнөх оны төсвийн төслийн саналаас нэмж хүргүүлснийг 205,472,307.1 мянган төгрөгөөр буюу 69,3 хувь (34,938,165.1 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 170,534,142.1 мянган төгрөг)-иар бууруулан баталсан байна.

ШЕЗ-ийн 2024 оны төсийн хувьд төсвийн төслийн саналыг 204,595,725.0 мянган төгрөгөөр өмнөх оны төсвийн төслийн саналаас нэмж хүргүүлсэн. Одоогийн байдлаар 184,742,795.5 мянган төгрөгөөр Хууль зүйн байнгын хороо хянасан байдалтай байна. Уг хянасан төсвийн зардал нь төсвийн төслийн саналаас 19,852,929.5 мянган төгрөгөөр буюу 10,7 хувиар бууруулан хянагдсан дүнтэй байна. Улсын төсөв өсөхийн хирээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын орон тоо, төсөв

өсөх хандлагатай байдаг бол шүүхийн төсөв зөвхөн шүүгчийн цалингийн зардлыг өмнөх оноос бууруулахгүй гэсэн зохицуулалтаар хамгаалагдан бусад зардал нь хасагдаж, хүртээмжтэй байдлаар батлагддаггүй хэвээр байна. Түүнчлэн ШЕЗ-ийн цалингийн сан нийт батлагдсан төсвийн 2022 онд 86.28 хувийг, 2023 онд 83.79 хувийг эзэлж байгаа нь өндөр дүнтэй харагдаж байгаа мэт боловч цалин бол шууд хүн амын хэрэглээний зардал юм.

УИХ-ын 2015 оны 101 дүгээр тогтоолоор бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноос хойших хугацаанд инфляцын түвшин өсөж 2 оронтой тооноос буураагүй, төгрөгийн ханш суларч валютын ханш чангарсан зэрэг нь бодит худалдан авалтад сөргөөр нөлөөлж байна. Шүүгчийн цалинг ийнхүү удаан хугацаанд тогтсон дүнгээр барих нь шүүгчийн эдийн засгийн баталгааг хөндөж буй хэрэг бөгөөд цаашид цалингийн хэмжээг өсгөх шаардлага үүсэж байна. Энэхүү өсөлтийг нэг дор өндөр хувиар өсгөх бус харин нарийвчилсан судалгааны үр дүнгээр улирал, хагас жилийн зайтайгаар 10-15 хувиар 2-оос доошгүй удаа нэмэгдүүлэн бодит худалдан авах чадварыг дээшлүүлэн нэг дор өндөр хувиар өсгөн төсөвт дарамт учруулахгүй зохицуулалт хийж буй зарим салбарын туршлагыг нэвтрүүлэх боломжтой дурдах нь зүйтэй болов уу.

ШЕЗ-ийн 2022, 2023 оны төсөв, 2024 оны төсвийн төслийн санал, батлагдсан төсвийн хувь хэмжээнээс дүгнэн үзвэл шүүхийн хөрөнгө оруулалтын зардлыг дийлэнх тохиолдолд хассан нь шүүхийн 41 тамгын газрын 43 байрны ажиллах орчин нөхцөл, анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн үйлчилгээний болон шүүх хуралдааны танхимын хүрэлцээ хангамж, анхан шатны шүүхийн шүүгч 384, давж заалдах шатны шүүхийн шүүгч 104 нийт 511 шүүгч, тамгын газарт ажиллаж буй төрийн захиргааны 855, төрийн үйлчилгээний 603 нийт 1458 албан хаагчийн³⁶, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх нь шууд зөрчиж байна. Мөн жил бүр Монгол Улсын нийт төсөв, ШЕЗ-ийн батлагдсан төсөв тодорхой хувиар өссөн дүн харагдаж байгаа ч энэ хэмжээгээр зардал, эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин тус бүр нөлөөлсөн байна. Түүнчлэн төсөв тодорхой хэмжээгээр өссөн ч тухайн байгууллагын цалингийн санд нийт төсвийн 84 орчим хувь нь зарцуулагдаж байгаагаас өдөр тутмын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсөв нь хангалттай бус байна. Мөн төсвийн хүртээмжгүй байдал нь шүүхээр үйлчлүүлж буй хүний эрх ашгийг хамгаалахад шүүх хуралдааны танхимын хүрэлцээ, техник технологийн дэвшилтэт тулгуурласан нээлттэй ил тод үйлчилгээ хангалтгүй нөхцөл байдалтай үргэлжилж байна.

1.3. Шүүхийн төсвийн хүрэлцээтэй байдал ба тулгамдаж буй асуудал

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойших 31 жилийн хугацаанд улсын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт шүүх эрх мэдлийн шинэтгэлтэй холбогдуулан тусгасан зорилт, арга хэмжээ, түүнчлэн тухайн шинэтгэлийг гүнзгийлүүлэх, эрчимжүүлэхэд чиглэсэн дагнасан бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж иржээ. Шүүхийн шинэтгэлийн тасралтгүй үргэлжлэх үйл явцад Шүүхийн тухай хуулийг 4 удаа шинэчлэн найруулж, хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2021 онд баталсан Шүүхийн тухай хуульд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй байхаар хуульчилсан.

³⁶ ШЕЗ-өөс ирүүлсэн албан мэдээлэл

Шүүхийн тухай 2021 оны хуулийн 5 дугаар зүйлийн 5.11-д Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүнийг Ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Улсын дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их хуралд уламжилна гэж хуульчилсан. Энэхүү зохицуулалтаас үзэхэд эрх зүйн шинэчлэлийг ардчилал, хүний эрх, эрх чөлөөг бүрэн хангахад чиглүүлэх, эрх зүйт төрийг бэхжүүлж, хуулийг бүх шатанд дээдлэх, хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэх, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх эрх мэдлийн ажиллагааг олон улсын стандартад хүргэх гэх мэт агуулгыг дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгаж, урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг тооцоолон тусгах шаардлага үүсэж байна. Монгол Улс хөгжлийн баримт бичгийг урт буюу 30 хүртэл жил, дунд буюу 10 хүртэл жил болон богино хугацааны гэсэн төрөлтэй байхаар хуульчилсан³⁷ бөгөөд дунд хугацааны буюу 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна. Энэ хүрээнд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого нь засаглалын зорилтот хөтөлбөр байх бөгөөд “Алсын хараа-2050”-ын 5.1 дэх зорилтын 2021-2030 оныг хамрах 1 дүгээр үе шатанд “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.” гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого нь дунд хугацааны хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг байх учиртай.

Монгол Улс 2000 онд Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн асуудлаар дагнасан бодлогын баримт бичиг “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г баталж, 30 зорилт, 101 арга хэмжээг хэрэгжүүлж, тус баримт бичигт 2022 онд хэрэгжилтийн үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээ хийлгэсэн байна. Энэхүү үнэлгээгээр тухайн баримт бичиг 92 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж, нийт 101 арга хэмжээний 86 арга хэмжээ “Бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 3 арга хэмжээ “Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн” 90 хувийн биелэлттэй, 4 арга хэмжээ “Гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа” 70 хувийн биелэлттэй, 2 арга хэмжээ “Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн” 50 хувийн биелэлттэй, 2 арга хэмжээ “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа” 30 хувийн биелэлттэй, 4 арга хэмжээ “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй байна гэж³⁸ үнэлэгджээ.

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-ний биелэгдээгүй болон хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн арга хэмжээний ихэнх нь шүүхийн төсвийн хүрэлцээгүй байдал гэж тодорхойлсныг анхааран санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шүүхийн төсвийн үр ашиг, удирдлагыг сайжруулах асуудлыг

³⁷ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020.

³⁸ Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээ. (2023). УБ., 98 дахь тал.

бодлогодоо тусган хэрэгжүүлэх хэрэгтэй³⁹ гэсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээг харгалзан үзэх нь зүйтэй.

ШЕЗ-өөс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчмыг удирдлага болгон ирэх 10 жилд шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж оролцоог хангаж хэлэлцүүлж “Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлого”-ыг гаргасан бөгөө энэхүү бодлогын баримт бичигт 7 зорилго, 13 зорилт, 93 арга хэмжээ, 130 шалгуур үзүүлэлттэй, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 629, 901.3 сая төгрөг⁴⁰ шаардлагатай гэж тооцоолол гаргажээ.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсөв байна. Шүүхийн төсвийн үрсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно. гэсэн хуулийн зохицуулалт нь сүүлийн төсвийн жилүүдэд “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолыг тус тус мөрдөн ажиллаж байна. Төсвийн хэмнэлтийн хүрээнд төрийн байгууллагуудын гадаад, дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах, сурталчилгаа хийх, бэлэг дүрсгалын зүйлс бэлтгэх, үралдаан тэмцээн, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, автомашин худалдан авах, захиргааны байгууллагуудад засвар тохижилт хийх болон бичиг хэргийн зардлын санхүүжилтийг түр хойшлуулах болон бууруулах арга хэмжээ авч байна. Хэдийгээр Засгийн газраас эдийн засаг, нийгмийн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн тэнцлийг сайжруулах зорилгоор төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай шийдвэр удаа дараа гаргаж ирсэн боловч зөвхөн тухайн санхүүгийн жилд хэрэгжиж цаашид тогтвортой мөрдөгдөхгүй байхын зэрэгцээ төсвийн байгууллагуудад тэгш бус үйлчилж ирсэн талаар дурдсан байна⁴¹.

Шүүхийн төсөв нь улсын төсвийн нэг хэсэг боловч эдийн засгийн болон улс төрийн шалтгаанаар өөрчлөгддөг байж таарахгүй бөгөөд бусад эрх мэдлээс хараат бусаар бие даасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц байх учиртай. Түүнчлэн шүүхийн төсвийн хүртээмжгүй байдал болон хэмнэлт хоёр цаашид хамтдаа үргэлжилбэл Урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан зорилт хэрэгжих боломжгүй болж төрийн эрх мэдэл хуваарилах онол үгүйсгэгдэж эрх мэдлийн хоорондын зөрчилдөөн өргөжих хандлага ажиглагдаж буйг тэмдэглэж байна. Шүүхийн эдийн засгийн засгийн баталгааг хангахад шийдвэрлэх шаардлагатай хамгийн эхний тулгамдаж буй асуудал бол бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлэхэд санхүүгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бие даасан механизмыг бүрдүүлэх, бэхжүүлэх явдал.

Шүүхийн үйл ажиллагаа явуулах төсөв, хэрэглэх хуулийг батлах бүрэн эрхийг хууль тогтоогч эдэлдэг бол гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоогчийн баталсан хуулийг Үндсэн хууль, хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын

³⁹ Шүүх эрх мэдлийн хөгжлийн хөтөлбөрийн төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ. Хөндлөнгийн судалгаа. Уб., 2023. 85 дахь тал

⁴⁰ ШЕЗ (2023.6 сар). “Шүүх эрх мэдлийн бодлого (зорилтот хөтөлбөр) батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн саналын танилцуулга.

⁴¹ Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт (2022.10.18). <https://www.parliament.mn/nn/18872/>

дагуу Үндсэн хуулиар бүрэн эрхийг нь тогтоох, бэхжүүлсэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь харилцан хяналт-тэнцлийн зарчмыг үл харгалзан бие биедээ нөлөөлөх, шүүмжлэх, элдэв шахалт үзүүлэх нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлсэн эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйл юм. Иймд Үндсэн хуулийн үзэлд баримтлалд нийцүүлэн, суурь зарчмыг салаа утгаар ойлгон үйл ажиллагаандаа удирдлага болгон ирсэн өмнөх 31 жилийн шүүхийн санхүүжилтийн алдааг залруулах, шүүх эрх мэдлийг улс төрийн хийгээд эдийн засгийн хараат байдлаас гаргах талаар хийж ирсэн туршлагад тулгуурлан шүүхийн төсөвлөлтийн ил тод, хүртээмжтэй байдлаар боловсруулан батлуулах, шүүхийн батлагдсан төсвийн хуваарилалт, тайлагналын хариуцлагатай байдлыг бэхжүүлэх хүрээнд зарим салбарт туршин хэрэгжүүлж буй төсвийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан удирдлагыг харгалзан үзэж болох юм.

Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 5.1 дэх зорилтын 1 дүгээр үе шат (2021-2030 он)-нд "Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө." гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан "Зорилт 4.1.2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050" Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах эдийн засгийн баталгааг хангахад Төсвийн тухай хууль(2022.11.11)-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/4 дүгээр зүйлийн 4.1.5б дахь заалт: "4.1.5б."гүйцэтгэлд суурилсан санхүүжилт" гэж хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, төрийн үйлчилгээний чанар зэрэг гарцын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилахыг." гэсэн нэмэлтийн дагуу иргэдийн шүүхэд хандах эрхийг хангах, шүүхийн үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд чиглэсэн төсөвлөлтийг шүүхэд хэрэгжүүлэх шаардлага үүсэж буйг тэмдэглэж байна.

Монгол Улс 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн цогц шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж, 2021 оноос лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагыг, 2022 оноос анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлж, санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад үүсэж буй асуудлыг тухай бүр Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд оруулсан өөрчлөлтийн тухай хуулийн 1/3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт: "3.1.8."тохиолдолд суурилсан төлбөрийн арга" гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тохиолдол бүрээр зардлыг урьдчилж багцлан тооцож санхүүжүүлэхийг." 2/16 дугаар зүйлийн 16.6.4 дэх заалт: "16.6.4.батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон цалингийн санд багтаан ажилтны ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, ажилтны нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах;" гэж эмнэлгийн даргын нийтлэг чиг үүргийг өөрчлөн найруулсан. Эрүүлийн мэндийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн 1 дүгээр зүйлээр "24.6.10.эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ."-г нэмж, 2 дугаар зүйлээр "24.2.Энэ хуулийн 24.6.3, 24.6.4-т заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх болон хяналт тавих журмыг холбогдох хууль

тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална." "24.4.Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн энэ хуулийн 24.6.10-т заасан тусламж, үйлчилгээнээс бусад тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс авна." гэж нэмэлт, өөрчлөлт оруулан ажилласан байна. Хэдийгээр эрүүл мэндийн салбарын хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх эхний алхам болж байсан ч Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг өөрчлөхгүйгээр тухайн төсөвлөлтийн загварыг туршин хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдал үүссэн байна. Тухайлбал, Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн жилийн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд "Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт "Энэ хуулийн 7.7 дахь хэсэг төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагчид хамаарахгүй" гэж заасан нь дээрх эрүүл мэндийн байгууллагад хамааралгүй байна" гэх үндэслэлээр дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэх тухай 2021 онд 114.1 сая төгрөгийн акт, 2022 онд 1.4 тэрбум төгрөгийн зөвлөмж өгсөн байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн зарчмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Төсвийн хуульд оруулж ирснээр тодорхойлогдож байна.

Харин боловсролын салбарт хэрэгжүүлж буй гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг салбарын хуулийн шинэчилсэн найруулгаар тодорхойлон нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал, Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална. Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллын санхүүжилт; 38.3.Энэ хуулийн 38.1.3-т заасан нэмэлт урамшууллын санхүүжилтийг олгоход боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл, чанар, үр дүнгийн үнэлгээ нь сургалтын чанар, суралцагч бүрийн суралцахуйн үр дүнд гаргасан ахиц, тухайн байгууллагын засаглал, ил тод байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар хийсэн хөндлөнгийн үнэлгээнд үндэслэх бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална. 38.4.Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно. гэж хуульчилсан байна.

Сангийн яам Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид⁴² 2.2 Төсвийн үрсгал зардлын талаар 2.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн үрсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх; 2.2.4 Эрүүл мэнд болон боловсрол, шинжлэх ухааны салбарт туршиж байгаа үр дүнд суурилсан дунд хугацааны төсөвлөлтийн хувьд шинэчилсэн маягтын дагуу боловсруулж ирүүлэх. Боловсрол шинжлэх ухааны салбарын үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо 1.4. Тогтвортой хөгжлийн зорилго үр дүн тодорхойлох заавар (БШУЯ) ашиглан бэлтгэнэ гэжээ. Төсвийн төсөл бэлтгэх удирдамж нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.56-д оруулсан нэмэлтийн дагуу боловсруулагдсан бөгөөд цаашид бусад салбар ч гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд

⁴² Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. Дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-07-05): <https://mof.gov.mn/article/entry/>

шилжих алхмыг эрүүл мэндийн болон боловсролын салбарын нэгэн адил бүхэлд нь туршин хэрэгжүүлэх, эсхүл салбарын онцлогийг харгалзан хүний нөөцийн, дэд бүтцийн, хөрөнгө оруулалтын гэх мэт төсвийн тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилах хууль зүйн орчин бүрдсэн байна. Үүнийг Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын баримт бичгийг 10 жилийн хугацаатайгаар батлан хэрэгжүүлэхдээ мөн Хоёрдугаар бүлэгт судалсан гадаадын зарим орны шүүхийн төсөвлөлтийн талаарх олон улсын байгууллагын зөвлөмжийн хүрээнд тодорхойлсноор төсвийн удирдлагын тогтолцоог өөрчлөх боломжтой. Шүүхийн цалингийн сангийн төсөвлөлт нь шүүгчийн хувьд өмнөх жилийг төсвөөс бууруулахгүй батлах хуулийн хамгаалалттай хэдий ч хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтээс хамааран шүүгч, шүүхийн ажилтны ажлын ачаалал хүн амын төвлөрлөөс хамааран харилцан тэнцвэргүй хэвээр байна. Энэхүү ачаалалтай холбогдуулан тохирсон цалингийн нэмэгдэл, урамшууллыг цалингийн сандаа багтаан төсвийн ерөнхийлөн захирагч шийдвэрлэж байх хууль зүйн үндэслэл эрүүл мэнд, боловсролын салбарт хангалттай бүрдсэн бөгөөд шүүх ч энэхүү гүйцэтгэл болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн загварт шилжих нь цаг хугацааны асуудал юм. Тухайлбал, ШЕЗ төсвийн жилийн төвлөрүүлэн буцаалтаар цалингийн сангаас 2021 онд 628,055,569, 2022 онд 4,026,281,028⁴³ мянган төгрөгийг буцаасан бөгөөд энэхүү санхүүжилтийг үр дүнтэй, хяналттай зарцуулан хүний нөөцийн эдийн засгийн баталгааг бэхжүүлэх боломжтойг судлан үзэж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй юм.

Шүүхийн хөрөнгө оруулалтын төсвийг огт батлахгүй, бага дүнтэйгээр баталж ирсэн нь шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад тулгамдаж буй асуудлын нэг хэвээр үргэлж байна. Шүүхийн байрны асуудлыг нэн түрүүнд анхааран үе шаттайгаар төлөвлөн шийдвэрлэх шаардлагатай байна. Тухайлбал, зарим аймаг, дүүрэг дэх шүүхүүд актлагдсан буюу ашиглалтын шаардлага хангахгүй болсон байранд, зарим нь өөрийн байргүй түрээсийн байранд эсвэл бусад төрийн байгууллагатай хамт нэг байранд үйл ажиллагаа явуулж байгааг Хүснэгт 8 болон 9-өөр харуулав.

Хүснэгт 8. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж буй шүүх

№	Байгууллагын нэр	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр		Тайлбар
		Түрээслүүлэгч	Түрээслэгч	
1	Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газар	Засаг даргын тамгын газрын байр	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	Засаг даргын тамгын газрын байранд ашиглалтын зардал төлөн үйл ажиллагаагаа явуулж байна.
2	Дархан-Уул аймаг дахь Анхан шатын шүүхийн тамгын газар	Оросын холбооны улсын ерөнхийлөгчийн хэрэг эрхлэх газар	Дархан-Уул аймаг дахь, анхан шатын шүүхийн тамгын газар	Үйл ажиллагаа явуулж буй байр 1975 оны ашиглалтад орсон бөгөөд 880 долларын сарын түрээсийн төлж жил бүр гэрээ хийж түрээсийн гэрээг сунгаж байна.
3	Багануур дүүргийн Шүүхийн тамгын газар	Засаг даргын тамгын газрын байр	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	Дүүргийн Засаг дарга, Шүүхийн тамгын газрын дарга, Нийслэлийн өмчийн харилцааны газар 3 хамтарсан гэрээ хийсэн жил болгон түрээсийн гэрээг сунгаж байна.

⁴³ ШЕЗ-өөс ирүүлсэн албан мэдээлэл

4	Өмнөговь Ханбогд сум дахь Шүүхийн тамгын газар	Засаг даргын тамгын газрын байр	Өмнөговь Ханбогд сум дахь шүүхийн тамгын газар	Засаг даргын тамгын газрын байранд ашиглалтын зардал төлөн үйл ажиллагаагаа явуулж байна. /ЗДТГ-ын бүртгэлтэй, 2009-2013 онуудад ашиглаагүй, тагтаа, шувуу үүрлэсэн. 1960 оны чулуун барилгыг засаж, янзлаад 2013 онд шүүх орсон/
5	БЗД дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	Кино үйлдвэрийн байр	БЗД-ийн Иргэний хэргийн АШШ	Жил, жилээр гэрээ байгуулдаг.
6	СБД, ЧД дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	Иргэн	Шүүхийн 3-р байр	Жил, жилээр гэрээгээ байгуулдаг.
		Засаг даргын тамгын газрын байранд	БЗД, СБД, ЧД-ийн иргэний хэргийн АШШ	Засаг даргын тамгын газрын байранд ашиглалтын зардал төлөн үйл ажиллагаагаа явуулж байна. Бүрэн засвар хийсэн.
7	Шүүхийн ерөнхий зөвлөл	Засгийн газрын 11-р байр	Шүүхийн сахилгын хороо /ШЕЗ-д эзэмшүүлэх шийдвэртэй/	Засгийн газрын 11-р байрны 7 давхрыг ашиглаж байгаа. Жил жилээр гэрээгээ хийдэг. Анх түрээслэхдээ 7,10 давхар түрээсэлдэг байсан.
		Түшээ дээд сургууль	Шүүхийн тусгай архив	Жилээр гэрээ хийсэн.1 м.кв-11620 төгрөг

ШЕЗ-ийн урсгал зардлаас шүүхийн байрны түрээсийн төлбөрт 2021 онд 437,273,655, 2022 онд 406,726,600, 2023 онд 564,409,600⁴⁴ мянган төгрөг өгсөн бөгөөд энэ төлбөрөөс гадна шүүхийн байр ашиглалтын зардал, олон оролцогчтой хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны танхим түрээслэх зардал шүүхийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал хэвээр байна.

Хүснэгт 9. Прокурорын байгууллагуудтай нэг байранд үйл ажиллагаагаа явуулж буй шүүх

№	Тамгын газрын нэр	Ашиглалтад орсон он	Ашиглах хугацаа /жилээр/	Талбайн хэмжээ м2	Эзэмшил
А	1	3	4	5	6
1	Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар	2008.08.01	60 жил	840 м2	Шүүх, прокурор хамт байрладаг.
2	Өмнөговь аймаг дахь Шүүхийн тамгын газар	1981.12.31	60 жил	814.75 м2	Шүүх, прокурор хамт байрладаг.
3	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн тамгын газар	1986	60 жил	630 м2	Шүүх, прокурор хамт байрладаг.

⁴⁴ ШЕЗ-өөс ирүүлсэн албан мэдээлэл

4	Увс аймаг шүүхийн Тамгын газар	2007.12 сар 2008.01.01	40 жил	893 м2	Шүүх, прокурор хамт байрладаг.
5	Хэнтий аймаг дахь Шүүхийн тамгын газар	1961	60 жил	978.6 м2	Шүүх, прокурор хамт байрладаг.
6	Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар	09.01.01	60 жил	2741.6 м2	Прокурор хамт нэг байранд байсан. 2022 онд Прокурор шинэ байрандаа орсон. /Балансаас балансад шилжүүлэх шийдвэр гараагүй/
7	Хөвсгөл аймаг дахь Шүүхийн тамгын газар	1976	60 жил	1152 м2-аас 887 м.кв ашигладаг.	Прокурор хамт нэг байранд байсан. 2022 онд Прокурор шинэ байрандаа орсон. /Балансаас балансад шилжүүлэх шийдвэр гараагүй/

Анхан болон давж заалдах шатны 116 шүүх 129 шүүх хуралдааны танхимтайгаар, 41 тамгын газрын 43 байранд үйл ажиллагаа явуулж байгаагаас 17 шүүх өөрийн байргүй, үлдсэн 26 шүүхийн байр нь зориулалтын бус, стандартын шаардлага хангахгүй, ашиглалтын зай талбай багатай барилгад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид шүүх хуралдааны танхим, зөвлөлдөх тасалгааны тоог нэмэгдүүлэх ч боломжгүй байна.⁴⁵ Үүнийг Монгол Улсад анх удаа боловсруулсан Шүүхийн индекс 2021-д авагдсан олон нийтийн санал асуулгын дүн шинжилгээнд хамгийн бага оноо авсан шалгуур үзүүлэлтэд Шүүхийн байр шударга ёсыг илэрхийлсэн, хүндэтгэл төрүүлэхүйц орчин, дэд бүтцээр хангагдсан байдаг (36.71 оноо)⁴⁶, мэргэжилтнүүдийн санал асуулгын дүн шинжилгээнд хамгийн бага оноо авсан шалгуур үзүүлэлтэд шүүхүүд шаардлага хангасан байранд байрладаг бөгөөд ажиллахад хангалттай өрөө, тасалгаа, зай талбайтай байдаг (29.35 оноо), шүүхийн байр шударга ёсыг илэрхийлсэн, хүндэтгэл төрүүлэхүйц орчин, дэд бүтцээр хангагдсан байдаг (30.97 оноо)⁴⁷ гэж үнэлсэн нь шүүхийн төсвийн хүрэлцээгүй байдал, хөрөнгө оруулалтын зардлыг тогтмол хасаж, төсөвлөсөн төсвийг бууруулан баталж өгсөн ирсний сөрөг үр дагавар гэж дүгнэж байна.

Шүүхийн байрны одоогийн нөхцөл байдлыг цөөн зургаар харуулбал:

Зураг 1. Шүүх хуралдааны танхим

Зураг 2. Шүүх хуралдааны танхимын багтаамж, хүн хоорондын зай талбай

⁴⁵ ШЕЗ-өөс ирүүлсэн албан мэдээлэл

⁴⁶ Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ (2022). Шүүхийн индекс 2021. 62 дахь тал.

⁴⁷ Мөн тэнд. 65 дахь тал.



ШЕЗ-өөс 2014 оны 100 дугаар тогтоолоор “Шүүхийн байрны нийтлэг шаардлага”-ыг баталсан ч өнөө хир нь энэхүү шаардлага нийцсэн шүүхийн байр цөөн, шүүхийн байрны анхны зориулалтаас хамаарч шүүхийн байрны иргэнд үйлчлэх хэсэг, шүүгчийн ажлын өрөө, шүүхийн ажилтны ажиллах хэсэг, шүүх хуралдааны танхимын зай талбай харилцан адилгүй байна.

Зураг 3. Хөгжлийн банканд хамааралтай нэр бүхий 84 шүүгдэгчид холбогдох шүүх хурал
Улаанбаатар чуулгын танхим (2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр)



Олон шүүгдэгчтэй хэргийн шүүх хурлыг томоохон үзвэр, үйлчилгээний газрын талбайг тухайн шүүхийн тамгын газраас түрээслэн зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр хэргийг хянан шийдвэрлэх зардал нь тухайн шүүхийн тамгын газрын жилийн төсвөөс давах тохиолдол цөөнгүй бөгөөд энэ нь бусад хэрэг маргаан шийдвэрлэх зардал нөлөөлдөг байна.

Шүүхийн тухай 46 дугаар зүйлийн 46.8.1-т Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх гэсэн шинэ зохицуулалт Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны төсвийн төслийг ХЗБХ-оор хэлэлцүүлснээр хэрэгжиж эхэлсэн. Өмнө нь Сангийн яаманд Шүүхийн төсвийн төсөл хянагдаж хасагдаад улсын төсөвт нэгтгэгддэг байсан бол ийнхүү Шүүхийн хуулийн шинэ зохицуулалтаар ХЗБХ хянаж байна. Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.2-т Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх; 46.8.3-т Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр

улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; гэж заасны дагуу хянагдсан төсвийг төсвийн ерөнхийлөн захирагчид өргөн хүргүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчаас Сангийн яаманд. Сангийн яам, Засгийн газраар оруулаад Их Хуралд өргөн мэдүүлж байна. УИХ-аар хэлэлцүүлэх хүртэл хянагдсан төсвийг бууруулахгүй байх хориглосон зохицуулалтыг тусгаснаар Засгийн газрын төсвийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн бүрэн эрхийг хязгаарласан байна. Мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.4-т Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх гэсэн хуулийн заалтын хэрэгжиж, УИХ төсвийн хууль батлахдаа шүүхийн төсвийг хасах, өөрчлөх эрх хэмжээ нь нээлттэй.

Шүүхийн тухай хуулийн дээрх шинэлэг зохицуулалт хэрэгжиж эхэлснээр өмнө нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1. жилийн төсвийн хязгаарт⁴⁸ багтаан төсвийн төслийг боловсруулан хүргүүлж төсвийн төслийн саналаас 40-өөс дээш хувиар бууруулан улсын төсөвт нэгтгэдэг байсныг халж, шүүхийн 2023 оны төсвийг ХЗБХ-ны⁴⁹ хянасан эцсийн хувилбарын дагуу Монгол Улсын төсөвт нэгтгэсэн баталжээ. Хэдийгээр ХЗБХ шүүхийн төсвийг хянаж, Сангийн яаманд хүргүүлж, улсын төсөвт нэгтгүүлж байгаа энэхүү зохицуулалт нь шүүхийн төсвийн Засгийн газраас хараат байдлыг бууруулж буй сайн тал ажиглагдаж байгаа хэдий ч төсвийг хянаж буй байнгын хороонд шүүхийн төсвийг бууруулах эрх хэмжээг олгож байх талтай. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022⁵⁰, 2023⁵¹, 2024⁵² оны төсвийн төслийг ХЗБХ-оор хянасан хуралдааны тэмдэглэлтэй судалгааны агуулгын хүрээнд танилцахад ажиглагдсан болно. Түүнчлэн шүүхийн төсвийн талаарх шинэлэг зохицуулалт нь зарим эерэг өөрчлөлтийг эхлүүлж буй тал ажиглагдлаа. Үүнд: 1) Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц төсвийг зардал тус бүрээр гаргасан нарийвчилсан, хэрэгцээ, шаардлагаа тодорхойлсон судалгаанд үндэслэн баталж өгөх нь хууль тогтоох эрх мэдлийн үүрэг мөн гэдгийг хүлээн зөвшөөрч буй; 2) Шүүхээс эрх зүйн маргаан хянан шийдвэрлэсэн үйлчилгээний хураамжийг шүүхийн хянагдсан төсвийг УИХ-д нэгтгэн хүргүүлэхдээ Засгийн газар төсвийн орлого төвлөрүүлэгчийн бүрэн эрхийн хүрээнд харгалзан үзэх зүйтэй; 3) Шүүхийн төсвийг Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн

⁴⁸ Төсвийн тухай хууль (2011)-ийн 4.1.8. "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

⁴⁹ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 7 дугаар сарын 22-ны УИХ-13/7376 дугаар албан бичиг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны төсвийн тухай.

⁵⁰ УИХ-ын 2021 оны Хаврын ээлжит чуулганы ХЗБХ-ны 7 дугаар сарын 06-ны өдөр /мягмар гараг/-ийн хуралдаанаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны 2022 оны төсвийг хэлэлцсэн тэмдэглэл.

⁵¹ УИХ-ын 2022 оны Хаврын ээлжит чуулганы ХЗБХ-ны 7 дугаар сарын 05-ны өдөр /мягмар гараг/-ийн хуралдаанаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны 2023 оны төсвийг хэлэлцсэн тэмдэглэл.

⁵² УИХ-ын 2023 оны Хаврын ээлжит чуулганы ХЗБХ-ны 6 дугаар сарын 27-ны өдөр /мягмар гараг/-ийн хуралдаанаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн үндэсний комиссын 2024 оны төсвийг хэлэлцсэн тэмдэглэл.

боловсруулсан “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” засаглалын зорилтот баримт бичгийн зорилго, зорилтын хүрээнд оновчтой төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлтийг өргөн хүрээнд харж шүүхийн төсвийг 3-5 жилээр уялдуулан төсөвлөх, төсвийг хэн хянаж, хэн баталж буйгаас үл шалтгаалсан тогтолцоонд шилжих нь хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Бүлгийн дүгнэлт

Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3-т Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэж суурь зарчмыг бэхжүүлснээр шүүхийн санхүүжилтийг ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлаар боловсруулан батлуулах хэрэгцээ шаардлага өнөө хир нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Шүүхэд 1993-2002 онд зохион байгуулалтын шинэчлэл хийгдэж, шүүхийн төсвийн хүртээмжгүй байдлыг судлан үзэж, улсын төсвийн тодорхой хувьтай тогтмол дүйцүүлэн баталж буй гадаадын зарим улсын түршлагыг судлан үзэж, 2012 онд хуульчлах оролдлого хийж ч үр дүнд хүрээгүй байна. Чухамдаа улсын төсвийн тодорхой хувьтай дүйцүүлэн батлах нь эрх мэдэл хоорондын нөлөөлөл шахалтыг бууруулах талтай боловч, тухайн улсын нийгэм эдийн засгийн өсөлт, бууралттай холбогдож байх тул харьцангуй тогтворгүй бөгөөд үр дүнгүй үзүүлэлт юм. Харин энэхүү үзүүлэлтээр хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс байгуулагдсан, ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын санхүүжилттэй харьцуулан судлан үзвэл шүүх эрх мэдлийн эдийн засгийн баталгааг хир хангаж буйд дахин нэг өнцгөөс хариулт авч болох юм.

Шүүхийн тухай 2012, 2021 оны хуульд шүүхийн төсөв, шүүгчийн цалингийн санг өмнөх жилийн төсвөөс бууруулахгүй гэж хуульчилсан ч төсвийн хэмнэлтийн үед шүүхийн үрсгал зардлыг бууруулж болохуйц эрх олгосон болон хязгаарласан зохицуулалтыг нэг зүйл хэсэгт хуульчлан өнөөдөр хэрэгжүүлж байна.

Шүүхийн төсвийг батлах үйл ажиллагаа нь гүйцэтгэх эрх мэдлийн нэг байгууллагын төсөв хянах, батлах үйл явцтай адил зохицуулалттай байсан бол Шүүхийн тухай хууль 2021 онд батлагдсанаар шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хороо хянаж, Сангийн яаманд хүргүүлэх зохицуулалтыг шинээр мөрдөгдөж байна. Ийнхүү хяналтын үе шатыг нэмэгдүүлсэн нь гүйцэтгэх эрх мэдлийн хэрэгжүүлдэг төсвийн хяналтыг урьдчилан хэрэгжүүлж, шүүхийн санхүүжилттэй холбоотой шинэчлэн баталсан хуулийн зүйл, хэсэг, заалтыг бүрэн хэрэгжүүлэх, шүүхийн төсвийн ил тод, хүртээмжтэй байдлыг бэхжүүлэхэд цаашлаад УИХ-аар тухайн төсвийг батлахад дэмжлэг үзүүлж байгаа юм.

Шүүх санхүүжилтийн хүртээмжгүй байдлаа шийдвэрлэх арга замыг хайсаар ирсэн бөгөөд улсын болон орон нутгийн төсөвт оруулж буй улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн тусгай архивын үйлчилгээний төлбөр зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд төсөвт орлого төвлөрүүлэгчийн үүргийг гүйцэтгэж иржээ. Эдгээр орлогыг улсын төсөвт өмнөх 2 жилийн орлоготой харьцуулан сүүлийн жилд 2 дахин нэмж ШЕЗ-ийн даргын багцад нэмсэн байх жишээтэй. Энэ шүүхийн бие даасан байдалд жил жилийн төсвийн хуулиар халдаж буй нэг хэлбэр юм. Түүнчлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй улсын тэмдэгтийн хураамж нь зарим жилд шүүхийн төсвийн 50 хүртэл хувьтай дүйцсэн тоон мэдээ гарсан нь орон нутгийн шүүхэд хөрөнгө оруулалт болгон дахин хуваарилах боломжийг гүйцэтгэх эрх мэдэлд олгож буй хэрэг. Гэхдээ шүүх

байгууллага нь улсын төсвийн орлого бүрдүүлэгчийн үүрэг хүлээхгүй бие даасан эрх мэдэл хэрэгжүүлэгч бөгөөд энэхүү эрх мэдлийн эдийн засгийн баталгааг гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдэл хангах үүргийг аль ч улсад хүлээж байгаа юм.

Шүүхийн 2022, 2023 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд шүүхийн цалингийн сангийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэн буцаан таталт хийж байгаа болон хөрөнгө оруулалтыг зардлыг огт батлахгүй болон бага дүнтэй баталж буй олон жилийн сөрөг үр дагаврыг цаашид залруулах, шүүхийн төсвийн талаарх Үндсэн хуулийн баталгааг бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатайг илэрхийлсэн байна.



ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮХИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Бүлгийн танилцуулга

НҮБ-ын “Шүүхийн хараат бус байдлын талаарх суурь зарчим”-ын 1-д Шүүхийн бие даасан байдал нь төрөөс баталгаажуулж, тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусган баталгаажуулна. ... Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд хүндэтгэж, сахин биелүүлнэ. 7-д Шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх боломж олгох хүрэлцээтэй төсөв, хангамжаар хангах нь гишүүн улс бүрийн үүрэг мөн⁵³ гэж тунхагласан нь шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах нь дэлхий нийтээр баримталж байгаа зарчим болж хүлээн зөвшөөрөгдсөн. Мөн Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай 2013 оны Софигийн тунхаглалын 4-т “Санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, захиргааны бие даасан байдал нь бие даасан, хараат бус шүүхийн зайлшгүй хамгаалалт мөн”; 5-д “ Шүүхийн хараат бус байдлын хамгаалалт нь шүүхийн төсөв, тэдний ажлын нөхцөл байдалтай холбоотой бүхий л асуудлыг авч үзэх, засгийн газарт санал, зөвлөмж гаргах эрх бүхий шүүхийн зөвлөл, эсхүл түүнтэй адил бие даасан байгууллагаас зохих ёсоор чиг үүргээ хэрэгжүүлснээр хэрэгжих боломжтой”⁵⁴ гэж заажээ. Европ дахь шударга ёсны ирээдүйн асуудлаарх Варшавын Тунхагт 1) шүүхийн бие даасан байдал; 2) шүүх, шүүгчийн хариуцлагатай байдал; 3) шүүхийн төсөв, хангамжийн асуудал; 4) ирээдүйд цахим хэлбэрээр шүүн таслах ажиллагааг явуулж, иргэдэд хүндрэлгүй цаг хөрөнгө хэмнэсэн арга, хэлбэрийг өргөнөөр нэвтрүүлэх шаардлагатай байгаа зэрэгт баримтлах арга, шийдлийг тусгасан байна⁵⁵.

Олон улсын баримт бичиг болон нийтлэг жишгийг үндэс болговол шүүхийн хараат бус байдал дараах үндсэн хэсгээс бүрдэж байна. Тухайлбал, 1) шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил эрх зүйн байдалтай төрийн бие даасан эрх мэдэл юм; 2) хараат бус байдлаа хадгалахын тулд шүүх нь бодлогоо өөрөө тодорхойлно; 3) шүүхийн төсвийг өөрсдөө боловсруулж, хууль тогтоох байгууллагад батлуулахаар оруулна; 4) шүүгчийг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод байна; 5) шүүгчийг хугацаагүй томилно; 6) шүүгчийн цалин нь амьдралд хүрэлцээтэй байх ёстой; 7) шүүгчид боловсрол, туршлагын хувь наад захын өндөр шаардлага хангасан байна; 8) шүүгчийг дэвшүүлэх нь түүний мэргэжлийн мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр хэрэгжинэ; 9) шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцруулах ажиллагааг гагцхүү сахилгын зөрчил гаргасан, эсхүл ажил эрхлэх чадваргүй болсны үндсэн дээр ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгчдээс бүрдсэн сахилгын хороогоор хэрэгжүүлэх учиртай⁵⁶.

Дэлхий дахинаа төсөвлөлтийн уламжлалт хандлагаас үндсэндээ зайлсхийж 1980 оны үеэс өөр өөрийн улсын онцлогт тохируулан гарц болон үр дүнд суурилсан үзэл баримтлалд суурилан улсынхаа төсвийг баталж ирсэн нь түүхэнд Нийтийн удирдлагын шинэ тогтолцоо (New Public Management) гэсэн нэрээр үлдсэн байна.

Үүний зэрэгцээ дэлхийн зарим улс орнуудад 1990 оны үеэр хэргийн ачаалал нэмэгдэж, санхүүжилт буурсны улмаас хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх хугацаа уртсаж, иргэдийн шүүхэд итгэх итгэл буурч эхэлсэн тул шүүхийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, цаг

⁵³ ШЕЗ (2019). Шүүхийн хараат бус байдал. Уб., 9 дэх тал.

⁵⁴ Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал (2013). Шүүх эрх мэдэл. Уб., 2015. №4. 53-55 -р тал.

⁵⁵ ШЕЗ (2019). Шүүхийн хараат бус байдал. Уб., 303-304 дэх тал.

⁵⁶ Энхбаатар, Ч., нар. (2016) Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Уб., 114 -р тал.

хугацаа хэмнэсэн хэлбэрт шилжүүлэх шаардлага үүссэн гэж зарим эх сурвалжид дурджээ.⁵⁷ Харин энэхүү асуудлыг шийдвэрлэх гарц нь өмнө дурдсан нийтийн удирдлагын шинэ тогтолцоо мөн гэж судлаачид үзэх нь нийтлэг байна. Уламжлалт төсөвлөлтийн арга барилыг авч үзвэл тодорхой нэг этгээд шийдвэр гарган шүүхийн төсвийг батлах нь шүүх тус бүрийн төсвийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлох, өмнөх хугацаанд гарсан үр дүнтэй холбон дараагийн төсвийг батлахад сөрөг нөлөөтэй бол шүүхийн гүйцэтгэлд суурилан дараагийн төсвийг батлах нь илүү үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай гэсэн байр суурийг судлаачид илэрхийлж байна.

Өнөө цагт дэлхийн улс орнуудад шүүхийн төсөвлөлтийн хамгийн нийтлэг гурван загвар хэрэгжиж байна. Үүнд:⁵⁸

1. **Тэгд суурилсан төсөвлөлт (Zero-based):** Энэ хэлбэр нь шүүх тус бүр ирэх жилийн төсвөө цоо шинээр зохион бүрдүүлж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн батлуулдаг онцлогтой.
2. **Аажмаар өсөх төсөвлөлт:** Тухайн жилийн төсөв нь өмнөх жилийн төсөвт үндэслэх шинжтэй төсөвлөлтийн хэлбэр бөгөөд эдийн засаг султай улс орнуудад илүү зохицно. Гэвч Хорват, Герман, Молдав зэрэг улс орнуудад энэ хэлбэрээр шүүхийг санхүүжүүлж байгаад санхүүжилт нь хүрэлцэхгүй болж дэд урсгал зардал болон хүний нөөцийн зэрэг зарим төрлийн зардал дутагдаж байсан түүхтэй.
3. **Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт:** Энэ хэлбэр нь шүүхийн үйл ажиллагааны үр дүнгийн хэмжүүрээр илэрхийлсэн үзүүлэлтүүдэд үндэслэн суурь төсөв болон төсвийн тодотголыг боловсруулдаг онцлогтой. Нидерланд, Дани, Франц, ИБУИНВУ болон АНУ-ын зарим муж улсуудад энэ байдлаар шүүхийн санхүүжилтийг шийдвэрлэдэг байна.

Энэхүү судалгааны ажилд ашигласан гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, үр дүнд суурилсан төсөвлөлт гэсэн хоёр нэр томъёотой холбогдуулан зарим тайлбар хийх шаардлагатай гэж үзэж байна. Төсөл хөтөлбөрт суурилсан төсөвлөлт (Program budgeting) гэх нэр томъёоны эх үүсвэр нь Дэлхийн II дайны дараа 1950 оны үед АНУ-д бий болсон бол энэ нь цаашид гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт гэдэг ойлголт болж хөгжсөн⁵⁹ байна. Үр дүнд суурилсан төсөвлөлт гэдэг ойлголт ч мөн л гүйцэтгэлд суурилсан төсөвлөлттэй бараг зэрэгцэн үүсэж бас хөгжиж ирсэн ойлголт юм. Зарим судлаачид үр дүнд суурилсан төсөвлөлтийг гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт гэж өөрөөр нэрлэж байгаа гэж үздэг ч тохиолдол байна.⁶⁰ Эдгээрээс дүгнэвэл гүйцэтгэлд суурилсан болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн аль аль нь үйл ажиллагааны орцод бус гарцад чиглэсэн шинжтэй бөгөөд гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт нь гарцыг илүү үр ашиг, үр нөлөө талаас нь харин үр дүнд суурилсан төсөвлөлт нь ирээдүйд хүрэх үр дүн талаас нь илүү харгалзан үзэж төсвийн эх үүсвэрийг хуваарилдгаараа л ялгаатай гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл үр дүнд суурилсан төсөвлөлт нь улс орны эсвэл тодорхой шүүхийн хүрэхээр тодорхойлсон үр дүнтэй илүү холбоотойгоор, тухайн үр дүнг бий болгоход чиглэсэн байдлаар төсвийн эх үүсвэрийг хуваарилж

⁵⁷ Federica Viapiana, A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies, дараах холбоосоор хандаж үзнэ үү: <https://www.emerald.com/insight/1096-3367.htm> (2023.08.23)

⁵⁸ Federal Judicial Center. Judiciaries Worldwide. Budget Process. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://judiciariesworldwide.fjc.gov/budget-process>

⁵⁹ International Monetary Fund. From Program to Performance Budgeting: The Challenge for Emerging Market Economies. 2003. IMF working paper WP/03/169. дараах холбоосоор хандаж үзнэ үү (-2023-09-02): <https://www.imf.org/external/pubs/ft/wp/2003/wp03169.pdf>

⁶⁰ Review: Performance Measurement: Getting Results. Public Performance & Management Review. Vol. 25, No. 3 (Mar., 2002), pp. 329-335. Дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://economia.uniandes.edu.co/sites/default/files/imagenes/eventos/chapter13.pdf>

зохицуулдаг бол гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт нь тухайн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилсан байдлаар гарцыг илүү үр нөлөөтэй, илүү үр ашигтай байдлаар санхүүжүүлэхэд төсөвлөлтийг хандуулах шинжтэй байна. Мөн эдгээрийн аль аль нь судалгаанд суурилсан байдлаар төсвийн эх үүсвэрийг хуваарилахыг шаарддаг шинжээрээ ижил төстэй гэж үзэж болох юм.

Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд шүүхийн төсвийг шүүхийн үйл ажиллагааны гүйцэтгэлтэй нь нягт холбож боловсруулах загвар нь тухайн улсын шүүхүүдэд төсвийг илүү тэгш шударгаар хуваарилах баталгаа болохоос гадна эргээд шүүхүүдийн гүйцэтгэл ижил тэгш болоход тодорхой нөлөөлөл үзүүлдэг байна⁶¹.

Стратеги төлөвлөлт болон гүйцэтгэлийн хэмжүүрийг нэгтгэсэн загвар нь менежментийг улам сайжруулахаас гадна нэгэнт энэ загварыг ашиглаж хэвшсэн тохиолдолд үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх үндэслэл бүрддэг байна. Зарим судлаачдын үзэж буйгаар Их Британи, Австрали, Шинэ Зеланд улс нь гүйцэтгэлд суурилсан менежментийн шинэчлэлтийг нэвтрүүлсэн байдлаараа дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд эдгээр улс орнууд цаашид орцод чиглэсэн (input oriented) менежментийн загвараасаа гарц болон үр дүнд чиглэсэн (output and result oriented) менежментийн хэлбэр рүү шилжих хандлагатай байгаа ажээ.⁶²

Үр дүнд суурилсан төсөвлөлтийг улс орнууд шүүхийн үйл ажиллагаанд хэрхэн нэвтрүүлсэн талаарх судалгаа төдийлөн хангалттай бус байсан нь энэхүү судалгааны үр дүнд тодорхой хэмжээнд нөлөөлсөн. Учир нь судалгааны баг анх Ази болон Европ тивүүдийн улс орнуудыг судлахаар төлөвлөж байсан боловч зарим ихэнх судалгаа нь зөвхөн европ тивийн улсуудад хийгдсэн байх бөгөөд латин америкийн зарим улс орнуудад хийсэн судалгаа нь Ази тивийн улс орнуудад хийсэн судалгаанаас илүү нийтлэг байсан. Иймд энэхүү судалгааны хүрээг зөвхөн Ази болон Европ тивийн улс орнуудаар хязгаарлах нь үр дүн багатай гэж үзэж Америк тивийн бусад улс орнуудад хийсэн зарим судалгааг ч эх сурвалж болгон харьцуулан судалж ашиглалаа.

2.1. Гадаадын зарим улсад шүүхийн санхүүжилтийг төсөвлөж байгаа өнөөгийн загвар

Финланд Улс

Финландын Үндсэн хуулийн Есдүгээр бүлэгт шүүх эрх мэдлийн асуудлыг зохицуулсан байна. Финланд Улсын ердийн шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүх болон дүүргийн шүүхээс бүрдэнэ. Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо нь Захиргааны хэргийн дээд шүүх болон бүсийн захиргааны хэргийн шүүхээс бүрдэнэ. Харин тусгай шүүх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хуулиар зохицуулахаар үндсэн хуульдаа заажээ. Мөн түр шүүх байгуулахыг хориглосон байна.

⁶¹ Viapiana, F. (2021), "A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies", Journal of Public Budgeting, Accounting & Financial Management, Vol. 33 No. 2, pp. 177-206.

⁶² Performance Budgeting in Context: An Analysis of Italian Central Administrations, дараах холбооцоо хандаж үзнэ үү: <https://www.mdpi.com/2076-3387/9/4/79>

Иргэний, арилжааны болон эрүүгийн хэрэг, маргааныг Улсын дээд шүүх эцэслэн шийдвэрлэдэг бол захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг Захиргааны хэргийн дээд шүүх эцэслэн шийдвэрлэнэ.

Дээд шүүхүүд нь тус тусын харьяалан шийдвэрлэх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхийн зэрэгцээ бусад шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжийн талаарх саналаа Засгийн газарт хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг ажээ.

Финланд Улсын анхан шатны шүүхүүдэд 2020 оны байдлаар нийт 834 шүүгч байсан нь 100,000 хүн ам тутамд 15.1 шүүгч оногдохоор үзүүлэлт байсан бөгөөд тус онд иргэний болон худалдааны 8,587 (100,000 хүн ам тутамд 0.16), эрүүгийн 51,645 (100,000 хүн ам тутамд 0.94) хэрэг, маргааныг шүүхэд хүлээн авсан бол улсын хэмжээнд шийдвэрлэж дуусаагүй 9,530 (100,000 хүн ам тутамд 0.17) хэрэг, маргааны үлдэгдэл дараа онд шилжжээ. Иргэний болон худалдааны хэрэг, маргаан шийдвэрлэсэн дундаж хугацаа 252 хоног байжээ.⁶³

Финланд Улсын Хууль зүйн яамны Шүүхийн захиргааны хэлтсээс шүүх тус бүрийн удирдлагатай нь жил тутам уулзаж төсвийн хэрэгцээ шаардлага, зорьж буй үр дүнгийн талаар хэлэлцэн тохиролцдог бөгөөд төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа тухайн шүүхийн хэргийн ачааллын хэмжээг үндсэн шалгуур болгож эх үүсвэрийн хэмжээг тодорхойлдог байна. Үүнээс гадна шүүгч тус бүрийн гаргаж байгаа шийдвэрийн тоо, шүүхийн шийдвэр гаргах бүрд оролцож байгаа албан хаагчдын тоо, шүүхэд хэрэг, маргаан шийдвэрлэх дундаж хугацаа, шийдвэрлэж дуусаагүй хэргийн тоо, шүүхийн төсвөөс гарсан зардлаас нэг хэрэгт ногдох зардлын дундаж зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг бусад шалгуур болгон тооцдог байна.⁶⁴

Финланд Улсын шүүх нь хэрэг, маргааныг тодорхой төрлүүдэд ангилан үзэж хэргийн төрөл тус бүрээр хэргийн ачааллыг тооцох “жигнэсэн ачааллын тогтолцоо”-г ашиглан шүүхийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, шүүгчдэд хэргийн ачааллыг илүү нарийвчлалтайгаар тэнцүү хуваарилах байдлаар ажилладаг байна.⁶⁵

Төсвийг батлахад үндсэн шалгуур үзүүлэлт нь хэргийн жигнэсэн үнэлгээ байх бөгөөд тухайн жилд баталж болох төсвийн дээд хязгаарыг харгалзан Хууль зүйн яам болон тухайн шүүхийн ерөнхий шүүгч нар ирэх жилийн төсвийг хэлэлцэн баталдаг ажээ. Харин бусад шалгуур үзүүлэлтүүд нь (1) тухайн шүүхийн орц, гарцын үнэлгээнд суурилсан бүтээмжийн оноо буюу шүүгч тус бүрийн шийдсэн хэргийн тоо болон шүүхийн ажилтны ажилласан хэргийн тоо, (2) шүүхийн үйл ажиллагааны үр дүнтэй байдал буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа, (3) шүүхийн үйл ажиллагааны үр ашигтай байдал буюу нийт шийдвэрлэсэн хэрэг маргаанд зарцуулсан зардлыг хэргийн тоонд харьцуулсан эдийн засгийн үр ашгийн тооцоолол байдаг байна.

⁶³ Federica Viapiana, A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies, дараах холбоосоор хандаж үзнэ үү: <https://www.emerald.com/insight/1096-3367.htm> (2023.08.23)

⁶⁴ Мөн тэнд.

⁶⁵ Мөн тэнд.

Гэвч 2020 оны судалгаанд шүүхийн төсвийн эх үүсвэрийг батлахдаа шүүхийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилах холбоос Финланд улсын хувьд харьцангуй сүл⁶⁶, харин Нидерланд улс гүйцэтгэлийн үзүүлэлттэй шүүд холбож буюу хэргийн тоог тухайн төрлийн хэргийн мөнгөн зардлаар үржүүлэх байдлаар⁶⁷ шүүхийн төсвөө баталдаг гэж дүгнэсэн байна. Үүнийг тодруулбал Нидерланд Улсын хувьд шүүхийн хэрэг, маргааныг 70 төрөлд ангилан 11 төрөлд багцалж гүйцэтгэлийн үнэлгээг боловсруулдаг⁶⁸ бөгөөд төрөл тус бүрийг тодорхой мөнгөн дүнгээр үнэлэх байдлаар шүүхийн төсвийг төлөвлөдөг байна. Тухайн хэрэг, маргааны төрөлд оногдох зардлын хэмжээг хэргийн төрөлд тохирох мөнгөн үнэлгээгээр үржүүлэх үндсэн аргыг ашигладаг бөгөөд илүү олон хэрэг шийдвэрлэдэг шүүх ахиу төсөвтэй ажилладаг байна. Түүнчлэн төсвийн зардлыг тооцоолохдоо тухайн хэргийг шийдвэрлэхэд оролцож байгаа шүүгч, шүүхийн ажилтны ажиллах цагийг таамаглан гаргаж түүнийгээ нэг минут ажиллах хөлсөөр үржүүлэн тооцдог бөгөөд төсөв батлахдаа урьдчилсан таамагласан хэргийн тооноос цөөн хэргийг тухайн жилд шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэрлээгүй хэргийн тооны мөнгөн үнэлгээний 70 хувийг шүүхийн зөвлөлдөө буцаан олгох зохицуулалттай байна.⁶⁹

Эстони Улс

Эстони Улс нь гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтөд бүрэн шилжихээр төлөвлөсөн бөгөөд 2015-2020 оныг шилжилтийн үе гэж тодорхойлсон, 2020 оны байдлаар бүрэн шилжиж дуусаагүй гэж үзэж байсан боловч төрийн албан хаагчдын 70 гаруй хувь нь гүйцэтгэлийн тайлан, мэдээг ашигладаг болсон байна⁷⁰

Шүүхийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлын Европын комисс (СЕPEJ) болон Европын зөвлөл (Council of Europe) хамтран 2020 онд гаргасан судалгаанаас үзэхэд Эстони Улс нь 2007 оноос эхлэн “хэрэг жигнэн хэмжих тогтолцоо”-г хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ тогтолцоо нь шүүхийн хүрэлцээтэй байдлыг хангах, шүүхийн шийдвэрийг боломжийн хугацаанд гаргах, шүүгчдэд хэргийг ижил тэгш байдлаар хуваарилах, хэрэг шийдвэрлэх цаг хугацааг үнэлсний үндсэн дээр шүүхэд ирэх ачаалал нэмэгдэх нөхцөлд шүүгч нар бэлтгэлтэй байх боломжийг бүрдүүлэх зорилготой байна.⁷¹

Иргэний хэргийн хувьд сөрөг нэхэмжлэл гаргасан эсэхийг тодорхой хүчин зүйлд тооцон үнэлэх, эрүүгийн хэргийн хувьд холбогдогчийн тоо, холбогдуулан шалгасан зүйл заалт, орчуулагч, хэлмэрч оролцуулсан эсэхийг хүчин зүйл болгон үнэлэх зэргээр шүүгчийн хэрэг маргаан шийдвэрлэхэд зарцуулсан ажлын ачааллыг цагаар тооцон гаргахаар судалгаа хийсэн бөгөөд 1 жил 6 сарын турш шүүгчийн ажилласан цагийг амралт, өвчтэй болон чөлөөтэй цагийг

⁶⁶ Federica Viapiana, Marco Fabri. Administration of Justice and Courts' Budget: An Independence and a Managerial Issue. Public Sciences & Policies. vol. V, N.01, 2019, 53-68. 60-р тал

⁶⁷ Мөн тэнд, 64-р тал

⁶⁸ Federica Viapiana, Marco Fabri. Administration of Justice and Courts' Budget: An Independence and a Managerial Issue. Public Sciences & Policies. vol. V, N.01, 2019, 53-68. 64-р тал

⁶⁹ Federica Viapiana, A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies, дараах холбоосоор хандаж үзнэ үү: <https://www.emerald.com/insight/1096-3367.htm> (2023.08.23)

⁷⁰ Aligning the budget with the Performance-Based Budgeting: lessons from Member States

⁷¹ European Commission for the Efficiency of the Justice, Council of Europe. Case weighting in judicial systems: CEPEJ studies No.28. 2020. 23 -р тал

оролцуулахгүйгээр шийдвэрлэсэн хэрэгтэй нь харьцуулан судалж үзэхэд нэг шүүгчийн жилд ажилласан дундаж цаг нь 1600 цаг байсан байна. Энэхүү судалгааны үр дүнд иргэний, эрүүгийн, захиргааны хэрэг, маргааныг жигнэн үнэлэх гурван тусдаа аргачлалыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн хувьд шүүгчид хэргийг 0,34-10 хүртэлх оноогоор үнэлэн шийдвэрлэхээр шүүгчид ярилцан шийдвэрлэжээ. Эрүүгийн хэрэгт “эрүүгийн хэргийн стандартыг тодорхойлох” аргачлал хэрэглэн 5 хүртэлх холбогдогчтой, хэлмэрч, орчуулагч оролцуулахгүй хэргийг 31.1 цагт шийдвэрлэх бөгөөд хүчин зүйлсийн нөлөөллийг тооцон үржүүлэх байдлаар зарцуулах хугацааг нэмж тооцоолох, хялбаршуулан шийдвэрлэх боломжтой хэрэгт хамгийн багадаа 2.3 цагийг зарцуулах, ялах шийдвэр гаргахад 8.9 цагийг зарцуулах зэргээр хамгийн ихдээ нэг хэрэгт 513.2 цагийг зарцуулахаар стандарт тогтоосон байна. Харин иргэний хэрэгт шүүгчийн хэрэг шийдвэрлэх хугацааг хамгийн багадаа 1.5 цаг, хамгийн ихдээ 11.5 цаг зарцуулахаар тооцох бөгөөд гэр бүлийн хэрэг, маргаанд хүүхдийн асран хамгаалагч тогтоох, хүүхдийн тэтгэмж тогтоох зэрэг нэхэмжлэлийн шаардлагын тооноос шалтгаалан хувьчлан тооцож зарцуулах цагийг тооцох аргачлалыг ашигладаг байна.⁷² Энэхүү аргачлалыг анх баталснаас хойш 2015 онд зөвхөн захиргааны хэргийн оноогоор үнэлэх тогтолцоог өөрчлөн 2-40 оноо өгч үнэлдэг болсон бөгөөд тодорхой төрлийн хэрэг, маргааны төвөгтэй байдлыг сүүлийн 4 жилд шийдвэрлэсэн цаг хугацааны статистикт үндэслэн жигнэн тооцох байдлаар оноо өгч зарцуулах хугацааг тооцоолох аргыг захиргааны хэргийг шийдвэрлэхдээ ашиглахаар шүүгчид харилан тохиролцож шийдвэрлэжээ.⁷³

Эстони Улс шүүхэд шийдвэрлэх хэрэг, маргааныг ийнхүү оноогоор жигнэн тооцоолсны үндсэн дээр анхан шатны тодорхой шүүхэд ажиллах шүүгчийн тоо зэрэг төсөвт хамаарах тооцооллуудыг боловсруулж гаргаж байгаа боловч 2020 оны судалгаанаас үзэхэд цөөн тооны анхан шатны шүүхэд болон давж заалдах шатны шүүхүүдэд ийм аргачлалыг бүрэн нэвтрүүлж чадаагүй байна. Цөөн тооны буюу 2-4 шүүгчтэй шүүхэд шүүгчийн тоог багасгах боломжгүй байдаг зэрэг шалтгааны улмаас улс орон даяар тус аргачлалыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байгаа боловч хэргийг жигнэн үнэлэх байдлаар шүүгчдийн ачааллыг тэнцвэржүүлэх аргыг улам боловсронгуй болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Сүүлийн 20 гаруй жилд Европын улс орнууд төсвийн уламжлалт загварыг халж нийтийн албаны үйлчилгээний орц, гарц, үр дүнд чиглэсэн төсвийн загварыг хэрэгжүүлэх хандлагатай байгаа бөгөөд эдгээр нь ихэвчлэн “гүйцэтгэлд суурилсан” төсөвлөлтийн шинжтэй байна. Энэ загвар нь шүүхийн төсөвт ч тусгалаа олж Франц, Финланд, Нидерланд, Албани, Дани, Швед, Эстони, Ирланд, Их Британи улс шүүхийн төсвийг боловсруулан батлахдаа энэ чиг хандлагыг баримталж байгаа нь ажиглагдаж байна.⁷⁴

⁷² European Commission for the Efficiency of the Justice, Council of Europe. Case weighting in judicial systems: CEPEJ studies No.28. 2020. 23 -р тал

⁷³ European Commission for the Efficiency of the Justice, Council of Europe. Case weighting in judicial systems: CEPEJ studies No.28. 2020. 23-24 -р тал

⁷⁴ Federica Viapiana. Pressure on Judges: How the Budgeting System Can Impact on Judge's Autonomy. 2018. 7 -р тал

Шүүхийн санхүүжилтийн хувьд Их Британи Улс нь гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн хэлбэртэй улс гэж үзэж болох бөгөөд иргэний хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүхийн зардлыг талуудаас гаргуулах зэрэг шүүхийн төсвийн ачааллыг багасгахад чиглэсэн шинэлэг санаачилгуудыг түршиж байна. Тухайлбал, Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх зардлыг гуравдагч этгээдээр гаргуулах нь Их Британи улсад, ялангуяа Англи, Уэльсд илүү нийтлэг байна. Шүүхэд хэрэг шийдвэрлүүлэх зардлыг гуравдагч этгээдээр санхүүжүүлэх гэрээ (Litigation Funding Agreements)-ийг ашиглан шүүхийн зардлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн гаргуулах боломжтой байдаг⁷⁵ бөгөөд мөн Англи, Уэльсд иргэний зарим хэрэг, маргааныг шүүхэд шийдвэрлэх зардал нь фунт стерлингээр илэрхийлэгдсэн тодорхой мөнгөн дүгээс давах тохиолдолд талуудаас шүүхийн зардлыг гаргуулах прецедент ('Precedent N') бий болгон хэрэглэж эхэлсэн байна⁷⁶.

Их Британи улсын хувьд нэгдмэл улс бөгөөд шүүхийн төсөв боловсруулж батлуулах тухай зохицуулалтууд нь Англи, Уэльс, Шотланд, Умард Ирланд гэсэн нэгдэн орсон улсууд хооронд ялгаатай зохицуулагддаг байна.

Хатан хааны Шүүх болон шүүхийн үйлчилгээний байгууллага (Her Majesty's Courts and Tribunals Service) нь шүүхийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, Хууль зүйн яам, шүүхүүд, шүүгч нар, хуулийн мэргэжилтнүүд, олон нийт болон холбогдох төрийн байгууллагууд зэрэг шаардлагатай бүх этгээдүүдтэй зөвшилцөн дараагийн жилийн шүүхийн төсвийг боловсруулах үүрэгтэй байна. Шүүхийн төсвийг боловсруулахдаа тусгайлан авч үзэх шүүхийн хэрэгцээ, шаардлагыг мөн тодорхойлж илүү өндөр эх үүсвэрийг батлах боловч бусад шүүхүүдэд эдийн засгийн хувьд үр ашигтай, хэмнэлттэйгээр ажиллахаар төсвийг баталдаг байна.

Их Британи улс шүүхийн төсвийг батлахдаа шүүхийн хэргийн ачаалал, хүний нөөцийн зардал, дэд бүтэц болон шүүхийн байрны зардал, технологийн хөрөнгө оруулалт, хууль зүйн туслалцаа, үйл ажиллагааны зардал, инновац болон хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ажиллах зардал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэхийн зэрэгцээ шүүхийн гүйцэтгэлийн үзүүлэлт, шүүхийн хүрэлцээтэй байдал, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг ч харгалзан үздэг байна.

Шүүхийн хэргийн ачааллыг тооцохдоо иргэний, эрүүгийн, гэр бүлийн, захиргааны хэрэг, маргаанаар тус тусад нь өөр өөр аргачлалаар тооцоолж гаргана.

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо шүүгч, шүүхийн ажилтны цалин хөлс, нэмэгдэл цалин, хөлс, хөнгөлөлт, урамшуулал зэрэг холбогдох бусад олговруудыг багтааж үздэг бол дэд бүтэц болон шүүхийн байрны зардалд шүүхүүдийн байрыг засварлах, сайжруулах зардал, хамгаалалтын зардал, технологийн дэд бүтцээр хангах хэрэгцээтэй холбоотой зардлуудыг багтааж үздэг байна. Үүний зэрэгцээ технологийн хөрөнгө оруулалт гэсэн тусдаа зардлыг төсөв тусгах бөгөөд үүнд технологийн дэвшлийг ашиглах, шүүхийн үйл ажиллагааны цахимжуулалтыг сайжруулах, онлайнаар гомдол, нэхэмжлэл гаргах талбарыг хөгжүүлэх, цахимаар шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлуудыг хамруулж үздэг ажээ.

⁷⁵ White & Case is a global law firm. Upheaval in the Litigation Funding Industry: UK Supreme Court Rules that many Litigation Funding Agreements are Unenforceable. 2022. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.whitecase.com/insight-alert/upheaval-litigation-funding-industry-uk-supreme-court-rules-many-litigation-funding>

⁷⁶

Их Британи улсад хууль зүйн туслалцаа нь шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал бөгөөд төлбөрийн чадвартгүй хүмүүст хууль зүйн туслалцааны төлбөр нь Европ тивийн бусад улс орнуудаас харьцангуй өндөр байдаг онцлогтой байна.

Харин үйл ажиллагааны зардалд өдөр тутмын буюу ашиглалт, бичиг хэрэг, томилолтын зардал зэрэг зардлуудыг хамааруулдаг байна.

Инновац болон хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ажиллах зардалд шүүхийн үйл ажиллагааг шинэчлэх, хэргийн удирдлагын шинэ тогтолцоо болон шүүхийн бус аргаар хэрэг, маргаан шийдвэрлэх зэрэг туршилтын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хамааруулж үздэг байна.

Шүүхийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг тооцохдоо хэрэг шийдвэрлэсэн хугацаа, шийдвэрлэгдээгүй хэргийн тоо зэрэг үр дүнгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзэх бөгөөд тодорхой гүйцэтгэлийн үзүүлэлттэй санхүүжилтийг нь холбон төлөвлөж төсөвлөдөг байна.

Шүүхийн хүрэлцээтэй байдал гэдэг үзүүлэлтийг төсөв батлахдаа харгалзан үздэг бөгөөд үүнд шүүхийн үйлчилгээний хүрэлцээтэй байдлыг ялангуяа нийгмийн эмзэг, зорилтод бүлгийн иргэдэд хүргэх арга хэмжээг тусгайлан хэрэгжүүлэх, энэ чиглэлээр шинэ санаачилга гарган туршихтай холбоотой зардал байхаар тооцоолдог байна.

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал гэсэн шалгуур үзүүлэлтэд улс орны хэмжээнд хэрэгжүүлж байгаа шүүхийн тогтолцооны шинжтэй санаачилгуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлуудыг харгалзан үздэг байна. Мөн энэ зардалд шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, хэрэглэгчийн туршлагад үндэслэн шинэчлэлт хийх зардлыг оруулж үздэг тохиолдол байдаг.

Үндсэндээ Их Британи улс нь шүүхийн шинэчлэл, сайжруулалтыг стратеги төлөвлөлтдөө тусган төлөвлөж жил бүр холбогдох зардлыг хийх ажилтай холбон баталж өгдөг, үүний зэрэгцээ тодорхой шүүхийн цахимжуулалт, инноваци, техникийн дэвшлийг дэмжих зардлыг хэрэгцээ, шаардлагыг нь судалсны үндсэн дээр тусгайлан баталж өгдөг, үүний зэрэгцээ гүйцэтгэлийн үзүүлэлттэй нь холбон зарим зардлыг төлөвлөдөг бөгөөд хүний нөөц, байр ашиглалтын зардлыг тусад нь баталдаг зэргээс үзэхэд үр дүнд суурилсан, гүйцэтгэлд суурилсан хоёр хэлбэрийн төсөвлөлтийн аль алиных нь шинжийг агуулсан холимог шинжтэй төсөвлөлтийн аргыг ашиглаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлд шүүхийн төсвийг зөвхөн холбооны улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан бөгөөд шүүхийн төсвийн асуудлыг ОХУ-ын Холбооны Төсвийн тухай, Шүүхийг санхүүжүүлэх тухай, Шүүхийн тогтолцооны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг байна. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүхийн үйл ажиллагааг хангахын тулд Холбооны төсвийн тухай хуульд төсвийн бие даасан байдлыг хангах талаар хуульчилжээ. Тухайлбал, шүүхүүдийн тухайн жилийн батлагдсан төсөв болон дараагийн жилийн шүүхийн төсвийн төслийн дүнгээс бууруулах бол зөвхөн ОХУ-ын Шүүгчдийн зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр

шүүхийн төсвийн 5-аас илүүгүй хувийг бууруулах, мөн дээрх шүүхүүд нь төсвөө бие даан зарцуулах, санхүү, материаллаг болон техник хангамжийн хувьд бусад байгууллагаас хараат бус байхаар холбогдох хуулиар зохицуулж өгсөн байна. Энэхүү төсвийг бууруулахад тодорхой хувь зааж өгсөн нь бусад эрх мэдлийн эдийн засгийн хийгээд улс төрийн нөлөөллийг хязгаарлах ач холбогдолтой.

ОХУ-ын Засгийн газар, Шүүхийн дээд зөвлөлийн даргатай хамтран тухайн жилдээ дараагийн жилийн шүүхийн төсвийн төслийг боловсруулж улмаар ОХУ-ын Төрийн дүм шүүхийн төсвийг баталдаг байна. Хэрэв төслийг боловсруулахад саналын зөрүү гарах тохиолдолд Засгийн газар төсөлдөө шүүхийн төсөвтэй холбогдох төслийн саналыг хавсаргаж өгөх үүрэг хүлээдэг. Шүүхийн тогтолцооны тухай хуулиар ОХУ-д шударга ёс тогтоох үйл ажиллагааг зөвхөн ОХУ-ын Үндсэн хууль болон энэхүү Холбооны хуульд зааснаар байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ, шүүхийн санхүүжилт нь холбооны хууль тогтоомжийн дагуу шударга ёсыг бүрэн, бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжийг хангасан байх бөгөөд Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, ерөнхий харьяаллын шүүх, арбитрын шүүхийн санхүүжилтийг Холбооны хуулиар баталсан стандартын үндсэн дээр Холбооны Улсын төсөвт тус тусад нь тусгаж төсөв хэлэлцэхэд Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгчид, Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн газрын даргыг оролцуулдаг байна.

ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль⁷⁷-д шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг хэрхэн бэхжүүлснийг судлан үзвэл: Шүүгчийн сар бүр олгох мөнгөн урамшуулал нь шүүгчийн эрхэлж буй албан тушаалын цалин, шүүгчийн мэргэшлийн зэргийн дагуу албан тушаалын цалинг 10 зэрэглэлд ангилан цалинг 30-150 хувиар сар бүр нэмэгдүүлэн олгодог. Мөн шүүгчид сар бүр олгох мөнгөн урамшуулал, ажилласан хугацааны нэмэгдэл, хууль зүйн доктор, хууль зүйн шинжлэх ухааны докторын зэргийн нэмэгдэл, дэд профессор, профессор, "ОХУ-ын гавьяат хуульч" цолны, түүнчлэн ОХУ-ын хууль тогтоомжид заасан тохиолдолд гадаад хэлний мэдлэг, гүйцэтгэлд ашиглахад сар бүр хуульд заасан хувиар нэмэлт урамшуулал олгодог байна.

Шүүгчийн албан тушаалын цалинг инфляцын түвшинг харгалзан тухайн жилийн болон төлөвлөсөн хугацаанд Холбооны төсвийн тухай хуульд заасны дагуу жил бүр нэмэгдүүлдэг бөгөөд энэхүү шийдвэрийг ОХУ-ын Ерөнхийлөгч гаргадаг байна. Шүүгчийн цалин, урамшууллын энэхүү зохицуулалтаас харахад манай улсын хувьд УИХ-аас 2015 онд Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд тухайн үед анхан шатны шүүхийн шүүгчийн цалин 1352 ам доллартой тэнцэж байсан бол 2023 онд 778 ам.доллартой тэнцэж байна. ОХУ-ын шүүхийн төсвийг аажмаар өсөх төсөвлөлтийн загвараар төсөвлөж, шүүх байгууллагуудын төсвийг тус тусад нь боловсруулан баталдаг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

⁷⁷ Закон о статусе судей в российской федерации. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү (2023-09-11): <https://sudact.ru/law/zakon-rf-ot-26061992-n-3132-1-o/?ysclid=lm688cc0sn123030502>

БНХАУ-ын Ардын шүүхийн зохион байгуулалтын хуульд Ардын шүүхийн үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг хангахын тулд эрх мэдлийн хуваарилалтын зарчмаар улсын төсвөөс санхүүжнэ.

“Төсвийн тухай хууль”-д шүүхийн санхүүжилтийг нарийвчлан зохицуулаагүй бөгөөд Засгийн газрын төсөвт шүүхийн төсөв ба захиргааны төсөв гэсэн хоёр агуулгаар тусгадаг баталдаг байна. Засгийн газраас төсвийг боловсруулахдаа шүүхийн байгууллагыг захиргааны байгууллагын статуст оруулж байгаа нь шүүхийн санхүүжилтийг захиргааны байгууллагад харьяалагдаж буйг харуулж байна.⁷⁸

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зардлыг Засгийн газраас санхүүжүүлдэг. БНХАУ-ын бүүрай хөгжилтэй бүс нутгуудын хувьд шүүхийн санхүүжилт нь харьцангуй сул, эдийн засгийн тэнцвэргүй хөгжлийн улмаас үүссэн шүүхийн санхүүжилтийн зөрүүг үр дүнтэй нөхөхийн тулд төвлөрсөн төсвөөс шилжүүлгийн төлбөрийн аргыг хэрэгжүүлдэг.

Засгийн газрын төсөв өргөн цар хүрээг хамардаг тул шүүхийн санхүүжилт нь ижил түвшний санхүүжилтээс тухайлбал, орон нутгийн бүх шатны Ардын шүүхийн төсвийн хөрөнгийг бүх шатны орон нутгийн засаг захиргаа бодитойгоор боловсруулан орон нутгийн Ардын их хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг. Шүүхийн үйл ажиллагааг дэмжих, шүүгчийн цалин зэрэг нь тухайн орон нутгийн засаг захиргааны орлого төвлөрүүлэлтээс хамааралтай. Шүүхийн санхүүжилтийн зохистой, хангалттай хамгаалалтыг бий болгож байж л шүүх шударга ёсыг хангаж, үр дүн дээшилдгийг түүхэн туршлага харуулж байна.⁷⁹

Шүүхийн санхүүжилтийн орон нутгаас хараат байдлыг бууруулах талаарх 2015 оны “Ардын шүүхийн шинэчлэлийг иж бүрэн гүнзгийрүүлэх тухай Ардын дээд шүүхийн санал”⁸⁰ - д

1. “Төв-Муж”-ийн шүүхийн төсвийн хоёр шатлалт удирдлагын загварыг боловсронгуй болгох;

БНХАУ-ын шүүхийн сангийн нэгдсэн удирдлага нь шүүхийн санхүүжилтийг орон нутгийн асуудлаас салгаж, орон нутгийн нөлөөллөөс зайлсхийх, шүүхийн төвийг сахисан байдлыг үр дүнтэй байлгахад оршино.

Хоёр шатны шүүхийн санхүүжилтийн баталгааны загвар нь Ардын дээд шүүхийн санхүүжилтийг төвөөс, мужийн дэсээс доогуур шүүхийн санхүүжилтийг мужаас батлан хариуцна.

2. Шүүхийн төсвийг шүүх боловсруулах бөгөөд Ардын Төлөөлөгчдийн Их Хурал шийдэх;

Ардын дээд шүүх нь төсөв боловсруулах, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаар батлах, шүүхийн гүйцэтгэлийг ерөнхийд нь төлөвлөх ажлыг тодорхой болгоно.

Зарим судлаач “хоёр эрх мэдлийг салгах, удирдлагын нэгдсэн төлөвлөгөө”-г санал болгож өмнөх төрлийн сангууд нь Засгийн газраас тусгай сан байгуулах замаар баталгаажсан байх, мөн

⁷⁸ 谌霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第18页。

⁷⁹ 张坤世: 《论我国司法预算制度的完善—以法院为中心的分析》, 《财经理论与实践》, 2007年第150期, 第71-75页。Мөн 谌霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第19页。

⁸⁰ 廖珏、王肖: 《关于省以下地方法院经费保障制度的调研-基于“省级统管”改革背景下的现状检视和体系重构》, 《中国应用法学》, 2018年第1期, 第59页。Мөн 谌霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第42页。

шүүх, прокурорын системд Шүүхийн сангийн удирдлагын тусгай хороо байгуулагдан менежментийг хариуцаж, хэргийн зардалд төвлөрсөн хөрөнгийн динамик өсөлтийг бий болгоно. Сүүлийн ангиллын хөрөнгө нь захиргааны сангийн ангилалд хамаарах бөгөөд үүнд аймгийн санхүүгийн хэлтсээс баталгаа гаргаж, аймгийн санхүүгийн хэлтэс хариуцан анхны сангийн баталгааны түвшинг хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлэх боломжтой.⁸¹

3. Засгийн газрын төсвийг орлох улсын төсвийн зохистой тогтолцоог бүрдүүлэх;

Шүүхийн төсвийг Засгийн газрын төсвөөс салгаж шүүхийн төсөв, Засгийн газрын төсөв гэсэн ойлголтуудыг багтаасан улсын төсөв гэх үзэл баримтлалыг бий болгоно.⁸²

БНХАУ-д 2014 оноос хойш мужийн дэсэд шүүхийн сангийн нэгдсэн удирдлагын шинэчлэл хийгдэж байна⁸³. Шүүхийн төсвийн онцлогийг тодруулахын тулд төсөвлөлтийг уламжлалт "суурь + өсөлт"-ийн загвараас "Тэг"-д суурилсан төсөвлөлтийн загварт шилжүүлэх⁸⁴, уламжлалт загвараар шүүхийн төсвийн зүйлийг үндсэн зардал, төслийн зардал гэж хоёр ангилж, үндсэн зардал нь тогтмол удирдлагад хамаарах бөгөөд төсвийн дүнг ерөнхийд нь санхүүгийн алба шүүд бүрдүүлдэг. Шүүх зөвхөн төсвийн хяналтын дагуу маягт бөглөх шаардлагатай. Төсөв нь төвийн ба орон нутгийн дэмжлэгийн 2 хэсгээс бүрдэх бөгөөд зөвхөн орон нутгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх орон зайтай байна. Төсвийн энэхүү загвар нь шүүхийн зардлын бодит хэрэгцээг үнэн зөв тусгахад хэцүү "Өсөлт" гэж нэрлэгддэг зүйл нь ихэвчлэн үнэ, инфляцын хүчин зүйлийг тооцдог. Шүүхийн тогтолцоо нь төсөв боловсруулах үйл явцад шүүгчийн тоо, хэргийн тооны талаас бусад бодитой мэдээлэл өгөх боломжгүй байдаг. Харьцуулбал "Тэг"-д суурилсан төсөвлөлт нь шүүхээс дарамтгүйгээр өөрийн нөхцөл байдалд тохируулан төсвийн шинэ төлөвлөгөө гаргахыг шаарддаг бөгөөд энэ нь шүүхийн өөрийн төсвийн санаачилгыг бүрэн тусгаж байгаа учраас хүчтэй тохирдог байна.

Тэнцвэртэй үнэлгээний карт дээр суурилсан төсөвлөлтийн загвар нь хэмжигдэхүүн тус бүрийн гол үзүүлэлтүүд болон үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэсэн. Хариуцсан хэлтсүүдийг хооронд нь холбосон. Төсөв боловсруулахдаа хэлтэс бүр үндсэн үзүүлэлтүүдийн зорилтот утгыг үндэслэн тодорхой төсөв боловсруулах шаардлагатай. Дараа нь тус хэлтсийн төсвийн тайланг гаргаж, санхүүгийн хэлтэст тайлагнаж, эцэст нь төсөв бүрдүүлнэ.⁸⁵

Бээжингийн их сургуулийн хуулийн сургуулийн дэд профессор Е Шан: Шүүхийн төсвийг орлого, зарлагын тэнцвэртэй байлгах оновчтой зохицуулалт, суурь тоо, хүчин зүйлийн аргыг хослуулах зарчмаар бүрдүүлэх ёстой⁸⁶. Шүүхийн санд захиргааны хэрэг эрхлэх эрх мэдлийн үйл ажиллагааны зардлыг төлөөлөх хүний нөөцийн сан, өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгө, дэд бүтцийн бүтээн байгуулалтын сан, шүүх эрх мэдлийн үйл ажиллагааны

⁸¹ 范丽思:《省级统管后法院经费保障机制再造》,载《人民司法》,2021(22)。

⁸² 谌霞.(2021).,我国法院组织制度改革完善研究,南昌大学硕士学位论文集,第42-44页。

⁸³ 郑涛.(2021).,预算法院的法理基础与实现路径——兼评法院经费省级统管改革,法学,2021年第9期,第53页。

⁸⁴ Мөн тэнд.

⁸⁵ 张晶.(2022).,基于平衡计分卡的XS法院全面预算管理研究,吉林电子科技大学,第35页。

⁸⁶ 叶珊.(2022).,司法经费保障条款的预算法治实现,中国人民大学学报,2022年第5期,第148页。

зардлыг төлөөлөх хэрэг хянан шийдвэрлэх сан, тоног төхөөрөмжийн сангуудыг оролцуулбал зохино. “Тэг”-д суурилсан төсөвлөлтийн аргаар⁸⁷ шүүхийн төсөвлөлтийг хийхийн тулд:

1) Төсвийн зарлагын стандарт, ангиллын тогтолцоог бүрдүүлэх, тэг дээр суурилсан төсвийн суурыг нэгтгэх;

Цаашид хүний нөөцийн удирдлагыг чангатгаж, орон тооны бус орон тооны өсөлтөд хатуу хяналт тавьж, боловсон хүчний үнэлгээний механизмыг боловсронгуй болгож, үнэлгээний үр дүнг үе шаттайгаар санхүүжилтийн зохицуулалттай хослуулах хэрэгтэй. Төсвийн хөрөнгийн квотын стандарт, динамик зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоход анхаарч, төсвийн хөрөнгийг ажиллах хүчний тооноос салгах асуудлыг судалж, албадын зардлын бодит хэрэгцээнд тулгуурлан “Тэг”-д суурилсан төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлнэ.

2) Төсвийн гүйцэтгэлийн бүх үйл явцын удирдлагыг нэвтрүүлэх, энэ нь “Тэг”-д суурилсан найдвартай мэдээллийн дэмжлэг үзүүлэх;

БНХАУ-ын төсвийн гүйцэтгэлийн менежмент 2011 онд Засгийн газрын гүйцэтгэлийн менежментээр эхэлсэн бөгөөд түршилтын шинэчлэл нь төсвийн удирдлагын шинэчлэлийн зайлшгүй өргөтгөл болж байна.

Түршилтын хөтөлбөрт хамрагдсан 14 бүс, газрын нэг болохын хувьд Сангийн яам төсвийн төсвийн хөрөнгийн гүйцэтгэлийн удирдлагын түршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, төсвийн зарлагын гүйцэтгэлийн үнэлгээнээс төсвийн гүйцэтгэлийн удирдлагад шилжих ажлыг эхлүүлж, "төсвийн бэлтгэлийг үе шаттайгаар бүрдүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийг Хяналт-шинжилгээтэй, төсвийн гүйцэтгэлийг үнэлгээтэй, үнэлгээний үр дүнг санал хүсэлттэй, санал хүсэлтийн үр дүнг хэрэглээтэй" холбон үйл явцын төсвийн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж байна.

3) Санхүүгийн хяналтын үүргээ биелүүлж, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын хяналт, шалгалтыг эрчимжүүлэх;

Зарчмын хувьд нийцлийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлагад адил ач холбогдол өгч АИХ-ын төсвийн хяналтын чиг үүргийг чангатгаж, хэлтсийн зардлын төрөл, төсөв боловсруулах, батлах зэрэгт АИХ-ын хяналтыг бүрэн хэрэгжүүлэх ёстой.

“Тэг”-д суурилсан төсвийн аргыг нь санхүүгийн дарамтыг багасгах, шаардлагагүй зардлыг хэмнэх, авлигаас зайлсхийж, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх тохиромжтой гэж дүгнэжээ⁸⁸.

Шүүгчийн цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулал гэсэн гурван хэсгээс бүрдэх бөгөөд үр дүнгийн урамшууллыг тухайн шүүгчийн хувийн гүйцэтгэлийн үнэлгээгээр тухайлбал: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр ашгийг харгалзан тогтоож байна⁸⁹. Шүүгчийн зэрэгтэй шууд холбоотой үндсэн цалин нь шүүгчийн цалин хөлсний түвшинд нөлөөлөх гол хүчин зүйл болдог байна. Харин нэмэгдэл цалин нь орон нутаг бүрийн санхүүгийн чадавхаас хамааралтай байдаг.

⁸⁷ 杨广勇, 杨林. 零基预算改革效果评价与未来推进——以珠海市A区为例[J]. 中央财经大学学报, 2019(1):3-14.

⁸⁸ 叶青, 吕阳. 十三五推行零基预算改革的研究[J]. 经济研究参考, 2016(32):20-29.

⁸⁹ 黄可、王菁.(2021)., 中国法官薪酬制度改革的审思与完善理路, 江西电力职业技术学院学报, 第34卷第2期, 第145页。

"БНХАУ-ын Шүүгчийн тухай хууль"-д шүүгчийн "дөрвөн дэс, арван хоёр зэрэглэл"-д заасны дагуу мэргэшсэн шүүгчийн зэрэглэлийг тодорхой аргачлалын дагуу шат дараатай ахиулж, цалинг нь ч шүүгчдийн зэрэглэлийн дагуу зохих хэмжээгээр нэмэгдүүлдэг байна.

"БНХАУ-ын Шүүгчийн тухай хууль"-д Шүүгчийн үнэлгээний агуулгад шүүх хуралдааны бодит гүйцэтгэл, мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн түвшин, хөдөлмөрийн чадвар, хэрэг маргааны төрөл зэрэг орно. Мөн хуульд жил бүрийн үнэлгээний дүнг дөрвөн зэрэглэлд хуваана. Үнэлгээний дүн нь шүүгчийн зэрэглэл, цалин хөлс, урамшуулал, шийтгэлийг тохируулах, албан тушаал бүүруулах, огцруулах үндэслэл болдог.

Шүүгчийн цалингийн тогтолцоог боловсронгуй болгох нь:

1. Шүүгчийн цалин хөлс, хэрэг хянан шийдвэрлэх нөхцөл хоорондын уялдаа холбоог сайжруулж, шүүгчийн орлогын бүтцийг оновчтой болгон ажлын ачааллыг тэнцвэржүүлэн шүүхийн тэтгэмжийн хэмжээг тохируулна.

2. Шүүгчийн цалингийн стандартыг дээшлүүлж, шүүхийн хүний нөөц, эд хөрөнгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

Нэгдүгээрт, Ардын дээд шүүх, Сангийн яамны хооронд бүх шатны шүүхийн санхүүгийн төсвийн удирдлагын тогтолцоог бий болгож, шүүхийн төсвийн хөрөнгийг баталгаажуулах шүүхийн төсвийн өсөлтийн механизмыг бий болгох хэрэгтэй. *Хоёрдугаарт*, санхүүгийн баталгааны иж бүрэн, хэрэгжих боломжтой тогтолцоог бүрдүүлж, хөрөнгө, тоног төхөөрөмжийн зардал, шүүгчийн цалин, туслах ажилтны цалинг ялгадаг санхүүгийн баталгааны механизмыг бий болгох⁹⁰ зэрэг шүүхийн санхүүжилтэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон байна.

Шинэчлэлийг иж бүрэн гүнзгийрүүлэх ажлыг тэргүүлэгч төв хэсгийн 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 16 дугаар хурлаар "Шүүгч, прокурорын албан тушаалын дэс дарааллын шинэчлэлийн туршилтын төлөвлөгөө"-ийг баталж, шүүгч, прокурорын мэргэшүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн цалингийн тогтолцооны шинэчлэл болж, шүүгч, прокурорын албан тушаалын дэс дарааллын туршилтын шинэчлэлийг онцоллоо.⁹¹

Шинэчлэлийн агуулга: Шүүхийн шинэтгэлийн туршилтын эхний ээлжийн муж, хотуудын дотроос шинэчлэлийн хамгийн хурдацтай хөгжиж буй Шанхай хот шинэчлэлийн дараа шүүгч, прокуроруудын цалингийн хэмжээг зарлаж, шүүгч, прокурорын цалингийн хэмжээг 43% нэмэгдүүлсэн байна.

Энэ удаагийн шүүхийн шинэтгэлийн гол цөм нь шүүхийн хариуцлагын тогтолцоо юм. Шинэчлэлийн дараа шүүгч, прокурор бүх насаараа хариуцлага хүлээдэг. Цөөн хэрэг гарсан тохиолдолд шүүгч, прокурорын мэргэжлийн эрсдэл нэмэгддэг гэсэн үг. Иймд цалингийн хэмжээ асар их нэмэгдсэн ч үүрэг хариуцлага ч нэмэгдсэн нь тэгш хариуцлага, урамшуулал гэж нэрлэгддэг байна.

⁹⁰ 黄可、王菁.(2021)., 中国法官薪酬制度改革的审思与完善理路, 江西电力职业技术学院学报, 第 34 卷 第 2 期, 第146-147页。

⁹¹Baidu Encyclopedia. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): https://baike.baidu.com/item/%E6%B3%95%E5%AE%98%E3%80%81%E6%A3%80%E5%AF%9F%E5%AE%98%E5%8D%95%E7%8B%AC%E8%81%8C%E5%8A%A1%E5%BA%8F%E5%88%97%E6%94%B9%E9%9D%A9%E8%AF%95%E7%82%B9%E6%96%B9%E6%A1%88/18724814?fr=ge_al

2.2. Дэлхийн бусад улс орнуудын онцлох туршлага болон олон улсын байгууллагуудын зөвлөмж

Энэхүү бүлгийн 2.1 дэх дэд зүйлд судалсан улсуудаас гадна дэлхийн бусад улс орнуудад онцгой төвөгтэй хэргүүдийг хянан шийдвэрлэхэд зориулсан зардлыг төсөвт тусгайлан тусгах, шүүхүүдийн төсвийг тэгш хуваарилахад анхаарах, шүүхийн санхүүжилтийн хамгийн бага хэмжээг тогтоох, шүүх өөрийн санхүүжилтийн эх үүсвэртэй байх, гүйцэтгэл болон үр дүнд суурилсан загварт шилжих гэх мэт сайн туршлагууд байгааг анхаарч үзэх нь зүйтэй байна.

Шүүхэд онцгой төвөгтэй хэргүүдийг хянан шийдвэрлэхэд зориулсан зардлыг төсөвт тусгайлан тусгаж шаардлагатай тохиолдолд тухайн улсынхаа хууль зүйн яам эсвэл шүүхийн зөвлөлөөс гаруулдаг жишиг ажиглагдаж байна. Жишээ нь Нидерланд улсад шүүхийн төсвийн 5 хувь буюу 42 сая орчим еврог үр дүнд суурилсан зардал биш зөвхөн зарим шүүхээр шийдвэрлэх худалдаа үйлдвэрлэлийн шүүхийн шийдвэрлэх хэрэг эсвэл эрүүгийн төвөгтэй хэргийн зэрэг онцгой хэргүүдийн зардал болгон төсөвлөж хууль зүйн яамнаас санхүүжүүлэхээр шийдвэрлэдэг⁹² бол Канад улсад томоохон хэрэг шүүхэд шийдвэрлэх үйл ажиллагаа (mega-trial буюу exceptional trial procedure) гэж үзэж тусдаа зохицуулалтаар хэргийн удирдлагыг зохион байгуулдаг⁹³ байна. Харин АНУ-ын Техас мужид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хувь хүнийг өмгөөлөх өмгөөлөгчийн зардал нь 30,000 ам.доллаароос их эсвэл өмгөөлөхөд 300 цагаас илүү хугацаа зарцуулахаар байвал "Mega-Case" буюу төвөгтэй хэрэг гэж тодорхойлж Өмгөөлөгчдийн зөвлөлтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд онцгойлон гарах зардалд тооцон Шүүхийн бага хурлаас дэмжлэг үзүүлэх боломжтойгоор зохицуулсан байна.⁹⁴

Шүүхүүдэд ижил тэгш байдлаар төсөв хуваарилах асуудал өнөө хэр анхаарлын төвд байгаа нь зарим эх сурвалжийн мэдээллээс харагдаж байна. Тухайлбал, АНУ-ын Калифорний муж улсын амбан захирагч мужийн ерөнхий сангаас 100 сая ам.долларыг шүүхүүдийн санхүүгийн эрх тэгш байдлыг хангахад зарцуулахаар 2022-2023 оны төсөвт тусгасан бөгөөд Шүүхийн зөвлөл төсвийн хуваарилалтыг зохицуулахаар шийдвэрлэсэн байна. Харин тус мужийн Хууль зүй судалгааны байгууллагаас шүүхийн санхүүжилтийн эрх тэгш байдлыг хэрхэн хангахыг тогтоолгүйгээр Шүүхийн зөвлөлд төсвийн хөрөнгийг зарцуулах эрх олгосныг анхааруулж, шүүхийн санхүүжилтийн хамгийн бага хэмжээг тогтоох, шүүхүүдийн хамгийн өндөр болон хамгийн бага санхүүжилтийн ялгааг харьцуулан бүх шүүхүүдэд хувьчлан тооцож санхүүжилтийн зөрүүтэй байдлыг багасгах зэрэг тодорхой чиглэл өгөх нь зүйтэй бөгөөд үүний зэрэгцээ Ковидын цар тахалтай холбоотой зарим сөрөг нөлөөг арилгах, шийдвэрлэгдээгүй хэргүүдийг шийдвэрлэх, технологийн дэвшил болон шүүх хуралд зайнаас оролцох боломжийг сайжруулах зэрэг бусад өндөр ач холбогдолтой ажлуудад зарцуулах байдлаар шүүхүүд хоорондын тэнцвэртэй байдалд дэмжлэг үзүүлэхийг зөвлөсөн байна.⁹⁵ Монгол Улсад ихэнх шүүх санхүүжилт дутагдалтай байгаа хэдий ч шүүхийн санхүүжилтийн ялгаатай байдлыг нарийвчлан судлах судалгаа хийж чухам ямар

⁹² Нидерланд улсын шүүхийн зөвлөлийн албан ёсны веб сайт дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10):

<https://www.rechtspraak.nl/SiteCollectionDocuments/The-Financing-System-of-the-Netherlands-Judiciary.pdf>

⁹³ Канад улсын Засгийн газрын албан ёсны веб сайт дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/csj-sic/esc-cde/mega/p3.htm>

⁹⁴ Техас мужийн дүүргийн шүүхийн албан ёсны веб хуудас дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.txed.uscourts.gov/?q=mega-case-non-capital-case-budgeting>

⁹⁵ Legislative Analyst's Office. The 2022-23 Budget, Judicial Branch Proposals. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://lao.ca.gov/Publications/Report/4513>

төрлийн зардлыг санхүүжүүлэхэд чиглэсэн төсөв дутагдалтай байгаа талаар тодорхой мэдээллийг цуглуулах нь шүүхүүдийн цаашдын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Шүүх нь өөрийн санхүүжилтийн эх үүсвэртэй байх асуудлаар зарим улс орон тодорхой зохицуулалтыг баталсан байдаг байна. Тухайлбал, Нидерланд улсын шүүхүүдийг Шүүхийн зөвлөл нь дүүргийн шүүхүүдийн төсвийг батлахад чиглэсэн 53 хэргийн төрөл, давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэх хэргийн 19 төрөл, дээд шүүхийн шийдвэрлэх хэргийн 3 төрлийг ерөнхийд нь мөнгөн дүнгээр илэрхийлэн нарийвчлан бэлтгэж, эдгээрийг нэгтгэн хууль зүйн яамандаа хэргийн 10 төрлөөр ангилан танилцуулдаг байна. Ийнхүү хэргийн ангиллаар тооцож төсвөөс бодитоор ирсэн хэргийн төрөл, тоогоор санхүүжилтээ гаргуулах бөгөөд хэрэг тутамд хэмнэсэн зардлаа давсан орлого гэж үзэн шүүхийн өөрийн санд байрлуулах эрхтэй болох бол тодорхой хэргийн зардал хэтэрсэн тохиолдолд нэмж санхүүжилт гаргуулахгүй, харин хэмнэсэн зардлаас цугларан сангаасаа зарцуулдаг зохицуулалттай байна. Шүүхийн өөрийн сан нь алдагдалтай байж болохгүй бөгөөд алдагдалд орсон тохиолдолд Шүүхийн зөвлөлөөс санхүүжилт нэмж алдагдалгүй болгох бөгөөд тухайн шүүхийн дараагийн хэмнэсэн зардлаас тодорхой хувиар эргүүлэн гаргуулдаг байна.⁹⁶ Энэ нь манай улсын давсан орлого зарцуулах зохицуулалттай ойролцоо боловч шүүх өөрийн сантай байх, санд дутагдсан санхүүжилтийг шүүхийн зөвлөлөөс нэмж өгөөд эргүүлэн авах зэрэг зохицуулалтаараа ялгаатай байна. Мөн Их Британи, Нидерланд, Шотланд улсуудад шүүх нь төрийн төсвөөс өөр санхүүгийн эх үүсвэртэй байхыг зөвшөөрсөн хуулийн зохицуулалттай гэдгийг эх сурвалжид дурджээ.⁹⁷ Монгол Улсын хувьд шүүх нь төсвөөс бусад эх үүсвэрээс санхүүжихийг үндсэндээ хориглодог бөгөөд зарим тохиолдолд олон улсын байгууллагын санхүүжилтийг ашиглаж байсан нь энэхүү судалгааны нэгдүгээр бүлгийн судалгаанаас харагдаж байна. Манай улсад шүүх өөрийн орлогоос санхүүжих боломж тодорхой хэмжээнд байдаг боловч өөрийн гэсэн сантай байж тухайн сангийн үлдэгдлийг жил дамнан удирдах, зарцуулах боломжгүй, ийм боломжийг нээхийн тулд төсвийн тухай хууль зэрэг хэд хэдэн хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж шийдвэрлэх нь дамжиггүй гэж үзэж болно.

Харин шүүхийн байгууллагын төсвийг батлахдаа дээд шүүхийн төсвийг тусад нь баталдаг түршлага байдаг эсэхийг шалгаж үзэхэд АНУ, Канад, Австрали, Их Британи гэсэн нэгдсэн улсын зохион байгуулалттай улс орнуудад Улсын дээд шүүх нь тусдаа төсөв батлах нь тодорхой байдаг бөгөөд Финланд улсын дээд шүүх (Korkein oikeus) болон Нидерланд улсын дээд шүүх (Hoge Raad)-ийн аль аль нь доод шатны шүүхүүдээс тусдаа төсөвтэй боловч шүүхийн нийт төсөвт нэгтгэгдэн парламентаар батлагддаг, ОХУ, Энэтхэг улс болон БНХАУ-ын дээд шүүхийн төсөв нь бусад шүүхийн төсвөөс тусдаа бэлтгэгдэж парламентаар батлагддаг байна. Үүнээс үзвэл тухайн улс орны төрийн байгууламжаас шалтгаалан холбооны улсууд болон Хятад, Энэтхэг зэрэг хүн ам олонтой томоохон улсуудын дээд шүүхийн төсвийг бусад шүүхээс тусдаа бэлтгэн баталдаг, харин нэгдмэл улсуудын хувьд дээд шүүхийн төсвийг бусад шүүхүүдийн төсвөөс ялгаатай баталдаг

⁹⁶ Нидерланд улсын шүүхийн зөвлөлийн албан ёсны веб сайт дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10):

<https://www.rechtspraak.nl/SiteCollectionDocuments/The-Financing-System-of-the-Netherlands-Judiciary.pdf>

⁹⁷ Alexander Rosselli. Judicial Independence and the Budget: A Taxonomy of Judicial Budgeting Mechanisms. Indiana Journal of Constitutional Design. 2020. Vol.5, Article 2. 9-р тал

боловч шүүхийн нийт төсөвт багтаан парламентаар хэлэлцдэг ерөнхий хандлага ажиглагдаж байна.

Шүүхэд ирэх хэргийн ачааллыг илүү нарийн тооцох зорилгоор “хэргийн ачааллыг жигнэн үнэлэх” гэдэг ойлголтыг анх АНУ-д 1970 оны үеэс эхлэн хэрэглэж шүүхэд тодорхой хэрэг, маргаан шийдвэрлэх хугацаа, хийх ажлын хэмжээг тооцоолж байсан байна.⁹⁸ Харин өнөө үед АНУ-д хэргийн ачааллыг жигнэн үнэлэхдээ (1) Хэргийн тоо хэмжээ буюу хэрэг маргааныг хэргийн төрлөөр ангилан гаргасан тоо (2) Хэргийн эзлэх жин буюу шүүгч, шүүхийн ажилтны тодорхой хэрэг шийдвэрлэхэд зарцуулсан хугацааг минутаар, хэргийн төрлөөр дундажлан гаргасан тооцоолол, (3) Шүүгчийн жилийн үнэлэмж буюу шүүгч, шүүхийн ажилтны хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулах боломжит хугацааг минутаар тооцсон дүн гэсэн үндсэн гурван элементэд тулгуурлан загварчилсан байдаг байна. Хэргийн эзлэх жинг шүүгч, шүүхийн ажилтнууд өөрийгөө үнэлэх аргачлалын дагуу гаргадаг ажээ.⁹⁹

Латин америкийн орнуудын шүүхийн үр дүнд суурилсан төсөвлөлт нэвтрүүлсэн туршлагыг үнэлж судалсан сүүлийн үеийн нэгэн судалгаанд шүүхийн төсөв батлахад харгалзан үзэх үзүүлэлтүүдийг (1) гүйцэтгэлийн үзүүлэлт, (2) үр дүнд хүрэхэд шаардлагатай үр чадварыг менежер эзэмшсэн байдал, (3) хүрэх үр дүндээ зориулан гаргаж байгаа менежерийн хичээл зүтгэл буюу урам зориг, (4) шийдвэр гаргахдаа мэдээллийг ашиглаж байгаа байдал гэсэн үндсэн дөрвөн тулгуур хэмжүүрт багцлан үзэх боломжтой гэж дурджээ.¹⁰⁰

Монгол Улсын хувьд 2050 оныг хүртэл хөгжих хөгжлийн бодлогын баримт бичгээ тусгайлан боловсруулж хүрэх үр дүнгээ тодорхойлсон зэргээс үзвэл гүйцэтгэл болон үр дүнд суурилсан төсөвлөлтийн загварт бүрэн шилжиж бодлогын баримт бичигт төлөвлөсөн үр дүндээ хүрэх зорилго тавьж ажиллаж байгаа нь талархууштай. Гэвч гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлт, менежментийг хэрэгжүүлэхэд тоон болон чанарын зорилтот судалгаанд үндэслэн шүүхийн ачаалал, төсөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхой болгох, судалгааны үр дүнд үндэслэн шүүхийн төсвийг боловсруулж түрших, боловсруулсан төсвийн төслийг хууль тогтоомжийн зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг тусгайлан шалгах зэргээр урьдач нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байх шаардлагатай. Эстони улс 8 жил орчим хугацаанд гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт болон менежментийг улс орондоо нэвтрүүлэхээр хичээж байгаа боловч зорилгодоо хүрч чадаагүй, одоогоор энэ загварын дагуу ажиллах, тайлагнах шаардлагатай төрийн албан хаагчдын 70 орчим хувь нь л гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ашигладаг болсон нь үр дүн болон гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, менежментийг хэрэгжүүлэх нь өөрөө тийм ч хялбар ажил биш болохыг харуулж байна. Ялангуяа шүүхийн үйл ажиллагаанд гүйцэтгэл, үр дүнд суурилсан менежментийг нэвтрүүлээгүй байхдаа төсвийн төлөвлөлтийг энэ төрлийн загвараар боловсруулж, батлуулах нь тийм ч оновчтой арга хэмжээ биш байх магадлалтай. Учир нь шүүхэд ирж байгаа хэрэг, маргаан тутамд шүүхээс зарцуулж байгаа дундаж хугацаа болон зардлыг оновчтой тодорхойлох аргачлалыг тогтоох, түрших, шүүгч, шүүхийн ажилтнуудын гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөв боловсруулахад оролцох оролцоог тодорхой төлөвлөж, тэднийг сургах, сургалтын үр дүнг үнэлэх зэрэг ажлыг урьдчилан гүйцэтгэж байж шүүх

⁹⁸ European Commission for the Efficiency of the Justice, Council of Europe. Case weighting in judicial systems: CEPEJ studies No.28. 2020. 4 -р тал

⁹⁹ Мөн тэнд.

¹⁰⁰ René Palacios Garita. Rule of law, budget and management by results of judicial institutions in Latin America: an approximation. 2023.

тус бүрийн онцлогийг харгалзсан төсвийн төслийг үндэслэлтэй гаргах, үүнд үндэслэн улсын хэмжээнд шүүхийн нийт төсвийг тооцон гаргаж эрх бүхий этгээдийн өмнө гаргасан тооцооллоо бүрэн хамгаалах хэмжээнд бэлтгэсэн байх шаардлагатай юм.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглохоор заасан, шүүхийн төсвийг тухайн төсвийн жил бүрд зориулан баталж байгаа, шүүхийн төсвийг батлахдаа шүүх тус бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд шууд үндэслэдэггүй зэргээс үзэхэд манай улсын шүүхийн төсөвлөлт нь үндсэндээ аажмаар өсөх загвартай улс гэж үзэх үндэслэлтэй байна. Харин хөгжлийн стратеги баталж шүүхийн үйл ажиллагааны хүрэх үр дүнг тодорхойлсон, ШЕЗ-өөсөнэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгүүлж, гарсан үр дүнд нь дүн шинжилгээ хийж байгаа зэргээс үзэхэд гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлтөд шилжихээр төлөвлөсөн буюу шүүхийн төсөвлөлтийн шинэ загварыг хэрэгжүүлэх шилжилтийн үедээ явж байгаа нь ажиглагдаж байна.

Европын шүүхийн зөвлөлийн сүлжээ (ENCJ)-ний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн талаарх тайланд дараах 12 зөвлөмжийг тусгажээ. Үүнд:¹⁰¹

1. Бодит бөгөөд ил тод шалгууртай байх;
2. Шүүхийн зөвлөл эсвэл шүүхүүдийг төлөөлөх эрх бүхий байгууллагыг төсөв хэлэлцэн батлах үйл явцад ямагт оролцуулах замаар засаглалын эрх мэдлийг тэнцвэржүүлэх;
3. Шүүхийн захиргааны зардал, сургалтын зардал зэрэг тодорхой зардлыг багтаасан шүүхүүдийн төсвийг Шүүхийн зөвлөл эсвэл эрх бүхий ижил төрлийн байгууллагын хяналтын дор боловсруулдаг байх;
4. Шүүхийн үйл ажиллагаа явуулахад хангалттай хэмжээний эх үүсвэртэй төсөв батлах;
5. Шүүхийн төсвийг жил бүрд нь санхүүжүүлэхээс илүү урт хугацааны санхүүжилттэй төсөвлөхөөр төлөвлөж, улс төрийн нөлөөллөөс шалтгаалан өөрчлөгдөх үр дагавраас сэргийлэх;
6. Шүүхийн төсөвт нэн түрүүнд тусгах асуудлын эрэмбэ дарааллыг шүүхийн эрх бүхийн байгууллагаар тодорхойлуулах;
7. Шүүхийн төсөвт орчин үеийн хөгжилтэй холбоотой өөрчлөлтүүдтэй нийцсэн шинэчлэлт, сайжруулалт хийх эх үүсвэрийг тусгадаг байх;
8. Шүүхийн төсвийг танах зайлшгүй шаардлагатай тулгарсан байлаа ч (1) шүүн таслах ажиллагааны үндсэн удирдлагыг хэрэгжүүлэх болон дээд шатны шүүхэд хандах зохицуулалтыг алдагдуулах, (2) шүүхийн бус хэлбэрээр хэрэг, маргаан шийдвэрлэхийг дэмжих, (3) хэрэг маргаан шийдвэрлэхэд тогтсон хэмжээний торгууль оногдуулан шийдвэрлэх зэргээр шүүгчийн оролцоог үгүйсгэхэд нөлөөлөх байдлаар төсвийг багасган зохицуулж болохгүй.
9. Шүүх нь тодорхой хэрэг маргааныг бусдаас нь ялган илүү чухал гэж тооцох хандлагыг гаргах ёсгүй боловч тодорхой төрлийн хэрэг, маргаан шийдвэрлэхэд шүүхээс гарах зардал өндөр байх тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод шалгуурт үндэслэн тухайн хэргийг бусдаас ялган чухалчлан зохицуулж болно.
10. Шүүгчийн болон шүүхийн ажилтнуудын цалин нь мэргэжлийн хариуцлага, шүүхэд итгэх итгэлийг хадгалж чадах хэмжээнд байх баталгааг бий болгох нь зүйтэй. Ялангуяа шүүгчийн цалин хөлсний баталгааг үндсэн хуулиар зохицуулах нь зөв юм.
11. Шүүхийн төсөвт шүүгчийг анх ажиллаж эхлэхээс нь эхлүүлэн цаашид ч зохих байдлаар, тогтмол сурган чадавхжуулахад хүрэлцэхүйц хэмжээний төсвийг багтаана.
12. Шүүгч, шүүхийн ажилтанд захиргааны чиг үүргийг хариуцуулан ажиллуулах бол шаардлагатай сургалтад хамруулна.

¹⁰¹ ENCJ Report- Funding of the Judiciary 2015-2016 adopted by the General Assembly 3rd June 2016

Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс гаргасан эдгээр зөвлөмжүүдийг Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулж үзвэл шүүхийн төсвийн ил тод болон бодит шалгууруудыг ашиглан баталдаг гэж үзэх үндэслэл мүү, ихэвчлэн өмнөх жилийн төсвийг бууруулахгүй гэсэн үндсэн зарчмаар ажиллаж байгаа боловч ийнхүү төсвийг боловсруулахдаа төгрөгийн ханшийн уналт, байр ашиглалтын болон орчуулгын зэрэг бусад үйлчилгээний үнэ нэмэгдэх зэрэг зарим хүчин зүйлсийг харгалзан үздэг эсэх нь тодорхойгүй, төсвийг тухайн төсвийн жилд зориулан баталж байгаа нь хөгжлийн стратегийн баримт бичигт дурдсан хүрэх үр дүнд чиглэсэн, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Аажмаар өсөн нэмэгдэх төсөвлөлтийн загвар нь 1950-1960 оны сүүл хүртэл АНУ-д үргэлжилсэн эдийн засгийн өсөлтийн үед хэрэгжиж байсан загвар боловч 1970-аад онд эдийн засгийн уналтаас шалтгаалан “аажмаар буурах төсөвлөлт” болж хувирч байсан талаар судлаач дурдсан байна.¹⁰² Аажмаар нэмэгдэх төсвийн загварыг ашигласнаар шүүхийн төсвийн хэмжээг улсын нийт төсвийн хэмжээтэй үялдуулан нэмэгдүүлж баталдаг тул инфляц, түүнийг дагасан түрээс, ашиглалт зэрэг бусад зардлын өсөлт зэрэг эдийн засгийн сөрөг хүчин зүйлийг төдийлөн тооцохгүй байх магадлалтай. Мөн төсөв хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар хуульд өөрчлөлт оруулж шүүхийн төсвийг багасгах ч боломжтой байдгийг гадаадын эх сурвалжуудад дурджээ. Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаанд энэ загвар нь төдийлөн тохиромжтой биш гэж үзэх үндэслэлтэй тул цаашид улс орны эдийн засгийн ерөнхий нөхцөл байдалтай бус шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай зардал, эх үүсвэрийг судалгааны үр дүнгээр нотлон төсөвт тусгуулж батлуулдаг өөр загварт шилжих нь зөв юм.

Цаашид Монгол Улсын шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах асуудлыг илүү нарийвчлан судалж улам сайжруулахад чиглэсэн судалгаа, дүн шинжилгээний ажлуудыг гүйцэтгэж, төсөвлөлтийн гүйцэтгэлд эсвэл үр дүнд суурилсан тохиромжтой загварыг боловсруулан турших, хэрэгжүүлэх шаардлагатай.

Бүлгийн дүгнэлт

Дэлхийн түүхээс үзвэл 1950 оны үеэс гүйцэтгэл болон үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, менежментийн үзэл баримтлалууд үүсэн хөгжиж эхэлсэн бөгөөд 1980 оны үед төрийн удирдлагын салбарт илүү нэвтэрч улс орнууд нийтийн удирдлагын шинэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүний дараахан буюу 1990 оны үеэс олон улсын хэмжээнд шүүхэд ирэх хэргийн ачаалал нэмэгдэж, шүүхийн төсөв, санхүү хүрэлцээгүй болох асуудал нийтлэг болж эхэлсэн бөгөөд шүүхийн салбарт төсөвлөлтийн шинэ загварыг хэрэгжүүлэх шаардлага бий болжээ.

Улс орнуудын шүүхийн төсөвлөлтийн хэлбэрийг авч үзвэл ихэвчлэн эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнууд гүйцэтгэл болон үр дүнд суурилсан загварыг хэрэгжүүлж эхэлсэн бол шилжилтийн үеийн эдийн засгийн нөхцөлд улс орнууд аажмаар өсөх төсөвлөлтийн загвар ашиглах нь нийтлэг байна. Харин БНХАУ зэрэг маш цөөн улс оронд л тэгд суурилсан төсөвлөлтийг ашиглаж байгаа нь ажиглагдлаа.

¹⁰² Allen Schick. Incremental Budgeting in a Decremental Age. Policy Sciences. Vol. 16, No. 1 (Sep., 1983), 1-p тал

Манай улсын хувьд шүүхийн төсвийг батлахдаа аажмаар өсөх төсөвлөлтийн загварыг илүү ашиглаж байгаа шинжтэй боловч үр дүнд суурилсан буюу урт хугацааны төлөвлөгөөнд чиглэсэн арга хэмжээнүүдийг санаачлан шүүхүүдийн хүрэх үр дүнг урьдчилан тодорхойлох ажлыг гүйцэтгэж байгаа нь сайшаалтай.

Дэлхийн ихэнх улс орнууд гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг шүүхийн салбарт ашиглаж байгааг эх сурвалжууд харуулж байна. Өнөөгийн Монгол Улсад шүүхийн төсвийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн эсвэл гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн аль хэлбэрт үндэслэн батлуулах нь зүйтэй болох асуудлыг судалж үзэхэд энэ хоёр загвар угаас ижил төстэй тал ихтэй байх тул үр дүнд суурилсан төсөвлөлтийн урт хугацааны стратегид тулгуурлах зэрэг зарим тодорхой арга хэлбэрийг гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн өмнөх жилүүдийн гүйцэтгэлийн дунджаар таамаглан тооцоолох зэрэг арга хэлбэртэй хослуулан дотоодын шүүх, шүүхийн тамгын газар тус бүрийн онцлогийг бүрэн тусгасан байдлаар төсвийг боловсруулж батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн гүйцэтгэл болон үр дүнд суурилсан аль ч хэлбэрийг ашигласан шүүгч, шүүхийн ажилтнуудын идэвхтэй оролцоог хангасан мэдээлэл цуглуулах тогтмол үйл ажиллагааг бий болгох, тэдний цуглуулсан мэдээлэлд үндэслэн төсвийг боловсруулах шаардлагатай байна. Үүнтэй холбогдуулан шүүхийн ерөнхий шүүгчид болон шүүхийн тамгын газрын дарга зэрэг менежерийн түвшний ажилтнуудад санхүүгийн боловсрол олгох, тэдний хичээл зүтгэлийг нэмэгдүүлэх байдлаар хүрэхээр төлөвлөсөн үр дүнг бий болгохыг зорих нь чухал болох нь харагдаж байна.

Финланд, Эстони, Нидерланд, АНУ, Их Британи зэрэг улсуудын туршлагаас үзвэл шүүгч, шүүхийн ажилтнуудын нэг хэрэг шийдвэрлэхдээ зарцуулах дундаж хугацаа болон нэг хэрэгт шүүхээс зарцуулах зардлын дүнг өнгөрсөн 3-5 жил зэрэг тодорхой хугацааны үзүүлэлтээс дүгнэн гаргаж, төсвийн дараагийн жилд эдгээр үзүүлэлт ямар байх талаар таамаглал дэвшүүлэн төсвөө боловсруулдаг байдал нийтлэг байна. Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс гаргасан зөвлөмжид ч төсвийг жил бүрд нь санхүүжүүлэхээс илүү урт хугацааны санхүүжилттэй төсөвлөхөөр төлөвлөж, улс төрийн нөлөөллөөс шалтгаалан өөрчлөгдөх үр дагавраас сэргийлэхийг зөвлөснийг энд дурдах нь зүйтэй байна.

Мөн шүүхийн төсвийг боловсруулахдаа хууль зүйн яам, засгийн газар зэрэг төсөв хянах, батлах эрх бүхий этгээдтэй шүүх тус бүрээр эсвэл шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхүүдийг төлөөлөн хэлэлцэн тохиролцох, эсвэл иргэн, эрүү, захиргааны зэрэг салбар бүрийн шүүгч нар төсөв батлах аргачлалаа өөрсдөө зөвшилцөн тохиролцох байдлаар боловсруулж төсөв батлах эрх бүхий этгээдэд хүргүүлэх зэрэг ялгаатай байдлаар боловсруулж байна. Манай улсын хувьд шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн төсвийг боловсруулж хүргүүлдэг. Гэвч шүүхийн төсвийг ихэвчлэн багасгаж, хүрэлцээгүй байдлаар, ялангуяа шүүхийн байрны асуудлыг шийдвэрлэх боломжгүй байдлаар эцэслэн баталж байгаа нь энэхүү судалгааны үр дүнгээс илэрхий харагдаж байна.

Оросын Холбооны Улсын хувьд Дээд шүүх, ерөнхий харьяаллын шүүх, арбитрын шүүхийн санхүүжилтийг холбооны хуулиар баталсан стандартын үндсэн дээр Улсын төсөвт тус тусад нь тусгаж парламентаар батлуулдаг бөгөөд шүүхийн төсвийг зөвхөн Бүх Оросын Шүүгчдийн Их Хурал эсвэл ОХУ-ын Шүүгчдийн зөвлөлийн зөвшөөрлөөр бууруулж болохоор зохицуулж шүүхийн хараат бус байдлыг хамгаалдаг байна. Манай улсад ч мөн ШЕЗ-өөс хүргүүлсэн төсвийг

ямар тохиолдолд, ямар үндэслэлээр бууруулах асуудлыг тодорхой зохицуулах шаардлага байгаа гэж үзэж байна.

Гадаадын зарим улсын туршлагаас үзэхэд шүүхэд онцгой төвөгтэй хэргүүдийг хянан шийдвэрлэхэд зориулсан төсвийг тусгайлан баталдаг, ийм хэргүүдийг шийдвэрлэхэд чиглэсэн тусгай зохицуулалт баталдаг, өмгөөлөгчийн болон шүүхийн зардлыг бусад байгууллагатай хамтран шийдвэрлэдэг зэрэг тодорхой зохицуулалтууд байгаа нь харагдаж байна. Манай улсын хувьд олон оролцогчтой, шийдвэрлэхэд онцгой төвөгтэй хэргийг хэрхэн санхүүжүүлэх, зохион байгуулах асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хуль тогтоомжид дутмаг байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа ийм тохиолдолд шүүхийн санхүүжилт дутагдах бол тодорхой санхүүгийн эх үүсвэрийг бэлэн байлгах, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал үүсэх тохиолдолд оюутан, сайн дурын хүмүүсийг түр ажиллуулах боломжийг бүрдүүлэх, илүү цаг ажиллах болон бичиг хэрэг, шуудан холбоо, байр ашиглалт, шүүхийн танхим түрээслэх зэрэг зардал өсөх зэрэг асуудлыг тодорхой байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн шүүх нь өөрийн эх үүсвэр бүрдүүлэх, зарцуулах асуудлыг зөвхөн давсан орлого зарцуулах хэмжээнд хязгаарлаж байгааг өөрчлөх боломжийг судалж үзэх нь зүйтэй. Нидерланд зэрэг улсуудын жишгээр шүүхийн өөрийн сан байгуулж тухайн сангийн ашиг, алдагдлын харьцааг тооцож дүгнэх нь шүүх зардлаа өөрөө хянаж зохион байгуулалтдаа анхаарах, төсвийн хөрөнгийн зарцуулалтад нарийн хяналт тавих үндэслэл болж гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлтийн загварыг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд эергээр нөлөөлөх боломжтой гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй юм. Гэвч нөгөө талаас төсвийн тухай хууль зэрэг хэд хэдэн хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж шийдвэрлэх шаардлагатай болохыг ч харгалзан холбогдох байгууллагуудтай зөвшилцөх шаардлагатай юм.



СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дэлхийн ихэнх улс орнууд шүүх нь хараат бусаар ажиллах, ялангуяа санхүүгийн хувьд хараат бус байж иргэдийн итгэлийг бататгах тухай зохицуулалт байдаг боловч шүүхийн санхүүжилт, төсөвлөлт нь бодит байдал дээрээ төдийлөн хүрэлцээтэй бус, зарим шалтгааны улмаас шүүхийн санхүүжилтийг хасаж байхад нөгөөтээгүүр үсрэнгүй хөгжлийг даган шүүхээр шийдвэрлүүлэх хэрэг, маргааны тоо огцом өсөж байгаа нь дэлхий дахинаа тулгамдсан асуудал болж байна. Монгол Улс ч энэ нөхцөл байдлыг тойрч гарахгүй бөгөөд шүүхийн төсвийн хүрэлцээгүй байдлын талаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон хөндлөнгийн судалгааны дүгнэлт, шүүхийн төсвийн талаар нэгдүгээр бүлгээс үзэх боломжтой.

Үндсэн хуульд заасан шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах суурь зарчим нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг Засгийн газар бүрдүүлж, УИХ баталж, ШЕЗ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд батлагдсан төсвийг ил тод, хариуцлагатай захиран зарцуулах үүргээр илэрч буй. Шүүхийн төсвийн төслийг тухайн жилд хүртээмжтэй байдлаар боловсруулан танилцуулж ирсэн хэдий ч бууруулан баталж төсөв хүрэлцээгүй хэвээр 30 жил үргэлжилжээ. ХЗБХ шүүхийн төсвийг хянаж, Сангийн яаманд хүргүүлж, улсын төсөвт нэгтгүүлж байгаа энэхүү зохицуулалт нь шүүхийн төсвийн Засгийн газраас хараат байдлыг бууруулж буй сайн тал ажиглагдаж байгаа хэдий ч төсвийг хянаж буй байнгын хороонд шүүхийн төсвийг бууруулах эрх хэмжээг олгож байх талтай байгааг анхаарах нь зүйтэй.

Шүүхийн төсвийг батлах үйл ажиллагаа нь гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагын нэгэн адил улсын төсөвт нэгтгэгдэж ирсэн бол Шүүхийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар шүүхийн төсвийн төслийг ХЗБХ хэлэлцэж, хянаад Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яам тухайн хянан хэлэлцсэн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсөвт нэгтгэн УИХ-д хүргүүлэх үүрэгтэйгээр хуульчилсан нь шүүхийн санхүүжилтийн хувьд эерэг үр нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлт байсан хэдий ч хуулийн хэрэгжилтийн явцад бэрхшээлтэй зарим асуудал урган гаргасан хэвээр байна. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын зардлын хасагддаг шалтгааны нэг нь төсвийн гүйцэтгэлийг хянах боломжгүй байдаг асуудал гэдгийг ч дурдах нь зүйтэй байна.

Энэхүү судалгааны хүрээнд шүүхийн төсвийг ХЗБХ-ны хурлаар хэлэлцсэн сүүлийн 3 жилийн хурлын тэмдэглэлтэй танилцахад шүүхийн цалингийн санг орон тооны нэмэгдлээс бусад ажлын ачаалал, зэрэг дэвийн нэмэгдэл, урамшууллыг цалингийн санд нэмэгдүүлэхээс татгалзах, шүүхийн хөрөнгө оруулалтын зардлыг өмнөх жилүүдэд төсөвлөсөн хэмжээнд батлах эсвэл огт батлахгүй байх, бүхэлд нь төсөвлөн оруулж ирсэн төсвийг 2-3 жилийн хуваарьт оруулахаар хойшлуулах, түүнчлэн зөвхөн өөрийн сонгогдсон тойргийн шүүхийн хөрөнгө оруулалтыг нааштайгаар дэмжих зэрэг улс төр, эдийн засгийн зарим нөлөөлөл байх тал ажиглагдлаа. Аливаа хуулийн шинэлэг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгардаг энэ мэт асуудлыг ёс зүйн болон хууль зүйн хүрээнд даван гарах зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний үр дүнд шүүхийн бие даасан,

шүүгчийн хараат бус байдал хангагдаж, иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх баталгаажих ёстой.

Шүүхийн төсвийг боловсруулах, батлах, зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагааг хуулиар зохицуулсан хэдий ч зарцуулалтын хяналтыг шүүх бүрэн бие даан хэрэгжүүлэх боломжгүй хэвээр байгаа нь бие даасан эрх мэдлийн төсвийн зарцуулалтад гүйцэтгэх эрх мэдэл эдийн засгийн нөлөөлөл тогтоож ирсэн хэвшмэл ойлголтоос үүдэлтэйг судалгааны үр дүнгээр дүгнэлээ. Шүүхийн төсвийг ил тод, хариуцлагатай, үр дүнтэйгээр захиран зарцуулах эрх хэмжээг эрүүл мэнд, боловсролын салбарт туршин хэрэгжүүлж буй гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг загварт аажмаар шилжилт хийх явцдаа тодорхой болгох шаардлагатай бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн хэвшмэл хяналтыг төсвийн хуульд нийцүүлэн эхний ээлжид өөрчлөх нь зүйтэй юм.

Шүүхийн санхүүжилтийн хүртээмжгүй байдлыг халахын тулд улсын төсвийн тодорхой хувь (3-2 хувь)-иас бууруулахгүйгээр шүүхийн төсвийг батлах, тухайн хувийг хуульчлах талаар санал гаргаж байсан хэдий ч эдийн засгийн хөгжил сул улсын хувьд энэ нь зөв зохицуулалт биш юм.

Шүүхийн тухай хуулиудад шүүхийн төсвийг өмнөх оны төсвөөс бууруулахгүй, тэр дундаа шүүгчийн цалин, хөлсний зардлыг бууруулахгүй байх зохицуулалтыг хуульчлан хэрэгжүүлж байгаа ч шүүхийн бие даасан байдлыг хангах хөрөнгө оруулалтын зардлыг тогтмол хасаж ирсэн нь өнөө хир нь үргэлжилж байна.

Шүүх улсын болон орон нутгийн төсөвт улсын тэмдэгтийн хураамжийн, шүүхийн тусгай архивын үйлчилгээний төлбөрийн гэсэн 2 төрлийн орлого төвлөрүүлж ирсэн байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан үйлчилгээний хураамжийг Төсвийн тухай хуулиар орон нутгийн орлогод төвлөрүүлж ирсэн бөгөөд энэхүү орлогын зарцуулалтыг Засгийн газар шүүхийн хөрөнгө оруулалтын зардалд олгох боломж бий. Харин шүүхийн тусгай архивын үйлчилгээ үзүүлсний орлогыг тухайн жилийн Төсвийн хуулиар ШЕЗ-ийн төсөвт оруулан баталж ирсэн нь жилийн эцэст зарим жилд давсан орлого, зарим жилд төсвийн зарцуулалтад хүрэлцэхгүй нөхцөл байдал үүсэхийг ч үгүйсгэхгүй юм.

Шүүхэд шаардлагатай хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусган батлуулахын тулд шүүхийн үйл ажиллагааны үр дүнг тоон илэрхийлэлд хувирган төсөвт мөнгөн хэлбэрт шилжүүлэн тусгуулах буюу гүйцэтгэл, үр дүнд суурилсан загварт шилжих шаардлага шүүхийн салбарт тулгамдсан асуудал болоод байна.

Шүүхийн салбарын гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт нь дэлхийн хөгжингүй орнуудад илүү нийтлэг ажиглагдаж байгаа бөгөөд Монгол Улс ч гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлтийн загварт шилжихээр төлөвлөж байгаа нь талархууштай боловч гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, менежментийг шүүхийн салбарт өнөөдөр ямар түвшинд хэрэгжүүлэх боломжтойг юуны өмнө маш нарийн дүгнэж байж хөгжлийн дараагийн үр дүнд хүрнэ гэдгийг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, Эстони улс 8 жил орчим хугацаанд гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт болон менежментийг улс орондоо нэвтрүүлэхээр хичээж байгаа боловч зорилгодоо одоо хэр нь хүрч чадаагүй, энэ загварын дагуу ажиллах, тайлагнах шаардлагатай төрийн албан хаагчдын 70 орчим

хувь нь л гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ашигладаг болсон¹⁰³ нь үр дүн, гүйцэтгэлд суурилсан менежментийг хэрэгжүүлэх нь тийм ч хялбар ажил биш болохыг харуулж байна.

Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс гаргасан 12 зөвлөмжийг Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулж үзвэл төсвийн ил тод болон бодит шалгууруудыг ашиглан шүүхийн төсвийг батлуулж байгаа гэж үзэх үндэслэл тааруу, ихэвчлэн өмнөх жилийн төсвийг бууруулахгүй гэсэн үндсэн зарчмаар ажиллаж байгаа боловч ийнхүү төсвийг боловсруулахдаа ханшийн уналт, хөдөлмөрийн зах зээл дээрх цалингийн өсөлт, шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын ашиглалт, түрээсийн зардлын өсөлт зэрэг хүчин зүйлсийг бодитоор харгалзан үздэг эсэх нь эргэлзээтэй гэж үзэж байна.

Шүүхийн төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх үе шатанд ШЕЗ хангалттай хэмжээнд оролцдог гэж тооцож болох боловч цаашид төсвийг гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд харгалзуулан үрт болон дунд хугацааны стратеги зорилтуудтай нягт холбон хэд хэдэн жилээр нь боловсруулж шүүхийн хараат бус байдлыг хангах шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

Аажмаар өсөн нэмэгдэх төсөвлөлтийн загварын сул талыг харгалзан үзэж манай улс цаашдаа шүүхийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсөвлөлтөд шилжих нь зүйтэй юм. Үүний тулд шүүхийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг мөн төсөвт тусгуулж байгаа зардалтайгаа хэрхэн холбож хэрэгжүүлдэг гадаад улсуудын сайн жишгээс үлгэр авч хэргийг жигнэн үнэлэх, хэргийн ачаалал болон хэргийн төрөл тус бүрд гарч байгаа дундаж зардлыг тооцох аргачлалыг шинээр боловсруулж туршин хэрэгжүүлэх шаардлагатай.

Гадаадын зарим улсад шүүхийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж байгаа аргачлалуудыг авч үзвэл шүүхээр шийдвэрлүүлэхээр гаргасан гомдол, нэхэмжлэлийн тоо, шийдвэрлэж дуусаагүй хэргийн тоо, хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаа дундаж хугацаа, нэг хэргийг шийдвэрлэхэд оролцож байгаа шүүгч, шүүхийн ажилтны зарцуулах хугацаа, хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч, орчуулагч оролцуулж байгаа давтамж зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааны онцлогт тохирсон байдлаар ашиглаж дадах, тэдгээрийг статистик болгон хувиргаж шаардлагатай хэмжээний төсвийг батлуулах нь нийтлэг байна. Харин Монгол Улсад энэ төрлийн тоон үзүүлэлтүүдийг шүүх тус бүрийн онцлогийг илэрхийлсэн байдлаар гаргаж байсан түршлага ажиглагдсангүй. Энэ нь шүүх болон ШЕЗ-д энэ төрлийн судалгааг гүйцэтгэх хүний нөөц, түршлага болон санхүүжилт дутмаг байгаатай холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Цаашид шүүхийн ачаалал, иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргаан тус бүрд оногдох төрөөс гарч байгаа нийт зардлын талаарх тоон болон чанарын судалгааг тогтмол гүйцэтгэх чиг үүргийг ШЕЗ бүрэн хариуцаж, шүүгч, шүүхийн ажилтнууд энэ судалгааг хэрэг тус бүрээр болон хэрэг, маргааны ангилал бүрээр нэгтгэн боловсруулах үүрэгтэй байхаар журамлан зохицуулах нь шүүхийн төсвийг боловсруулж батлахад чухал үр нөлөөтэй ажил болно гэж үзэж байна.

Мөн хэрэг маргааныг жигнэн үнэлэх аргачлал нь шүүхүүдэд төсвийг тэнцвэртэй, тэгш хуваарилах, шүүгчид оногдох хэргийн ачааллыг нийт шүүгчдэд шударгаар хуваарилах, хэрэг, маргаан шийдвэрлүүлж байгаа иргэдийн цаг, зардлыг хэмнэх зэрэг олон давуу тал байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Нөгөөтээгүүр шүүхийн зардлыг тодорхой стандарт аргачлалаар тогтоох нь цөөн тооны шүүгчтэй, алслагдмал орон нутгийн шүүхүүдэд төдийлөн

¹⁰³ Federica Viapiana, Marco Fabri. Administration of Justice and Courts' Budget: An Independence and a Managerial Issue. Public Sciences & Policies. vol. V, N.01, 2019, 64-р тал

тохиромжтой бус байх магадлалтай бөгөөд ийм нөхцөл бүрдсэн шүүх манай улсад цөөнгүй байгааг ч анхаарах нь учиртай. Иймд цөөн тооны шүүгчтэй, алслагдмал зэрэг онцгой нөхцөл байдалд ажиллаж байгаа шүүхүүдэд тохирох тусгай аргачлалыг боловсруулж турших нь зөв гэж үзэж байна.

Түүнчлэн Монгол Улсын хувьд тодорхой шүүхэд ирж буй хэрэг, маргааны ачааллаас шалтгаалаад шүүгч, шүүхийн ажилтны илүү цаг, амралтын өдөр ажилласны нэмэгдэл зэргийг тооцож гаргахад цалингийн сан бусад ачаалал багатай шүүхүүдээс илүү өндөр дүнтэй тогтоогдох нь зөв зарчим юм. Цалингийн нэмэгдэлгүйгээр ажиллах ажлын ачааллаас шалтгаалан шүүхүүд хүний нөөцийн дутагдалд орох эрсдэлтэй байна. Ийнхүү илүү цагаар болон амралт, баяр ёслолын өдрүүдээр ажиллаж байгааг тогтоосон судалгааг нотолгоонд суурилан бүрдүүлж төсөв батлах эрх бүхий этгээдийн өмнө цалингийн зардлыг өсгөх үндэслэлийг хамгаалах зэргээр шүүхүүд хоорондын ажлын ачаалал болон цалингийн зардлын хэмжээг тэнцвэржүүлэхэд ч гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ нь нөгөө талаар Европын шүүхийн зөвлөлийн сүлжээнээс гаргасан бодит бөгөөд илт тод шалгууртай байх, шүүхийн үйл ажиллагаа явуулахад хангалттай хэмжээний эх үүсвэртэй төсөв батлах, төсөвт орчин үеийн хөгжилтэй холбоотой өөрчлөлтүүдтэй нийцсэн шинэчлэлт, сайжруулалт хийх эх үүсвэрийг тусгадаг байх, шүүгчийн болон шүүхийн ажилтнуудын цалин нь мэргэжлийн хариуцлага, шүүхэд итгэх итгэлийг хадгалж чадах хэмжээнд байх баталгааг бий болгох зарчимд нийцэх юм.

Судлан үзсэн гадаадын зарим улсын туршлагад үндэслэн шүүгч, шүүхийн ажилтны нэг хэрэг дээр ажиллах дундаж цагийг сүүлийн 3-5 жилийн үзүүлэлтээр гаргаж түүнийг ирэх жил тухайн шүүхэд ирэх хэргийн тооны таамагласан дүнгээр үржүүлэн цалин хөлсний зардлыг тооцох, үүний дээр хэрэг маргаан шийдвэрлэхтэй холбогдох захиргааны бусад зардлуудын дүнг хэргийн тоонд хувааж нэг хэрэгт оногдох захиргааны зардлыг тооцох байдлаар нэг хэрэгт оногдох нийт зардлын дүнг ойролцоогоор гаргаж турших нь зүйтэй байна. Харин нэг хэрэгт оногдох зардалд шүүхийн байрны түрээс, дэд бүтцийн ашиглалтын зардал, байрны засварын зардал, мэдээллийн технологийн шинэчлэлт зэрэг зардлуудыг оруулах эсэхийг тусгайлан судалж үзсэний үндсэн дээр шийдвэрлэх учиртай. Эдгээрээс гадна төсвийн тухайн жилд тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэт олон хохирогч, оролцогчтой, олон хоног үргэлжлэх, олон хоног шүүх танхимын зориулалтаар байр түрээслэх зэргээр төсөвлөсөн зардлаас хэт өндөр зардал гарч болох тохиолдлыг болон тооцоолох боломжгүй бусад байдлаар шүүхийн зардал хэт өсөх тохиолдлыг шийдвэрлэх зорилгоор ШЕЗ-өөс тухайн тохиолдол бүрийг шинжлэн судалсны үндсэн дээр санхүүжилт гаргах эх үүсвэрийг шүүхийн төсөвт тусгайлан тусгах нь зүйтэй.

Түүнчлэн манай улсын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэн болон шилжиж буй эрүүл мэнд, боловсролын салбараас шүүхийн байгууллага нь эрс ялгаатай бөгөөд салбарын онцлогийг нарийвчлан судлах, хэрэг маргааны төрөл, түвшингээр ялган судлах, нэг хэрэгт зарцуулж буй мөнгөн дүнг бүрэн тооцон илэрхийлэх гэх мэт бэлтгэл үе шатанд тодорхой хэмжээний зардал болон хугацааг зайлшгүй зарцуулах юм. Хэдийгээр нэг загвараас нөгөө загварт шилжихэд хууль зүйн хувьд тулгамдаж буй зөрчилтэй зохицуулалт одоогоор байхгүй гэж үзэж болох ч шилжих үйл хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ гарахыг үгүйсгэхгүй гэдгийг боловсрол, эрүүл мэндийн салбарын шилжилтийн туршлагаас харж болохоор байна. Харин нэгэнт хууль эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах тохиолдол гарвал шүүх тус бүрийн өөрийн санг байгуулах, зарцуулалтад хяналт тавих зэрэг шинэ зохицуулалтуудыг оруулахад анхаарал хандуулах боломжтой.

Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэгэнт туршин хэрэгжүүлж эхэлсний дараа хөгжлийн үрт болон дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийг жил бүрээр бус төлөвлөсөн тодорхой үр дүнтэй холбон хэд хэдэн жилээр төлөвлөн боловсруулж, төсвийн тодорхой жил бүрд тохируулан хянах байдлаар төсвийг батлах нь шүүхийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан, тогтвортой, үр дүнтэй, үр ашигтай байдлыг цогцоор нь хангах үндэслэл болно. Ялангуяа зарим шүүхүүд тодорхой үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын зардал батлуулж чадахгүй хэд хэдэн жил болж байгаа өнөөгийн нөхцөлд энэ нь шүүхийн зардлыг жил бүр урьдчилан тооцож, төсөвт тогтмол тусгадаг байх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Үндсэн хуулийн шүүхийн эдийн засгийн баталгааны талаарх суурь зарчмыг тодотгон хуульчилж, төсвийн болон шүүхийн бусад холбогдох хууль тогтоомжийг өөрчлөн найруулах хэрэгцээ шаардлага үүсэж ирснийг шүүхийн төсвийн гүйцэтгэлийн дүнгээс харж болох юм. Иймд дээр дурдсан эрүүл мэнд, боловсролын хуульд шинэчлэн найруулгаар оруулсан төсвийн гүйцэтгэл, үр дүнг тооцох, хүний нөөцийн тогтвортой мэргэшсэн байдлыг хангах чиглэлээр хийгдэж буй төсөвлөлтийг Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.1 дэх заалтад болон 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулснаар сайжруулах боломжтой гэж үзэж доорх судалгааны саналд тусгалаа. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Шүүхийн төсвийг боловсруулах, батлуулах үйл явц өөрөө үндэслэл тооцоотой байж, шүүхийн хүний нөөцийг чадавхжуулах, эдийн засгийн баталгаа хангах нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

СУДАЛГААНЫ САНАЛ

Салбарын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар:

1.1 Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.1-д “Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх” гэснийг “Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлан төсөвлөж Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх” гэж өөрчлөн найруулах.

1.2 Шүүхийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Ерөнхий зөвлөлийн дарга Ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, сум буюу сум дундын, нийслэл, дүүргийн болон дагнасан шүүх, шүүхийн захиргааны бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэсэн хэсэгт “Шүүхийн батлагдсан цалингийн санд багтаан гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал олгох, эдийн засаг, нийгмийн баталгааг хангах, чадавхжуулах төсөвлөлтийг төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж нэмэлт тодруулга оруулах;

Гүйцэтгэл болон үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжихэд дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар:

2.1 Шүүхийн санхүүжилтийн уламжлалт хандлагын сул талыг халж, дэлхийн хөгжингүй улс орнуудын жишгийг харгалзан гүйцэтгэл болон үр дүнд суурилсан шүүхийн санхүүжилт, төсөвлөлтийн загварт шилжих;

2.2 Шүүхийн төсвийг батлахдаа ханшийн уналт, хөдөлмөрийн зах зээл дээрх цалингийн өсөлт, шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын ашиглалт, түрээсийн зардлын өсөлт зэрэг хүчин зүйлсийг тоон үзүүлэлтээр тооцон гаргаж бодитоор харгалзан үздэг байх;

2.3 Шүүхээр шийдвэрлүүлэхээр гаргасан гомдол, нэхэмжлэлийн тоо, шийдвэрлэж дуусаагүй хэргийн тоо, хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаа дундаж хугацаа, нэг хэргийг шийдвэрлэхэд оролцож байгаа шүүгч, шүүхийн ажилтны зарцуулах хугацаа, хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч, орчуулагч оролцуулж байгаа давтамж зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааны онцлогт тохирсон байдлаар ашиглаж дадах, тэдгээрийг статистик болгон хувиргаж шаардлагатай хэмжээний төсвийг боловсруулдаг болох;

2.4 Төсвийн үзүүлэлтүүдийг боловсруулах, түрших, нэвтрүүлэх судалгаа, шинжилгээний зардлыг шүүх бүрээр тусгайлан гаргаж төсөвт батлах, цөөн тооны шүүгчтэй болон цөөн хэрэглэгчтэй шүүхүүдэд тохиромжтой аргачлалыг боловсруулах;

2.4 Шүүгч, шүүгчийн ажилтны илүү цаг ажилласан хөлсийг олгох байдлаар шүүхүүд хоорондын санхүүжилтийн тэгш байдлыг хангах, хүний нөөцийн дутагдалд орох эрсдэлээс сэргийлэх;

2.5 Төсөвлөсөн зардлаас хэт өндөр зардал гарах болон тохиолдлыг шийдвэрлэх зорилгоор зарцуулах эх үүсвэрийг шүүхийн төсөвт тусгайлан тусгах;

2.6 Бусад улсын түршлагаас үзэхэд шүүх нь өөрийн сантай байх, тухайн сангаа жил дамнуулан удирдах боломжийг бий болгох нь шүүхийн хараат бус байдлыг сайруулах нэгэн чухал арга хэмжээ болохыг анхаарах.



СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэл дээрх эх сурвалж:

Алтансүх, Ж. (2017). Монгол Улсын Үндсэн хууль ба шүүхийн эдийн засгийн баталгаа. //Хууль дээдлэх ёс. №2(62). 158-159 дэх тал.

Амарсанаа, Ж, Чимид, Б нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 77-78 дахь тал.

Брент Т. Уайт. Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан Нээлттэй нийгэм форум. Уб., 2008. 14 дэх тал.

Бямбаа, Л. (2016) Шүүхийн эдийн засгийн баталгааг хангах зарим асуудал. //Шүүхийн шинэтгэл. Уб., 219-222 дахь тал.

Доржготов, А. (2016) Монгол Улсын шүүх (Эрх зүйн баримт бичиг). Уб., 236 дахь тал

Дэлхий нийтийн авлигын тайлан 2007 (Шүүхийн тогтолцоо дахь авлига).Транспэрэнси интернэшнл – Монгол. Уб., 2008. 86 дахь тал.

Канад улсын Засгийн газрын албан ёсны веб сайт дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/csjsic/esc-cde/mega/p3.htm>

Лүндэндорж Н., нар. Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь (Бодлогын тойм судалгаа). Нээлттэй нийгэм форум. Уб., 2010. 35-36 дахь тал.

Лүндэндорж, Н. (2022) Монгол Улсын Үндсэн хууль (Шинжлэх ухааны тайлбар). Уб., 761 дэх тал.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан. 2020. 31 дэх тал.

Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээ. (2023). Уб., 98 дахь тал.

Нээлттэй нийгэм форум, Оюуны инноваци ТББ (2022). Шүүхийн индекс 2021. 62 дахь тал.

Оюумаа, В. (2011). Монгол Улсын эрх зүйн шинэтгэл: Олон Улсын байгууллага, гадаад орнууд, олон улсын байгууллагын төслийг дэмжлэг. //Эрдмийн ертөнц (Academiae). Уб., 136-139 дэх тал.

Өлзийсайхан, Б. (2018) Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны гүйцэтгэх үүрэг: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сэдэвт Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан бүтээл. 159 дэх тал.

Үндсэн хууль. 1992

Төрийн хэмнэлтийн тухай хууль. 2022

Төсвийн тухай хууль. 2011 он.

УИХ-ын 2021 оны Хаврын ээлжит чуулганы ХЗБХ-ны 7 дугаар сарын 06-ны өдөр /мягмар гараг/-ийн хуралдаанаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны 2022 оны төсвийг хэлэлцсэн тэмдэглэл.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 7 дугаар сарын 22-ны УИХ-13/7376 дугаар албан бичиг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны төсвийн тухай.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020.

Хууль зүйн судалгааны төв (2016). Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь. (Судалгааны үндсэн тайлан). Уб., 102-103 дахь тал.

Чимид, Б. (2017) Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 265 дахь тал.

ШЕЗ (2018). Шүүхийн захиргааны хөгжил. Уб., 222 дахь тал.

ШЕЗ (2019). Шүүхийн хараат бус байдал. Уб., 9 дэх тал.

ШЕЗ (2023.6 сар). “Шүүх эрх мэдлийн бодлого (зорилтот хөтөлбөр) батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн саналын танилцуулга.

ШЕЗ-ийн 1996 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн “Монгол Улсын шүүхийн 1995 оны төсвийн гүйцэтгэл, 1996 оны төвлөрсөн төсвийг хуваарилах тухай.” Тогтоолын дугаар 13.

ШЕЗ-ийн 1996 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Шүүхийн байгууллагын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх тухай.” Тогтоолын дугаар 50.

ШЕЗ-ийн 1997 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Шүүхийн 1997 оны төсөв хуваарилах тухай.” Тогтоолын дугаар 1.

ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 207 дугаар тогтоолоор “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ыг баталсан.

ШЕЗ-ийн даргын 2016 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 01/915-921 тоот албан бичиг.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн хөтөлбөрийн төсөлд хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ. Хөндлөнгийн судалгаа. Уб., 2023. 85 дахь тал

Шүүх эрх мэдлийн хөгжлийн хөтөлбөрийн төсөлд хийсэн нөлөөллийн үнэлгээ. Хөндлөнгийн судалгаа 2023. Уб., 24 дэх тал

Шүүхийг санхүүжүүлэх тухай Холбооны хуулийн 3 дугаар зүйл.

Шүүхийн архивын ажиллах журам. ШЕЗ-ийн 2016 оны 03 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 56 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан.

Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал (2013).

Шүүх эрх мэдэл. Уб., 2015. №4. 53-55 -р тал.

ШЕЗ-өөс ирүүлсэн албан мэдээлэл

Энхбаатар, Ч., нар. (2016) Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. Уб., 114 -р тал.

Гадаад хэл дээрх эрх сурвалж:

Англи хэл дээрх эх сурвалж:

Alexander Rosselli. Judicial Independence and the Budget: A Taxonomy of Judicial Budgeting Mechanisms. Indiana Journal of Constitutional Design. 2020. Vol.5, Article 2.

Aligning the budget with the Performance-Based Budgeting: lessons from Member States

Allen Schick. Incremental Budgeting in a Decremental Age. Policy Sciences. Vol. 16, No. 1 (Sep., 1983),

ENCJ Report- Funding of the Judiciary 2015-2016 adopted by the General Assembly 3rd June 2016

European Commission for the Efficiency of the Justice, Council of Europe. Case weighting in judicial systems: CEPEJ studies No.28. 2020.

Federal Judicial Center. Judiciaries Worldwide. Budget Process. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://judiciariesworldwide.fjc.gov/budget-process>

Federica Viapiana, A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies, дараах холбоосоор хандаж үзнэ үү (2023.08.23): <https://www.emerald.com/insight/1096-3367.htm>

Federica Viapiana, Marco Fabri. Administration of Justice and Courts' Budget: An Independence and a Managerial Issue. Public Sciences & Policies. vol. V, N.01, 2019, 53-68

Federica Viapiana. Pressure on Judges: How the Budgeting System Can Impact on Judge's Autonomy. 2018. Дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://www.mdpi.com/2075-471X/7/4/38>

International Monetary Fund. From Program to Performance Budgeting: The Challenge for Emerging Market Economies. 2003. IMF working paper WP/03/169. дараах холбоосоор хандаж үзнэ үү (2023-09-02): <https://www.imf.org/external/pubs/ft/wp/2003/wp03169.pdf>

Legislative Analyst's Office. The 2022-23 Budget, Judicial Branch Proposals. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://lao.ca.gov/Publications/Report/4513>

Performance Budgeting in Context: An Analysis of Italian Central Administrations, дараах холбоосоор хандаж үзнэ үү: <https://www.mdpi.com/2076-3387/9/4/79>

René Palacios Garita. Rule of law, budget and management by results of judicial institutions in Latin America: an approximation. 2023.

Review: Performance Measurement: Getting Results. Public Performance & Management Review. Vol. 25, No. 3 (Mar., 2002), pp. 329-335. Дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://economia.uniandes.edu.co/sites/default/files/imagenes/eventos/chapter13.pdf>

Viapiana, F. (2021), "A performance-based budget in the judiciary: allocation of resources and performance variability in first instance courts. An analysis of three case studies", Journal of Public Budgeting, Accounting & Financial Management, Vol. 33 No. 2, pp. 177-206.

White & Case is a global law firm. Upheaval in the Litigation Funding Industry: UK Supreme Court Rules that many Litigation Funding Agreements are Unenforceable. 2022. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.whitecase.com/insight-alert/upheaval-litigation-funding-industry-uk-supreme-court-rules-many-litigation-funding>

Техас мужийн дүүргийн шүүхийн албан ёсны веб хуудас дахь мэдээлэл. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-10): <https://www.txed.uscourts.gov/?q=mega-case-non-capital-case-budgeting>

Орос хэл дээрх эх сурвалж:

Закон о статусе судей в российской федерации. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү (2023-09-11): <https://sudact.ru/law/zakon-rf-ot-26061992-n-3132-1-o/?ysclid=lm688cc0sn123030502>

КонсультантПлюс. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_433298/80cf84afcd2a4bf20929c180df2fb6e8ff8d22930/

ОХУ-ын Москва хот дахь Шүүхийн Тамгын газрын Нягтлан бодох бүртгэл тайлангийн газрын ахлах мэргэжилтэн А.Д. Барциц. Үндэсний шүүхийн тогтолцооны санхүүжилтийг зохион байгуулах, түүнийг боловсронгуй болгох арга зам (2021-2023 онд)

Тасс. Бюджет судебной системы России за 25 лет вырос в 100 раз. 2023. Дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзэх боломжтой (2023-09-11): <https://tass.ru/ekonomika/17280963>

Хятад хэл дээрх эх сурвалж:

Baidu Encyclopedia.
https://baike.baidu.com/item/%E6%B3%95%E5%AE%98%E3%80%81%E6%A3%80%E5%AF%9F%E5%AE%98%E5%8D%95%E7%8B%AC%E8%81%8C%E5%8A%A1%E5%BA%8F%E5%88%97%E6%94%B9%E9%9D%A9%E8%AF%95%E7%82%B9%E6%96%B9%E6%A1%88/18724814?fr=ge_ala

叶珊.(2022).,司法经费保障条款的预算法治实现,中国人民大学学报,2022年第5期,第148页。

叶青, 吕阳. 十三五推行零基预算改革的研究[J].经济研究参考,2016(32):20-29.

廖珏、王肖: 《关于省以下地方法院经费保障制度的调研-基于“省级统管”改革背景下的现状检视和体系重构》, 《中国应用法学》, 2018年第1期, 第59页。Мөн 湛霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第42页。

张坤世：《论我国司法预算制度的完善——以法院为中心的分析》，《财经理论与实践》，2007年第150期，第71-75页。Мөн 湛霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第19页。

张晶.(2022)., 基于平衡计分卡的XS法院全面预算管理研究, 吉林电子科技大学, 第35页。

杨广勇, 杨林. 零基预算改革效果评价与未来推进——以珠海市A区为例[J]. 中央财经大学学报, 2019(1):3-14.

范丽思：《省级统管后法院经费保障机制再造》，载《人民司法》，2021（22）。

湛霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第18页。

湛霞.(2021)., 我国法院组织制度改革完善研究, 南昌大学硕士学位论文文集, 第42-44页。

郑涛.(2021)., 预算法院的法理基础与实现路径——兼评法院经费省级统管改革, 法学, 2021年第9期, 第53页。

黄可、王菁.(2021)., 中国法官薪酬制度改革的审思与完善理路, 江西电力职业技术学院学报, 第34卷第2期, 第145页。

黄可、王菁.(2021)., 中国法官薪酬制度改革的审思与完善理路, 江西电力职业技术学院学报, 第34卷第2期, 第146-147页。

